



Европын Холбоо
санхүүжүүлэв



Food and Agriculture
Organization of the
United Nations



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ “МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТой УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ



Зургийн эх сурвалж: <https://eagle.mn>

ДОРНОГОВЬ АЙМГИЙН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАНГИЙН ШИНЖИЛГЭЭ

Улаанбаатар хот

2024 он

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ “МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

ДОРНОГОВЬ АЙМГИЙН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАНГИЙН ШИНЖИЛГЭЭ

Тайланг боловсруулсан:

А.Мөнх-Оргил, НҮБХХ-ийн зөвлөх

Г.Түвшинтуяа, НҮБХХ-ийн зөвлөх

Хянан тохиолдуулсан:

Н.Мөнхсүх, Сангийн яамны Төрийн сангийн газрын, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга

Энэхүү “Дорноговь аймгийн 2024 оны хагас жилийн хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, үр дүнгийн тайлангийн шинжилгээ” судалгааны тайланг Европын Холбооны санхүүжилттэй “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд боловсруулав. Төслийг Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр нь ядуурал, тэгш бус байдал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шударга бус байдлыг эцэслэх зорилго бүхий НҮБ-ын тэргүүлэх байгууллага юм. Дэлхийн 170 орны түншлэгчид болон мэргэжилтнүүдийн өргөн цар хүрээт хамтын ажиллагааны дүнд эх дэлхий, хүн бүрийн сайн сайхны төлөө хөгжлийн урт хугацааны, цогц шийдлийг бий болгоход улс үндэстнүүдийг дэмжин ажилладаг.

Европын Холбоо бол Европ тивийн 27 тусгаар улсын эдийн засаг, улс төрийн нэгдэл юм. Тус Холбоо нь хүний эрхэм чанар, эрх чөлөө, ардчилал, эрх тэгш байдал, хууль дээдлэх ёс, хүний эрхийг түүний дотор цөөнхийн эрхийг дээдлэх үндсэн үнэт зүйлс дээр тулгуурлан байгуулагджээ. Өнөө цагт Европын Холбоо нь даян дэлхийн хүн бүрд хүртээмжтэй, нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа явуулж байна.

Ерөнхий мэдэгдэл

Тайлангийн агуулга зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд Европын Холбоо болон НҮБХХ-ийн албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй. Энэхүү тайланд ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт Европын Холбоо, НҮБХХ хариуцлага хүлээхгүй болно. НҮБХХ-ийн зөвшөөрөлгүйгээр энэхүү хэвлэлийг худалдах, эсвэл ямар нэгэн ашиг олох хэрэгсэл болгохыг хориглоно.

ISBN: 978-9919-9195-0-4

УДИРТГАЛ

Монгол Улсын Засгийн газар, Европын холбоо, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрөөс Тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулахад чиглэсэн төрийн бодлого, төлөвлөлт болон төсөвлөлтийн уялдааг сайжруулах замаар үр дүн, хөтөлбөрт суурилсан төсөв боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хянах, үнэлэх, тайлагнах тогтолцоо бүхий төсөв, санхүүгийн зохистой удирдлагыг нэвтрүүлэхээр 4 бүрэлдэхүүн хэсэг байгуулан ажиллаж байгаа билээ. Тус төслийн Бодлого, төсвийн уялдааг хангах А бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайлангийн үр дүнг сайжруулах, хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх зорилгоор орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төлөөлөл Дорноговь аймгийн 2024 оны хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв хүрсэн үр дүнгийн тайланд үндэслэн энэхүү шинжилгээг боловсрууллаа.

Дорноговь аймгийн хөтөлбөр, арга хэмжээний 2024 оны хагас жилийн тайланг тус аймгийн 2024 оны 7-8 сард боловсруулж ирүүлсэн тайланд үндэслэн Сангийн яамны Төрийн сангийн эхний 6 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, аймгийн бодлогын баримт бичгийн хагас жилийн урьдчилсан мэдээ тайлан, аймгийн Статистикийн хэлтсийн эрхлэн гаргасан “Статистикийн эмхэтгэл – 2023” болон Засаг даргын тамгын газрын (ЗДТГ) бүрэлдэхүүн байгууллагуудын мэдээлэл, танилцуулга болон аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн албан хаагчидтай хамтран ажиллаж, хянасны үндсэн дээр шинжилсэн.

Шинжилгээний хүрээнд хөтөлбөр, арга хэмжээний тайланд ашиглагдаж буй аргачлал, арга зүйн ашиглалтын өнөөгийн байдал болон Дорноговь аймаг болон бусад аймгуудад нийтлэг ажиглагдсан асуудалд үндэслэн цаашид сайжруулах дүгнэлт саналыг бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарын тайланд ашиглахаар боловсрууллаа.

Судалгаанд статистик тоо, мэдээлэл, тайлбараар хангаж, хамтран ажилласан бүх байгууллага, албан хаагч, үүний дотор Дорноговь аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Статистикийн хэлтэсд талархал илэрхийлье.

Сангийн яамны Төрийн сангийн газар

ТОВЧИЛСОН ҮГС

| | |
|-------|------------------------------------|
| ААН | Аж Ахуйн Нэгж |
| АХЖТ | Аймгийн Хөгжлийн Жилийн Төлөвлөгөө |
| АЗДТГ | Аймгийн Засаг Даргын Тамгын Газар |
| ЖХТ | Жилийн Хөгжлийн Төлөвлөгөө |
| ЗДТГ | Засаг Даргын Тамгын Газар |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| МААХХ | Мал Аж Ахуйг Хөгжүүлэх Хөтөлбөр |
| ҮСХ | Үндэсний Статистикийн Хороо |

АГУУЛГА

| | |
|--|----|
| УДИРТГАЛ..... | 3 |
| АГУУЛГА..... | 5 |
| Зургийн жагсаалт | 7 |
| Хүснэгтийн жагсаалт | 8 |
| ДОРНОГОВЬ АЙМГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА..... | 9 |
| Аймгийн төсвийн шинжилгээ | 9 |
| ҮР ДҮНД СУУРИЛСАН ТӨЛӨВЛӨЛТ | 13 |
| ТӨСВИЙН ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ БОЛОН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН УЯЛДАА | 15 |
| ХӨТӨЛБӨР, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН | 18 |
| 1. Хөтөлбөрийн тайлангийн үр ашиг | 18 |
| 2. Хөтөлбөрийн төсвийн гүйцэтгэл..... | 18 |
| 3. Хөтөлбөрийн хүрэх үр дүн..... | 20 |
| 4. Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт | 21 |
| 5. Үр дүнгийн хамаарал..... | 22 |
| 6. Хөтөлбөр, үр дүнгийн тайлан | 23 |
| Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа - 70105 | 23 |
| Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх – 70709..... | 25 |
| Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага – 70106 | 30 |
| Нээлттэй Дорноговь – 70106..... | 33 |
| Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх – 70426..... | 35 |
| Худалдан авах ажиллагаа – 70418..... | 37 |
| Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага – 70429..... | 38 |
| Хүрээлэн буй орчин..... | 40 |
| Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх– 71413..... | 41 |
| Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт– 71405 | 44 |
| Нийгмийн халамж – 71902 | 45 |
| Эрүүл мэнд..... | 47 |
| Биеийн тамир спорт – 71701 | 48 |
| Соёл урлаг – 71702..... | 51 |
| Сургуулийн өмнөх боловсрол – 71801..... | 53 |
| Ерөнхий боловсрол – 71802 | 55 |
| Мэргэжлийн боловсрол – 71804 | 57 |
| Мал аж ахуйг хөгжүүлэх– 70801 | 58 |
| Гамшгаас хамгаалах– 70708..... | 60 |
| Ахмад настны хөгжил хамгаалал – 72208 | 62 |
| Авто зам – 71101 | 64 |
| Санхүүгийн зах зээлийн зохицуулалт – 70204..... | 65 |

| | |
|---|-----------|
| Нийгмийн тодорхой бүлэгт чиглэсэн хөтөлбөр..... | 66 |
| Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих– 72101..... | 69 |
| Засгийн газрын өрийн үйлчилгээ– 70203 | 72 |
| Хот байгуулалт, тохижилт – 71502 | 73 |
| Хил хамгаалах– 70602 | 74 |
| Зэвсэгт хүчин– 70601 | 76 |
| Ойжуулалт – 71403 | 79 |
| ДҮГНЭЛТ, САНАЛ..... | 82 |
| ХАВСРАЛТ | 85 |

Зургийн жагсаалт

| | |
|---|----|
| Зураг № 1 Дорноговь аймгийн төсвийн динамик, өсөлтийн хувь /тэрбум төгрөгөөр/ | 9 |
| Зураг № 2 Дорноговь аймгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн динамик, тэрбум төгрөгөөр | 10 |
| Зураг № 3 Урсгал ба хөрөнгийн зардлын жилийн өсөлт, хувиар | 11 |
| Зураг № 4 Дорноговь аймгийн батлагдсан төсөв, хөтөлбөрөөр, тэрбум төгрөгөөр..... | 13 |
| Зураг № 5 Хөтөлбөрийн үр ашиг, ангиллаар | 18 |
| Зураг № 6 Зардлын бүтэц | 18 |
| Зураг № 7 Хөтөлбөрийн 2024 оны хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн хувь | 19 |
| Зураг № 8 Хөтөлбөрийн үр дүнгийн үгийн тоо | 20 |
| Зураг № 9 Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл..... | 21 |
| Зураг № 10 Шалгуур үзүүлэлтийн ангилал /хэмжих нэгжээр/..... | 21 |
| Зураг № 11 Хөтөлбөрийн үр дүн, төсвийн гүйцэтгэл, үр ашгийн хамаарал | 22 |
| Зураг № 12 Дорноговь аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн тоо..... | 23 |
| Зураг № 13 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа хөтөлбөрийн биелэлт | 24 |
| Зураг № 14 Гэмт хэрэг, төрлөөр, эзлэх хувиар | 25 |
| Зураг № 15 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн биелэлт | 30 |
| Зураг № 16 Дорноговь аймгийн тамгын газрын бүтэц, албан хаагчийн тоо..... | 30 |
| Зураг № 17 Орон нутгийн гүйцэтгэх засаглал хөтөлбөрийн 2024 оны батлагдсан төсвийн бүтэц, тэрбум төгрөгөөр..... | 32 |
| Зураг № 18 Орон нутгийн гүйцэтгэх засаглал, удирдлага хөтөлбөрийн биелэлт | 33 |
| Зураг № 19 Ашиглалтад оруулсан орон сууц, хаалны тоогоор, оны дүнгээр..... | 34 |
| Зураг № 20 Нээлттэй дорноговь хөтөлбөрийн биелэлт..... | 35 |
| Зураг № 21 Аймгийн нийт төрийн болон орон нутгийн өмчийн бүтэц..... | 35 |
| Зураг № 22 Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн биелэлт..... | 37 |
| Зураг № 23 Худалдан авах ажиллагааны хөтөлбөрийн биелэлт | 38 |
| Зураг № 24 Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдлийн удирдлагын хөтөлбөрийн биелэлт..... | 39 |
| Зураг № 25 Газрын мэдээлэл, ангиллаар | 40 |
| Зураг № 26 Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн биелэлт..... | 41 |
| Зураг № 27 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хөтөлбөрийн бүтэц, зориулалтаар..... | 42 |
| Зураг № 28 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хөтөлбөрийн биелэлт..... | 43 |
| Зураг № 29 Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт хөтөлбөрийн биелэлт..... | 45 |
| Зураг № 30 Нийгмийн халамжийн сангийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо, 2023 он..... | 45 |
| Зураг № 31 Нийгмийн халамж хөтөлбөрийн биелэлт | 46 |
| Зураг № 32 Эрүүл мэндийн салбарын зарим үзүүлэлт..... | 47 |
| Зураг № 33 Эрүүл мэндийн хөтөлбөрийн биелэлт | 48 |
| Зураг № 34 Аймгийн эхний хагас жилийн зохион байгуулагдсан арга хэмжээнд хамрагдагчид..... | 49 |
| Зураг № 35 Биеийн тамирын хөтөлбөрийн биелэлт | 50 |
| Зураг № 36 Соёл урлагийн салбарын хүртээмж, үйлчлүүлэгчийн тоогоор | 51 |
| Зураг № 37 Соёл урлаг хөтөлбөрийн биелэлт | 53 |
| Зураг № 38 Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн тоо..... | 53 |
| Зураг № 39 Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн биелэлт..... | 54 |
| Зураг № 40 Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид, хувиар..... | 55 |
| Зураг № 41 Ерөнхий боловсрол хөтөлбөр | 56 |
| Зураг № 42 Мэргэжлийн боловсрол хөтөлбөр | 58 |
| Зураг № 43 Мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрийн биелэлт | 60 |
| Зураг № 44 Сүүлийн хоёр жилд тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл..... | 60 |
| Зураг № 45 Гамшгаас хамгаалах хөтөлбөрийн биелэлт | 61 |
| Зураг № 46 АХЖТ-нд туссан ахмад настны хөгжил хамгаалалын арга хэмжээ | 62 |
| Зураг № 47 Ахмад настны хөгжил хамгаалал хөтөлбөрийн биелэлт | 64 |
| Зураг № 48 Авто зам хөтөлбөрийн биелэлт | 65 |
| Зураг № 49 Санхүүгийн зах зээлийн зохицуулалт хөтөлбөрийн биелэлт | 66 |

| | |
|---|----|
| Зураг № 50 Суурин хүн ам, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар, 2022,2023 | 66 |
| Зураг № 51 Нийгмийн тодорхой бүлэгт чиглэсэн хөтөлбөрийн биелэлт..... | 69 |
| Зураг № 52 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн биелэлт..... | 72 |
| Зураг № 53 Засгийн газрын өрийн үйлчилгээний хөтөлбөрийн биелэлт | 73 |
| Зураг № 54 Хот байгуулалт, тохижилт хөтөлбөрийн биелэлт | 74 |
| Зураг № 55 Хил хамгаалах хөтөлбөрийн биелэлт | 76 |
| Зураг № 56 Зэвсэгт хүчний хөтөлбөрийн биелэлт | 78 |
| Зураг № 57 Ойжуулалт, түүний хувь, жил бүрийн эцэст..... | 79 |
| зураг № 58 ойжуулалт хөтөлбөрийн биелэлт | 81 |

Хүснэгтийн жагсаалт

| | |
|---|----|
| Хүснэгт № 1 Дорноговь аймгийн төсвийн хөтөлбөрийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй харьцуулсан судалгаа..... | 15 |
| Хүснэгт № 2 Биеийн тамирын сорилын мэдээлэл | 49 |
| Хүснэгт № 3 Дорноговь аймгийн 2024 оны эхний хагас жилийн хөтөлбөр, үр дүнгийн тайлан, хөтөлбөрөөр, сая төгрөгөөр | 85 |

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Дорноговь аймаг нь Монгол Улсын зүүн аймаг бөгөөд 1931 онд байгуулагдсан. 2023 оны эцсээр 14 сум, 64 баг, 71517 хүн амтай бөгөөд олон хүн амын тоо хурдацтай нэмэгдэж байгаа юм. Аймгийн төв Сайншанд сум нь улсын нийслэл Улаанбаатар хотоос 450км-т оршдог. тус аймагт 2023 оны эцсийн байдлаар 21.5 мянган өрхийн 71517 хүн ам оршин суудаг бөгөөд 1 кв.км нутаг дэвсгэрт 0.65 хүн ногдож байна. Тэдний 60.6 хувь нь аймгийн төвд, 15.2 хувь нь сумын төвд, 24.2 хувь нь хөдөөд оршин суудаг. Дорноговь аймаг Монгол орны зүүн өмнөд хязгаарт Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар аймгуудтай хил залган оршдог. БНХАУ-тай 600 км-урт газраар хиллэдэг. Хойд, урд хоёр гүрнийг холбосон, төвийн бүсийн хөгжлийн гол тэнхлэг болсон төмөр зам дайран өнгөрдөг. Энэ замын дагуу тус аймгийн бүх сумын 42.8 хувь, хүн амын 61 хувь нь оршин сууж байна.

Статистик тоон мэдээлэл

| | |
|---|--------------------|
| Нутаг дэвсгэр: | 109,5 мянган кв км |
| Засаг захиргаа: | 14 сум, 65 багтай |
| Сумдын тоо: | 14 |
| Хүн ам: | 71517 / 2023 / |
| Ажилгүйдлийн түвшин: | 2.7% |
| Нэг хүнд ногдох ДНБ (оны үнээр, мянган төгрөг): | 8,336.5 |
| Нийт өрх: | 21543 / 2023 он / |


Дорноговь аймаг нь Аймгуудын өрсөлдөх чадварын үнэлгээгээр¹ нийт 21 аймгаас 2 дугаар байрт эрэмбэлэгдэж байгаа Эдийн засаг, дэд бүтэц, засаглалын үр ашгаар аймгуудын дунджаар өндөр, бизнесийн үр ашгаар бусад аймгийн түвшинд үнэлэгддэг харьцангуй хөгжил сайтай аймгийн нэгд тооцогдож байна. Тус аймгийн хувьд сүүлийн жилүүдэд эдийн засаг, хүн амын үзүүлэлтийг сайжирч байгаа нь төрийн үйлчилгээ, төсөв

санхүүгийн үйл ажиллагааны үр ашигтай хэрхэн уялдаж байгааг судлах нь зайлшгүй шаардлагатай юм.

Аймгийн төсвийн шинжилгээ

Дорноговь аймгийн төсөв, санхүүгийн байдал нь аймгийн эдийн засгийн хөгжлийн чухал хэсэг бөгөөд орон нутгийн амьдралд нөлөөлөх олон асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд (2019-2023 он) Дорноговь аймгийн төсөв нь улсын эдийн засгийн байдал, татварын орлого, ашигт малтмалын экспортын орлого, төрийн бодлогоос хамаарч өөрчлөгдөж ирсэн.

Зураг № 1 Дорноговь аймгийн төсвийн динамик, өсөлтийн хувь /ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР/



Дорноговь аймгийн нийт төсөв сүүлийн 10 жилийн хугацаанд 8 дахин өссөн бөгөөд үүнд 2019, 2021 онуудад төсвийн хэмжээ буурч, бусад онуудад харилцан адилгүй хувь хэмжээгээр өссөн байна². Төсвийн хэмжээ буурахад 2019 оны эдийн засгийн хямрал, 2021 оны Ковид-19 цар тахал зэрэг улс орны төсөв, эдийн засагт нөлөөлсөн хүчин зүйлс томоохон нөлөө үзүүлсэн. Төсвийн


¹ Монгол Улс: Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан 2023.

² Эх сурвалж: Сангийн яам. Төрийн сангийн газар. Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтэс. Монгол Улсын 2024 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан

хэмжээ 100 дээш хувиар өссөн онуудын хувьд 2018, 2020 оны Монгол Улсын эдийн засгийн өсөлт, 2023-2024 онуудад орон нутгийн бие даасан байдлыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлсэн хууль эрх зүй, татварын тогтолцооны томоохон өөрчлөлтүүд нөлөөлсөн байна. Цаашид Дорноговь аймгийн хувьд төсвийн хэмжээг зохистой хэмжээнд тогтмол хадгалах, төсвийг үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр анхаарч ажиллах шаардлагатай.

Төсөв санхүүгийн үр ашгийг нарийвчлан судлах зорилгоор төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулан судалсан. Дорноговь аймгийн хувьд 2014-2020 оныг хүртэл төсвийн гүйцэтгэлийн хувь тогтмол 88 болон түүнээс дээш хувьтай байсан. Сүүлийн 3 жилийн хугацаанд төсвийн гүйцэтгэлийн хувь 80 хувь хүрэхгүй, 2023 онд 68 хувьтай байгаа нь төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл уялдаагүй, үр ашиг багасаж байгааг харуулж байна. Үүнд төсвийн урьдчилан тооцох боломжгүй нөхцөл, шинээр хэрэгжүүлж буй татварын тогтолцооны өөрчлөлт нөлөөлж байгаа боловч төсвийн гүйцэтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлж, санхүүгийн нөөцийн ашиглалтыг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай³.

ЗУРАГ № 2 Дорноговь аймгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн динамик, тэрбум төгрөгөөр




Дорноговь аймгийн төсвийн орлогын гол эх үүсвэрүүд нь дараах хүчин зүйлсээс бүрдэнэ:

- Татварын орлого: Аймгийн орлогын томоохон хэсгийг татварын орлого бүрдүүлдэг. Үүнд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үл хөдлөх хөрөнгийн татвар зэрэг орно. Сүүлийн 5 жилийн хугацаанд эдийн засгийн өсөлт болон ашигт малтмалын салбарын өсөлттэй уялдан татварын орлого нэмэгдсэн байна.
- Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн орлого: Дорноговь аймаг нь ашигт малтмалын салбарт өндөр ач холбогдолтой бөгөөд тус аймагт уул уурхайн компаниуд үйл ажиллагаа явуулдаг. Ашигт малтмалын салбарын өсөлтөөс хамааран аймгийн төсвийн орлогын хэсэг нэмэгдсэн.
- Тусламж, дэмжлэгийн сангууд: Орон нутгийн төсөвт улсын төсвөөс болон олон улсын байгууллагуудын санхүүгийн дэмжлэг ихээхэн үүрэг гүйцэтгэдэг. Төрийн сан болон бусад сангуудаас төсвийн санхүүжилт хийгддэг бөгөөд энэ нь аймгийн хөгжлийг дэмжих, дэд бүтэц сайжруулах зэрэгт чиглэсэн байдаг.

³ Эх сурвалж: Сангийн яам. Төрийн сангийн газар. Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтэс. Монгол Улсын 2024 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан

ЗУРАГ № 3 УРСГАЛ БА ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫН ЖИЛИЙН ӨСӨЛТ, ХУВИАР



Дорноговь аймгийн нийт төсвийн дунджаар 75 хувь нь урсгал зардал, 25 хувь нь хөрөнгийн зардалд зарцуулж байсан боловч сүүлийн 3 жилд хөрөнгө оруулалтын зардлын хэмжээ орон нутгийн бие даасан байдлыг дэмжсэн эрх зүйн шинэчлэл, улс орны хөгжлийн бодлоготой уялдан өссөнөөр хөрөнгө оруулалтын эзлэх хувь хэмжээ сүүлийн 3 жилд тогтмол 30 болон түүнээс дээш хувьтай байна⁴. Үүнд:

- 2019 онд Дорноговь аймгийн төсөв нь 68 тэрбум төгрөг байсан бөгөөд голчлон дэд бүтцийн төсөл хөтөлбөрүүд, боловсрол, эрүүл мэндийн салбарт зарцуулагдсан. Мөн энэ онд татварын орлого өсөж, ашигт малтмалын экспортын орлого нэмэгдсэн байна.
- 2020 онд COVID-19 цар тахлын нөлөөгөөр эдийн засгийн хүндрэлүүд гарсан. Аймгийн төсөвт тодотгол хийж, 72 тэрбум төгрөг-ийг баталсан бөгөөд цар тахлын эсрэг арга хэмжээнд ихээхэн хөрөнгө зарцуулсан. Мөн нийгмийн халамжийн зардлууд өссөн.
- 2021 онд төсвийн орлого нэмэгдэж, 76 тэрбум төгрөг-ийн төсөв батлагдсан. Татварын орлого, уул уурхайн экспортын орлого нэмэгдсэн бөгөөд боловсрол, эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт үргэлжилсэн.
- 2022 онд аймгийн төсөв 81 тэрбум төгрөг болж нэмэгдсэн. Энэ онд уул уурхайн салбарын орлого огцом нэмэгдэж, орон нутгийн эдийн засагт эерэг нөлөө үзүүлсэн. Төсвийн зарцуулалтын гол чиглэл нь дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний салбар байсан.
- 2023 онд аймгийн төсөв 85 тэрбум төгрөг болж, өмнөх жилүүдээсээ нэмэгдсэн. Энэ онд орон нутгийн дэд бүтцийг сайжруулах төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, зам, цахилгаан, усны дэд бүтцийг өргөжүүлсэн. Мөн нийгмийн халамж, боловсрол, эрүүл мэндийн салбарт ихээхэн хөрөнгө оруулалт хийгдсэн.

Дорноговь аймгийн төсвийн зарцуулалт нь аймгийн иргэдийн амьдрах орчин, дэд бүтцийг сайжруулахад ихээхэн төвлөрсөн. Сүүлийн 5 жилийн хугацаанд төсвийн хөрөнгийг дараах чиглэлүүдэд зарцуулсан байна:

- Боловсролын салбар: Аймгийн төсвийн тодорхой хэсэг нь боловсролын салбарт зарцуулагдсан. Шинэ сургууль, цэцэрлэг барих, сургалтын орчныг сайжруулахад зориулсан хөрөнгө оруулалт нэмэгдсэн. Үүнээс гадна багш, ажилтнуудын цалингийн санхүүжилт, сургалтын материал худалдан авах зэрэг зардлууд багтдаг.
- Эрүүл мэндийн салбар: Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарсан төсвийн хөрөнгө оруулалтууд хийгдсэн. Аймгийн төв болон сумдад эмнэлгийн тоног төхөөрөмжийг шинэчлэн, хүний нөөцийн чадавхыг сайжруулахад төсөвлөлт хийгдэж, COVID-19 цар тахлын үеэр тусгай арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.
- Дэд бүтэц: Зам, цахилгаан, цэвэр усны дэд бүтцийг сайжруулах төсөл хөтөлбөрүүд нь орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих гол чиглэлүүдийн нэг байсан. Сүүлийн жилүүдэд аймгийн авто замын сүлжээг өргөжүүлж, сумдын дэд бүтцийг сайжруулахад ихээхэн анхаарч, хөрөнгө зарцуулсан байна.

⁴ Эх сурвалж: Сангийн яам. Төрийн сангийн газар. Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтэс. Монгол Улсын 2024 оны хагас жилийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан

- Нийгмийн халамжийн үйлчилгээ: Хүн амын ядуурал, ажилгүйдлийг бууруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих зорилгоор нийгмийн халамжийн зардлуудыг нэмэгдүүлсэн. Мөн тэтгэвэр, тэтгэмж олгох, гэр бүл, хүүхдийг хамгаалах чиглэлээр төсвөөс хөрөнгө гаргаж ирсэн.


Дорноговь аймаг нь улсад татаас өгдөг буюу төсвийн хувьд бие даасан 6 аймгийн нэг юм. Эдийн засгийн өсөлтөө хадгалахын тулд санхүүгийн бодлогоо үр ашигтай хэрэгжүүлж ирсэн. Уул уурхайн салбарын орлогоос хамааран аймгийн төсөв өсөлттэй явж ирсэн ч, тогтвортой хөгжлийг хангахын тулд олон салбарын хөгжилд анхаарах шаардлагатай байна.

Цаашид дэд бүтцийг хөгжүүлэх, ажил эрхлэлт, боловсролын чанарыг сайжруулахад ихээхэн анхаарал хандуулах нь аймгийн хөгжлийг дэмжих гол бодлогын чиглэл байх болно. Мөн байгаль орчин, ногоон хөгжлийн чиглэлээр төсвийн зарцуулалтыг нэмэгдүүлэх нь эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэх юм.

ҮР ДҮНД СУУРИЛСАН ТӨЛӨВЛӨЛТ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн хуулийн дагуу тухайн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь аймгийн жилийн төсвийг хэлэлцэн, тогтоолоор батлах бөгөөд тус тогтоолын нэгдүгээр хавсралтаар тухайн жилийн төсвийн хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтийг батална. Дорноговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 15/08 тоот “Дорноговь аймгийн 2024 оны төсөв батлах тухай” тогтоолын дагуу төсвийг баталсан байна. Тус тогтоолын 1 дүгээр хавсралтаар 29 хөтөлбөр, 29 хөтөлбөрийн хүрэх үр дүн, 29 шалгуур үзүүлэлттэй батлагдсан.

ЗУРАГ № 4 ДОРНОГОВЬ АЙМГИЙН БАТЛАГДСАН ТӨСӨВ, ХӨТӨЛБӨРӨӨР, ТЭРБҮМ ТӨГРӨГӨӨР



Тайлбар: Бусад хөтөлбөрийн төсвийн хуваарилалтыг тод харьцуулах зорилгоор “орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөр”-ийг тусад нь оруулав.

Аймгийн нийт төсвийн 57 хувь нь орон нутгийн гүйцэтгэх засаглал хөтөлбөрийн хүрээнд төрийн захиргаа, үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардал болон аймагт хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний төсвүүд эзэлж байна⁵. Мөн орон нутгийн төсвийн харьцангуй өндөр буюу 10 хувийг хот байгуулалт, тохижуулалт хөтөлбөр, 12 хувийг хуулийн дагуу орон нутгийн өмчит⁶ боловсрол, эрүүл мэнд, соёл, биеийн тамирын байгууллагуудын ашиглалтын зардал болон тухайн салбаруудын хөрөнгө оруулалтын зардал тус тус эзэлж байна.

⁵ Эх сурвалж: Сангийн яам. Төрийн сангийн газар. Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтэс. Монгол Улсын 2024 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан

⁶ Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/ 20.1.18.төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар;

Нийт төсвийн 49 хувь нь буюу 106.9 тэрбум төгрөгийн төсөв 2024 оны эхний хагасд хуваарилагдсан бөгөөд үүнд “Зэвсэгт хүчний үйл ажиллагаа”, “Хил хамгаалах “ хөтөлбөрийн төсөв эхний хагас жилд бүрэн хуваарилагдсан бол “Санхүүгийн зах зээлийн зохицуулалт” хөтөлбөр жилийн эхний хагас төсөвгүй, бусад хөтөлбөрийн нийт төсвийн 34-85 хувь нь хуваарилагдсан. Батлагдсан төсвийн хуваарилалт саруудад ялгаатай байгаа нь тухайн хөтөлбөрийн хэрэгжих хугацаа, үйл ажиллагаатай нягт уялдаатай байдаг тул цаашид зорилтот түвшиний үр дүнг хагас жил, улирлаар тооцох боломжтой уян хатан болгох нь бодлого, төсвийн уялдааг хангах нэг хэрэгсэл болох юм.

ТӨСВИЙН ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ БОЛОН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН УЯЛДАА

Дорноговь аймгийн төсөв, санхүүгийн бодлого төлөвлөлт нь Төсвийн тухай хууль, Засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуулийг үндэслэл болгон холбогдох бусад хууль эрх зүйн хүрээнд орон нутгийн хуулиар заасан эрх үүрэг, бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх санхүүгийн суурь, хөшүүрэг болон төлөвлөж, хэрэгжүүлэн, тайлагнаж байна. Иймд төсвийн санхүүжилт болон бодлогын уялдааны үр дүнг холбох үндсэн хэрэглэгдэхүүн нь болж байгаа учраас хөтөлбөр, үр дүнгийн тайланг, бодлогын үндсэн баримт бичгийн биелэлтэй уялдуулан судалж үзэх нь зайлшгүй юм.

Дорноговь аймагт тайлант хугацаанд Дорноговь аймгийн 2021-2025 оны стратеги төлөвлөгөө, Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа – 2” 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөө – 2023, Нээлттэй Дорноговь зэрэг дунд болон богино хугацааны, аймгийн бүх салбарыг хамарсан бодлогын баримт бичгүүд, салбарын 16 дэд хөтөлбөр хэрэгжиж байна. Үүнээс Дорноговь аймгийн 2024 оны батлагдсан төсвийн дагуу нийт 29 хөтөлбөрийн дагуу шалгуур үзүүлэлтийн аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний уялдааг судалсан.

Аймгийн хөгжлийн үндсэн баримт бичиг болох хөгжлийн төлөвлөгөөнд төрийн бүх чиглэлийн үйлчилгээний чиг үүргүүд дангаар болон нэгтгэсэн байдлаар тусгагдсан байна. Үүнд төсвийн хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтээр болон хөтөлбөрийн нэрээр шууд тусгагдаагүй 5 хөтөлбөр /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, Төрийн өмчийг хэрэгжүүлэх, Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдлийн удирдлага, Санхүүгийн зах зээлийн зохицуулалт, Засгийн газрын өрийн үйлчилгээ/ хөтөлбөрийн хамрах цар хүрээ, нэр ижил тодорхойлогдсон боловч шалгуур үзүүлэлт ялгаатай байдлаар тодорхойлогдсон 5 хөтөлбөр /Эрүүл мэнд, Мэргэжлийн боловсрол, Мал аж ахуйг хөгжүүлэх, Гамигаас хамгаалах, Ойжуулалт/ байна. Аймгийн ИТХ-аар баталсан төсөвт “Нээлттэй Дорноговь” хөтөлбөрийг “Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага” хөтөлбөрөөс салгаж үнэлсэн тул тухайн хөтөлбөрийг нэмж тооцсон.

Хүснэгт № 1 Дорноговь аймгийн төсвийн хөтөлбөрийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

| Дд | 2024 оны хөтөлбөр /төсөвт батлагдсанаар | Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт | Жилийн хөгжлийн төлөвлөгөө |
|----|--|--|---|
| 1. | Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа | ИТХ-ын шийдвэрийн хэрэгжилт | Тусаагүй |
| 2. | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх | Гэмт хэрэг, зөрчил | 169-174 Гэмт хэргийн илрүүлэлт, Хэсэгчилсэн арга хэмжээ г.м |
| 3. | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага | Иргэдийн сэтгэл ханамж | Тусаагүй |
| 4. | Төрийн өмчийг хэрэгжүүлэх | Орон нутгийн өмчийн байгууллагын өмч хөрөнгийн ашиглалтын гэрээний хэрэгжилт | Тусаагүй |
| 5. | Худалдан авах ажиллагаа | Төлөвлөгөөний хэрэгжилт | 269-Төлөвлөгөөний хэрэгжилт |
| 6. | Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдлийн удирдлага | Илрүүлсэн зөрчил | Тусаагүй |
| 7. | Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага | Зохион байгуулсан арга хэмжээ | 201-205, 211-222 Зохион байгуулсан арга хэмжээ г.м |
| 8. | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | Зохион байгуулсан арга хэмжээ | 201-205, 211-222 Зохион байгуулсан арга хэмжээ г.м |

| | | | |
|-----|---|--|--|
| 9. | Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт | Тусгай хамгаалтанд авсан газрын хэмжээ | 209-210 Тусгай хамгаалалтад авсан газрын хэмжээ, Зохион байгуулсан арга хэмжээ |
| 10. | Нийгмийн халамж | Нийгмийн үйлчилгээнд халамжийн хамрагдсан иргэд | 143-155 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэд |
| 11. | Эрүүл мэнд | Дундаж наслалт | 42-73 Сургалт, эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан ахмад, Өвчлөлийн бууралт г.м |
| 12. | Биеийн тамир, спорт | Спортоор хичээллэгсэд | 74-88 Биеийн тамир, спортоор хичээллэгчид, Хамтран ажилласан спортын холбоо, клубын тоо г.м |
| 13. | Соёл урлаг | Иргэдэд хүргэсэн соёл урлагийн арга хэмжээ | 113-116, 96-112 Соёлын байгууллагаар үйлчлүүлсэн хүн, Уран бүтээл |
| 14. | Сургуулийн өмнөх боловсрол | СӨБ-н хамран сургалтын цэвэр жин | 1-9 Сургуулийн өмнөх боловсролын хамрагдалт г.м |
| 15. | Ерөнхий боловсрол | Гүйцэтгэлийн хувь | 10-38 ЕБ-олгох үйл ажиллагаанд хамрагдсан хүүхэд, Гүйцэтгэлийн үнэлгээний ахиц |
| 16. | Мэргэжлийн боловсрол | Политехникийн коллежид суралцагчид | 39 Ур чадварын уралдаан |
| 17. | Мал аж ахуйг хөгжүүлэх | Вакцинд хамрагдсан мал | 291 Хийгдсэн хяналт, хүргүүлсэн зөвлөмж |
| 18. | Гамшгаас хамгаалах | Гамшиг ослын бууралт | 180 Зохион байгуулсан арга хэмжээ |
| 19. | Ахмад настны хөгжил, хамгаалал | Ахмад настанд чиглэн зохион байгуулсан арга хэмжээ | 136-142 Гериатр эмч, сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагдсан ахмад, Асрамжийн үйлчилгээнд хамрагдсан ахмад г.м |
| 20. | Автозам | Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ | 175-179, 198 Шинээр бий болсон автозам |
| 21. | Санхүүгийн зах зээлийн зохицуулалт | Нөөцийн махны хэмжээ | Тусаагүй |
| 22. | Нийгмийн тодорхой бүлэгт хөтөлбөр чиглэлсэн | Зохион байгуулсан арга хэмжээ | 117-142 117 Хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэгтэй тэмцэх 118 үүхэд хамгааллын үйл ажиллагаа явуулах 119 Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа болон эрх нь зөрчигдсөн хүүхэд, гэр бүлд хамгаалах, нөхөн сэргээх хариу үйлчилгээ үзүүлэх 120 Хүүхэд хөгжлийн үйлчилгээ үзүүлэх 121 Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх 122 Хүүхдийн өмнө үүрэг хүлээгч бүх шатны байгууллага, албан тушаалтнуудыг чадавхжуулах сургалтад хамруулах 127 Гэр бүлийн боловсролын үйлчилгээ үзүүлэх 129 Үр хүүхдээ эсэн мэнд өсгөн бойжуулсан гэр бүлийн туршлагыг нийтэд сурталчлах 130 Залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх 134 Архины хамааралтай гэр бүлд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах 135 Хүчирхийллийн хохирогч иргэдэд Түр хамгаалах байраар үйлчилгээ үзүүлэх |
| 23. | Ойжуулалт | Тэрбум мод хөтөлбөрийн хэрэгжилт | 219-222 Зөвлөх үйлчилгээнд хамрагдсан иргэн, ААН г.м |
| 24. | Нээлттэй Дорноговь | Шилжин ирсэн иргэд | 278-281 Шилжин сууршигчдад үзүүлж буй санхүүгийн дэмжлэг г.м |
| 25. | Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих | Зорилтот хөтөлбөрийн хэрэгжилт | 303-305 Зохион байгуулсан эвент арга хэмжээ |
| 26. | Засгийн газрын өрийн үйлчилгээ | Өр барагдуулалт | Тусаагүй |
| 27. | Хот байгуулалт, тохижилт | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | 194-198 Ажлын гүйцэтгэл, Нэмэгдсэн талбайн хэмжээ |

| | | | |
|-----|------------------------------|---|---------------------------------------|
| 28. | Хил хамгаалах | Хилийн цэргийн ангиудыг дэмжсэн ажил, арга хэмжээ | 275-276 Дэмжлэг |
| 29. | Зэвсэгт хүчний үйл ажиллагаа | Зэвсэгт хүчний ангиудыг дэмжсэн ажил, арга хэмжээ | 251-254 Зохион байгуулсан арга хэмжээ |

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд дараах салбарын үр дүнгүүд төсвийн хөтөлбөртэй шууд тусаж, хамааруулагүй бөгөөд үүнд (1) зарим салбарын чиг үүрэг шууд улсын төсвөөс санхүүжиж хэрэгждэг, төрийн захиргааны төв байгууллагын шууд удирдлага доор хэрэгжүүлдэг арга хэмжээ байх, (2) зарим хөтөлбөр, арга хэмжээ нь төсвийн хөтөлбөртэй шууд нийцэхгүй боловч дэмжих, харилцан уялдаатай байна. Үүнд:

- Салбарын үр дүн 7.1: Авлигын үзүүлэлтээр 10 байр урагшилна.
- Салбарын үр дүн 10.1: Хариуцлагатай уул уурхайн нийт үйлдвэрлэлийг 57.2 хувиар нэмэгдүүлнэ.
- Салбарын үр дүн 10.2: Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг 6 хувиар нэмэгдүүлнэ.
- Салбарын үр дүн: 10.3: Стандартын шаардлага хангасан хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг 10 хувиар нэмэгдүүлнэ.
- Салбарын үр дүн 10.4: Гадаад жуулчдын тоог 0.003 саяд хүргэнэ.
- Салбарын үр дүн 10.5: Худалдааны салбарын нэмүү өртгийг 20.8 хувиар нэмэгдүүлнэ.
- Салбарын үр дүн 10.7: Мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн үзүүлэлтийг 1 хувиар нэмэгдүүлнэ.
- Салбарын үр дүн 10.8: Эрчим хүчний сэргэлт

Цаашид төсвийн хөтөлбөрийг боловсруулахдаа улс орны болон орон нутгийн урт, дунд болон богино хугацааны бодлогын аливаа баримт бичигтэй уялдуулах, шалгуур үзүүлэлтийг төстэй буюу ижил байдлаар сонгох нь цаашдаа бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг үнэлэх, баталгаатай, нэг эх сурвалж дээр үнэлэн шалгуур үзүүлэлтийг хэмжих болон ажлын ачаалал, цаг хугацааг хэмнэх боломжийг бүрдүүлнэ.

Судалгааны хэсгийн дараагийн бүлэгт төсвийн хөтөлбөр тус бүрийн үнэлгээнд Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээний ижил төстэй болон холбогдох хэсгийг нарийвчлан оруулсан.


ХӨТӨЛБӨР, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дорноговь аймгийн хөтөлбөр, арга хэмжээний 2024 оны хагас жилийн тайланг тус аймгийн 2024 оны 7-8 сард боловсруулж ирүүлсэн тайлан дээр үндэслэн Сангийн яамны Төрийн сангийн 6 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, аймгийн бодлогын баримт бичгийн хагас жилийн урьдчилсан мэдээ тайлан, Дорноговь аймгийн Статистикийн хэлтсийн эрхлэн гаргасан “Статистикийн эмхэтгэл – 2023” болон Засаг даргын тамгын газрын бүрэлдэхүүн байгууллагуудын мэдээлэл, танилцуулга болон Санхүү, төрийн сангийн хэлтсийн албан хаагчидтай хамтран ажиллаж, хянасны үндсэн дээр боловсрууллаа.

1. Хөтөлбөрийн тайлангийн үр ашиг

Дорноговь аймгийн 2024 оны хагас жилийн тайланд нийт 29 хөтөлбөрийн гүйцэтгэлийг тайлагнасан бөгөөд хөтөлбөр тус бүр нэг нэг хөтөлбөрийн хүрэх үр дүн болон шалгуур үзүүлэлттэй. Орон нутгийн төсвийн гүйцэтгэлээр нийт 35 хөтөлбөрийн дагуу төсөв батлагдсан бөгөөд үүнээс “Нийгмийн тодорхой бүлэгт чиглэсэн хөтөлбөр” -ийн хүрээнд төсвийн 6 хөтөлбөр, “Эрүүл мэнд” хөтөлбөрт төсвийн 2 хөтөлбөр, “Хүрээлэн буй орчин” хөтөлбөрт төсвийн 2 хөтөлбөр тус тус хамаарсан байна. Цаашид, хөтөлбөр үр дүнгийн тайланг дээрх 29 хөтөлбөрийн дагуу судаллаа. Дээрх хөтөлбөрүүдийг үр ашгийн хувьд ангилахад “Үр ашиггүй буюу сайжруулах шаардлагатай” ангилалд 0-ээс бага хувийн гүйцэтгэлтэй 11 хөтөлбөр, “Үр ашигтай” ангилалд 1-ээс дээш хувийн хувийн гүйцэтгэлтэй 18 хөтөлбөр байна. Нийт хөтөлбөрийн 38 хувь нь үр ашиггүй байгаа нь тайланг хагас жилийн хугацаагаар тасалбар болгон тайлагнаж буйтай холбоотой хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагаа удааширсан, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг эхний саруудад төсөв хуваарилсан ч зарцуулж амжаагүй зэрэгтэй холбоотой. Мөн үр ашиг тооцоход сөргөөр нөлөөлсөн томоохон хүчин зүйл нь төсвийн хэмжээг хагас жилээр хуваарилж болох боловч хөтөлбөрийн хүрэх үр дүнг хагас жилээр шууд хуваарилах боломжгүйгээс хөтөлбөрийн хүрэх түвшин бага гарч байгаатай шууд холбоотой юм.

ЗУРАГ № 5 ХӨТӨЛБӨРИЙН ҮР АШИГ, АНГИЛЛААР



2. Хөтөлбөрийн төсвийн гүйцэтгэл

Дорноговь аймгийн 2024 онд нийт 35 хөтөлбөрийн хүрээнд нийт 217.4 тэрбум төгрөг батлагдснаас эхний 6 сард 106.9 тэрбум төгрөг батлагдсан. Эхний 6 сарын байдлаар нийт төсвийн 20 хувь, хагас жилийн төсвийн 40 хувийн гүйцэтгэлтэй байна.

ЗУРАГ № 6 ЗАРДЛЫН БҮТЭЦ



Нийт батлагдсан төсвийн 78 хувь буюу 170.0 тэрбум төгрөг нь урсгал зардалд, 22 хувь нь буюу 47.4 тэрбум төгрөг нь хөрөнгө оруулалтын зардалд тус тус батлагдсан байна⁷.

Нийт төсвийн 59 хувь нь “Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага” батлагдсан бөгөөд тус хөтөлбөрт аймгийн болон 14 сумын

⁷ Эх сурвалж: Сангийн яам. Төрийн сангийн газар. Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтэс. Монгол Улсын 2024 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан

засаг даргын тамгын газар болон ажлын алба хамаарах нийт төсөв багтсан. Тус хөтөлбөрийн нийт төсвийн 38 хувь хөрөнгө оруулалтын зардал буюу орон нутгийн хөгжлийн сан болон засаг даргын багцаас хэрэгжүүлэх орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн төсөл боловсруулах удирдамжид ⁸ “2.4.2 Аймаг/нийслэлийн болон сум/дүүргийн ИТХ-ын тогтоолын 1 дүгээр хавсралтаар зөвхөн аймгийн эсвэл сумын төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг батлах /сумын төсвийн суурь зарлага, суманд олгож байгаа орлогын шилжүүлэг санхүүгийн дэмжлэгийг оруулахгүй байх/;” гэж тусгасны дагуу аймгууд төсөв батлах болон түүнийг тайлагнах явцад сумдын төсөв, үр дүн ороогүй байна.

Төсвийн төсөл боловсруулах үе шатаас эхлэн хөтөлбөрийн хүрэх үр дүнг төсвийн нэгэн адил анхан шатнаас буюу сумдын нэгжээс хүлээн авч нэгтгэхгүй байгаагаас шалтгаалан Аймгийн ИТХ-аар баталж байгаа хөтөлбөр, хүрэх үр дүн, төсвийн хэмжээ зөвхөн аймгийн түвшинд сумдын нөлөөлөл тусгахад цаг хугацаа хангалтгүй, харилцан уялдаагүй байдал үүсдэг. Иймд тухайн орон нутгийн төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хэмжээнд гарсан үр дүнг бүрэн илэрхийлэх зорилгоор цаашид хөтөлбөр, үр дүнг төлөвлөж, хуваарилах, тайлагнах, хяналт шинжилгээ хийх үе шатанд төсвийн ерөнхийлөн захирагчид хамаарах бүх төсөв, хөтөлбөрийг багтаах нь зүйтэй.

Тус тайланд Дорноговь аймгийн хөтөлбөр, үр дүнд шинжилгээ хийхдээ аймгийн нийт төсвөөр буюу 14 сумдын төсөв нэмэгдсэн дүнгээр, хөтөлбөр бүрийн батлагдсан төсөв, гүйцэтгэл бүрээр задаргааг доор судалгаанд багтаасан.

ЗУРАГ № 7 ХӨТӨЛБӨРИЙН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ




⁸ Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж <https://mof.gov.mn/article/entry/2025>

Дорноговь аймгийн эхний хагас жилийн төсвөөр нийт 29 хөтөлбөрөөс 1 хөтөлбөр бүрэн зарцуулагдсан бол 2 хөтөлбөр огт зарцуулалтгүй тайлагнасан байна. Үүнд “Засгийн газрын өрийн үйлчилгээ”, “Санхүүгийн зах зээлийн зохицуулалт” хөтөлбөрүүд нь төлөвлөсөн хугацаанд үйл ажиллагаа зохион байгуулагдаагүй бол төвлөрүүлэх санхүүжилт бүрдээгүйтэй холбоотой бөгөөд хөтөлбөр тус бүр дээр дэлгэрэнгүй судалгааг орууллаа.

3. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

Дорноговь аймгийн батлагдсан төсвийн дагуу нийт 29 хөтөлбөр тус бүр нэг хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй. Нийт 29 хөтөлбөрийн хүрэх үр дүнгээс 21 хөтөлбөр нь үйл ажиллагааны шууд гарах

ЗУРАГ № 8 ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮНГИЙН ҮГИЙН ТОО Үр дүнг заасан бол 8 хөтөлбөр нь тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах нийгэм, эдийн засаг, хүн амд гарах үр нөлөөг тодорхойлсон байна.



Дорноговь аймгийн хувьд бусад аймгуудын хагас жилийн тайлантай харьцуулахад 29 хөтөлбөрийн хүрэх үр дүнг оновчтой, тус бүрийн үр дүнд тохируулан сонгосон байна.


Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн тодорхойлсон өгүүлбэр, найруулгын хувьд хамгийн урт хөтөлбөрийн үр дүн нь 20 үгтэй, хамгийн цөөн үгтэй нь 3 байна. Нийт хөтөлбөрийн 9 хувь 5-7 үгтэй бөгөөд үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагыг нэвтрүүлэх зорилгоор 2022 онд

Дорноговь аймгийг сонгон аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөө, төсвийн төсөл боловсруулахад үе шатуудад хамтран ажилласны үр дүнд тодорхой ахиц гарсан байна. Хүрэх үр дүнг тухайн хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн өөрчлөлтийг хэмжиж болохуйц үр дүн байдлаар бичиж нэг хөтөлбөрийн хүрээнд хэд хэдэн үр дүнд хүрэхээр тодорхойлж болно.

1. Салбарын эсвэл эрхлэх ажлын хүрээнд тулгарч байгаа асуудлыг шийдэх стратегийн зорилтыг агуулах, товч тодорхой, нэг утгыг илэрхийлэх;
 2. Тодорхой шийдвэр гаргахад чухал мэдээллийг илэрхийлэх;
 3. Гүйцэтгэлийг хэрэгжүүлэгч ажилтан, албан хаагч тус үзүүлэлтийг тодорхойлоход оролцсон байх, тэдний саналыг тусгах;
 4. Зөвхөн ач холбогдолтой гол үр дүнг тодорхойлох (зөвхөн хэмжиж болох үзүүлэлтүүд, хийх ажил эсвэл процессыг тоочихгүй байх) зэрэг шаардлагыг тавьсан бөгөөд үүнийг хөтөлбөр тус бүрийн хүрээнд нарийвчилсан судалгаа хийж дүгнэлт хийх шаардлагатай юм.
- Цаашид хөтөлбөрийн үр дүнг SMART шинж чанарыг хангах байдлаар, товч тодорхойлон тасралтгүй сайжруулах боломжтой.

Нийт хөтөлбөрөөс 13 хөтөлбөр нь хагас жилийн байдлаар 80-аас дээш хувийн гүйцэтгэлтэй байна. Бүх хөтөлбөрийн зорилтот түвшнийг бүтэн жилийн үр дүнгээс тооцсон тул хагас жилийн байдлаар өндөр гүйцэтгэлтэй байгаа нь (1) хөтөлбөрийн зорилтот түвшнийг төсвийн төлөвлөлттэй уялдаа багатай төлөвлөсөн, (2) хөтөлбөр үр дүнгийн тайланг хагас жилийн тайланд тогтмол гаргах, хяналт үнэлгээг хийж, баталгаажуулах үйл ажиллагаа хангалтгүй байгаа болон үндэслэх бодлогын баримт бичгүүд нь холбогдох хууль эрх зүйн хүрээнд хагас жилээр албан ёсоор тайлагнахгүй зэрэг шалтгаанаас хүрсэн түвшинг бодитой тайлагнаагүй шалтгаантай байна.

ЗУРАГ № 9 ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ




Нийт хөтөлбөрөөс 3 хөтөлбөрийн хүрэх үр дүн нь 0 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд “Засгийн газрын өрийн үйлчилгээ”, “Санхүүгийн зах зээлийн зохицуулалт” хөтөлбөрүүд нь төлөвлөсөн хугацаанд үйл ажиллагаа зохион байгуулагдаагүй бол төвлөрүүлэх санхүүжилт бүрдээгүйтэй холбоотой. Бага гүйцэтгэлтэй хөтөлбөрийн хувьд дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүд нь Засгийн газрын 2020 оны 206 тоот тогтоолын дагуу 02 дугаар сарын 01-ний дотор төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах эрх зүйн зохицуулалттай тул хагас жилийн үр дүнгийн тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх боломжгүй байдаг нь эдгээр үзүүлэлтийг үнэн бодит гарсныг бүрэн баталгаажуулахад хүндрэлтэй.

4. Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт

Дорноговь аймгийн 2024 оны хагас жилийн тайланд нийт 29 хөтөлбөрийн хүрэх үр дүнг 29 шалгуур үзүүлэлтээр хэмжихээр төлөвлөсөн. Нийт шалгуур үзүүлэлтийн 15 шалгуур үзүүлэлт нь

ЗУРАГ № 10 ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН АНГИЛАЛ /ХЭМЖИХ НЭГЖЭЭР/



тоогоор, 10 шалгуур үзүүлэлт нь хувиар хэмжихээр төлөвлөгдсөн бол 4 шалгуур үзүүлэлт нь бусад буюу га талбай, нас, сая төгрөг, тн махны хэмжээгээр хэмжихээр

төлөвлөгдсөн байна. Цаашид шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг зарцуулах санхүүжилтийн хэмжээ буюу сая төгрөгөөр бус үр нөлөөг хэмжих боломжтой шалгуур үзүүлэлтээр хэмжихээр сайжруулах боломжтой.

Нийт шалгуур үзүүлэлтийн 23 шалгуур үзүүлэлт нь 5 хүртэл үгтэй, үлдсэн 6 шалгуур үзүүлэлт 6-11 хүртэл үгтэй байгаа тул цаашид шалгуур үгийг товч байдлаар сайжруулах боломжтой.


Нийт 29 шалгуур үзүүлэлтээс 9 шалгуур үзүүлэлт нь тухайн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний тоогоор, 4 шалгуур үзүүлэлт нь тухайн хөтөлбөрт төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтээр хэмжихээр тогтоосон байна. Цаашид шалгуур үзүүлэлтийг нийгэм, эдийн засаг, орон нутгийн иргэдэд үзүүлэх үр нөлөөнд үндэслэн сайжруулах боломжтой.

Нийт 29 шалгуур үзүүлэлтийн 2024 оны хагас жилийн гүйцэтгэлээр 8 шалгуур үзүүлэлт 100 болон түүнээс дээш хувийн биелэлттэй тул “**Үр дүндээ хүрсэн**”, 21 шалгуур үзүүлэлтийн биелэлт 0-95.2 хувийн гүйцэтгэлтэй учир “**Сайжруулах шаардлагатай**” ангилалд багтаасан. Тухайн хөтөлбөрүүдэд бодлогын баримт бичиг болон улсын төсвийн ижил төстэй хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг мөн харьцуулан дэлгэрэнгүй судалсан судалгаанд үндэслэн шалгуур үзүүлэлтийг сайжруулах боломжтой.

5. Үр дүнгийн хамаарал

Дорноговь аймгийн батлагдсан төсвийн дагуу нийт 29 хөтөлбөрийн 2024 оны хагас жилийн хөтөлбөр, үр дүнгийн тайлангийн үр дүн болох хөтөлбөрийн гүйцэтгэл /тус бүр нэг хөтөлбөртэй учир хөтөлбөрийн хүрсэн түвшний гүйцэтгэлтэй ижил/, төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрийн үр ашгийн харилцан хамаарлыг судаллаа. Зөвхөн нэг аймгийн 29 хөтөлбөрийн хувьд тооцож буй бөгөөд бүх хөтөлбөр нэг шалгуур үзүүлэлттэй учир хязгаарлагдмал олонлог сонгогдож байгаа гэдгийг анхаарах нь зүйтэй. Харьцуулсан шинжилгээ дараах байдалтай харагдаж байна.

Зураг № 11 ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР АШГИЙН ХАМААРАЛ



Дээрх зурагт нийт 29 хөтөлбөрийн хүрээнд хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн биелэлт болон төсвийн гүйцэтгэл нь хөтөлбөрийн үр ашгийн тархалтыг харьцуулан харуулж байна. Үр дүнгүүд нь эерэг налуутай тул эдгээр хувьсагчид хооронд эерэг хамааралтай боловч шугамаас зөрүүтэй харагдаж байгаа тул хоёр хувьсагчийн хооронд тодорхой хамаарал байгаа хэдий ч харьцангуй тархалт ихтэй байна гэж дүгнэж болно. Иймд хөтөлбөрийн үр ашгийг сайжруулахад хөтөлбөрийн дээрх үр дүнг жигд сайжруулах, мөн цаашид төсвийн хэрэгжилтийг үр нөлөөтэй, хамааралтай байдлаар бодитой төлөвлөх шаардлага байна.


6. Хөтөлбөр, үр дүнгийн тайлан

Дорноговь аймгийн хөтөлбөр, үр дүнгийн тайланд туссан 29 хөтөлбөрийг биелэлтийн тоон болон чанарын үнэлгээг Дорноговь аймгаас Сангийн яаманд 2024 оны хагас жилийн тайлангийн нэгтгэлд ирүүлсэн байдлыг Сангийн яамны төрийн сангийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, Дорноговь аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө, тус төлөвлөгөөний хагас жилийн урьдчилан тайлан, Дорноговь аймгийн 2023 оны жилийн эцсийн статистикийн мэдээлэл болон бусад холбогдох эрх зүйн баримт бичигт үндэслэн судаллаа. Тус тайланд хөтөлбөр тус бүрээр хөтөлбөрт хамаарах үйл ажиллагааны танилцуулга, бодлогын баримт бичгийн уялдаа болон тайлангийн тоон мэдээлэл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг багтаасан.

Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа - 70105

Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ) нь аймгийнхаа иргэдийн эрх ашгийг төлөөлж, орон нутгийн асуудлуудыг шийдвэрлэх үүрэгтэй байгууллага юм. Дорноговь аймагт аймгийн 1, сумдын 14 ИТХ үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн хэмжээнд нийт 421 иргэдийн төлөөлөгч байгаагаас аймгийн ИТХ-д 33, 14 сумдад нийт 388 ИТХ байна. Дорноговь аймгийн сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ)-д нийт төлөөлөгчдийн тоо нь тухайн сумдын хүн ам, газар нутгийн хэмжээнээс хамааран ялгаатай байдаг. Монгол Улсын сум бүрийн ИТХ нь дунджаар 15-25 төлөөлөгчтэй байдаг ч энэ тоо сум бүрд харилцан адилгүй байна.

Зураг № 12 Дорноговь аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн тоо



Аймгийн ИТХ нь 33 сонгогдсон төлөөлөгчдөөс бүрдэж, иргэдийн саналаар сонгогддог тул нутгийн ард иргэдийн оролцоог хангадаг байгууллага юм. ИТХ нь дараах гол үүргүүдийг гүйцэтгэдэг⁹. Үүнд:

- Орон нутгийн бодлого тодорхойлох: Аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт гаргаж, хэрэгжүүлэлтэд хяналт тавина.
- Төсөв батлах: Аймгийн төсөв, орлого зарлагыг хэлэлцэн батлах эрхтэй.
- Хууль тогтоомжийн хэрэгжилт: Орон нутгийн түвшинд Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.
- Иргэдийн эрх ашиг хамгаалах: Иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах, тэдний саналыг сонсож, тэдгээрийг бодлогод тусгах үүрэгтэй.

Аймгийн ИТХ нь 2024 оны хагас жилд орон нутгийн гүйцэтгэх удирдлагын засаглал хөтөлбөрт 8 зорилтын 35 арга хэмжээний 1,333.7 сая.төг-ийн төсөвтэй, 12 орон тоотой ажиллахаас 236.9 сая.төг-ийн зардалтай, 12 орон тоотой ажиллаж, зардлыг 216.8 сая.төг-өөр буюу 8,5%-иар хэмнэсэн байна. Зардлыг арга хэмжээ тус бүрээр задалбал:

1. Үндсэн үйл ажиллагааны зардалд (80101) 955,8 сая.төг-ийн төсөвтэй ажиллах ёстойгоос 904.5 сая.төг-ийн гүйцэтгэлтэй ажиллаж төсвийг 5%-иар хэмнэсэн шалтгаан нь 2024 оны эхний улирал буюу 1-3 сар 12 орон ажиллахаас 1 орон тоо дутуу ажилласнаас болсон.

2. Мэдээлэл сурталчилгааны зардалд (80205) 2 телевиз, 2 сонины газартай гэрээ байгуулан хамтран ажиллаж Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд иргэд, ард олонд сурталчилсан.

⁹ Эх сурвалж: Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын цахим хуудас. <http://dornogovi.khural.mn/>

3. Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг (80802) зардалд 12 албан хаагчийн ар гэрт 2.8 сая.төг-ийн буцалтгүй тусламж, нийт албан хаагчдын дархлааг сэргээж, витаминжуулахад 2.8 сая.төг зарцуулсан.

4. Орон нутгийн нөөц хөрөнгийн (81102) зардалд 101.0 сая.төг-ийн төсөвтэй ажиллаж 99.1 сая.төг-ийн гүйцэтгэл гаргасан. Үүнийг задалбал 2023 оны ажлаа дүгнэж сайн ажилласан малчин, төрийн албан хаагч, тэргүүний хамт олны шагналд 9,8 сая.төг, 15 иргэнд 25.2 сая.төг-ийн эмчилгээний зардал болон бусад дэмжлэг хүндэтгэл үзүүлэхэд 12.7 сая.төг, 25 байгууллагад 20.2 сая.төг-ийн дэмжлэг, сургалт, зөвөлгөөн, чуулган, өдөрлөг, арга хэмжээ болон бусад зардалд 5.6 сая.төг зарцуулсан байна.

Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 74.0%

Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллын үйл ажиллагаа хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 4.7 тэрбум төгрөг төлөвлөгдсөн бөгөөд үүнээс 2024 оны эхний 6 сард 2.7 тэрбум төгрөг хуваарилсан. Нийт төсвийн 74.0 хувьтай тэнцэх буюу 2.0 төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 82.5%

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Иргэдийн төлөөлөгчидийн хурлын шийдвэр нь орон нутгийн хөгжлийг дэмжихэд чиглэнэ” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 82.5% байна.

Хөтөлбөрийн гүйцэтгэл: 82.5%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлттэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 82.5 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: 8.2%

Хөтөлбөрийн үр ашиг нь 8.2 хувь буюу “үр ашигтай” гарсан.

ЗУРАГ № 13 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа хөтөлбөрийн биелэлт



Аргачлал: Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааны тайланд үндэслэн тайланд хугацааны үйл ажиллагааны гүйцэтгэлд харгалзан тооцсон.

Ахиц дэвшил: Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлон орон нутгийн төрийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг төсвийн зарцуулалттай уялдуулж хэвшиж байгаа давуу талтай.

Анхаарах асуудал: Хөтөлбөр, үр дүнгийн тайланд тус хөтөлбөрт сумдын тайлан мэдээллийг нэгтгэн тайлагнахгүй байгаа нь цаашид үр дүн тооцоход хүндрэлтэй байна. Иймд цаашид төлөвлөлт, тайлагналын бүх шатанд сумдын дүнг нэгтгэсэн байдлаар ашиглаж байх нь зүйтэй. Засгийн газрын 2020 оны 206 тоот тогтоолын дагуу 02 дугаар сарын 01-ний дотор аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах эрх зүйн зохицуулалттай тул хагас жилийн үр дүнгийн тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх боломжгүй байдаг нь энэхүү үзүүлэлтийг үнэн бодит гарсныг бүрэн баталгаажуулахад хүндрэлтэй.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх – 70709

Дорноговь аймгийн Цагдаагийн газар нь Цагдаагийн ерөнхий газрын ерөнхий удирдлага доор үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 2024 оны байдлаар 9 тасаг хэлтэстэй үйл ажиллагаа явуулж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нэгдсэн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах, илрүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээнд дүн шинжилгээ хийж, өссөн гэмт хэрэг, зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулах ажил, арга хэмжээг дараах байдлаар хэрэгжүүлэн. Үүнд: “Цахим”, “Хамтдаа сэргийлье”, “ШТС-2024”. “Нуугдмал-2024”, “Гэрэл-хулгай тээвэр-бүс”, “Шаргын овоо”, “Гэрэл”, “Зочид буудал”, “Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлье”, “Намайг хамгаал”, “За больё-Хэмжээ болсон” зэрэг 11 тусгай арга хэмжээг зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээний үр дүнд гэмт хэргийн илрүүлэлт аймгийн хэмжээнд 48.6 хувь буюу өмнөх оны мөн үеийнхээс аймгийн хэмжээнд 6.0 нэгжээр өссөн үзүүлэлтэй байна.

ЗУРАГ № 14 ГЭМТ ХЭРЭГ, ТӨРЛӨӨР, ЭЗЛЭХ ХУВИАР



Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 50.2 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 26.4 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 6.2 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 17.4 хувийг бусад төрлийн гэмт хэрэг эзэлж байна¹⁰.

Эхний хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 103 олон нийтийн цагдаа нарт олгосон урамшуулалд 106.8 сая төгрөг, ажил олгогчоос олгох Нийгмийн даатгалын шимтгэл 12.4 сая төгрөг, 1 олон нийтийн цагдаад сайн ажилласан гэж 0.4 сая төгрөгийн урамшуулал бусад байгууллагад дэмжлэг болон үйл ажиллагааны зардалд 105,864,200 төгрөгийг зарцуулсан байна. Мөн олон нийтийн цагдаа нарын нийгмийн баталгааг хангах зорилгоор цагдаагийн таних тэмдэг, хөдөлмөрийн аюулгүй байдлын тусгай хувцас худалдан авахад 8.8 сая төгрөгийг зарцуулсан.

Тусгай байгууллагуудын орчин нөхцлийг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор урсгал засвар болон камержуулалт, гэрэлтүүлгийг нэмэгдүүлсэн. Нийт 5 төсөл арга хэмжээний гүйцэтгэлд 1.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тус салбарын зорилтыг “5.2. Гэмт хэрэг, зөрчлийг 3 хувиар бууруулна”, “5.3. Хүний хүчин зүйлээс хамааралтай осол гэмтлийн гаралтыг 5 хувиар бууруулна” гэж тодорхойлсон. Тус хоёр зорилтын хүрээнд нийт 4 хөтөлбөр, 5 хөтөлбөрийн хүрэх үр дүн, 16 шалгуур үзүүлэлтээр хэмжихээр төлөвлөсөн. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагааны нийт үр дүнгээр төсвийн ерөнхийлөн захирагчийн “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” хөтөлбөрийн үр дүн илэрхийлэгдсэн байна.

1. Цагдаагийн байгууллагын үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг 20 хувиар нэмэгдүүлнэ.

Тус үр дүнгийн хүрээнд “Цагдаа”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” хоёр хөтөлбөр төлөвлөсөн.

- 1.1. “Цагдаа” хөтөлбөрийн “Гэмт хэрэг илрүүлэлтийг 2 хувиар нэмэгдүүлэх”, “Хэргийг хэрэг бүртгэл явуулж эхэлснээс хойш хуулийн хугацаанд шийдвэрлэлтийг 10 хувиар нэмэгдүүлнэ” хоёр хөтөлбөрийн үр дүнг 7 чиглэлийн үйл ажиллагаа, төслийн дагуу шалгуур үзүүлэлтээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:


¹⁰ Эх сурвалж: Дорноговь аймгийн статистикийн хэлтэс. Дорноговь аймгийн 2023 оны статистикийн эмхэтгэл.

1.1.1. “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх” арга хэмжээг “Зохион байгуулсан арга хэмжээ” шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр төлөвлөсөн. Тус арга хэмжээний хүрээнд 75 удаагийн сургалт, уулзалт хэлэлцүүлэг 2 зохион байгуулж нийт 78 гадагшаа чиглэсэн арга хэмжээг зохион байгуулсан. Зохион байгуулсан сургалт, мэдээлэл, уулзалт, хэлэлцүүлэгт төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн 5279, хуваарь хөдөлмөр эрхлэгч 1580, малчин 1500, оюутан 2810, сурагч 8296, ажилгүй 205 иргэд хамрагдсан. Аймгийн хөгжлийн төлөвлөгөөний хагас жилийн тайланд тус арга хэмжээг 90 хувийн биелэлттэй гэж үнэлсэн боловч хүрсэн түвшинг хагас жилээр тодорхойлоогүй



байна.

1.1.2. “Гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх” арга хэмжээг “Гэмт хэргийн илрүүлэлт” шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр төлөвлөсөн. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нэгдсэн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах, илрүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээнд дүн шинжилгээ хийж, өссөн гэмт хэрэг, зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулах ажил, арга хэмжээг дараах байдлаар хэрэгжүүлэн “Хамтдаа сэргийлье”, “ШТС-2024”. “Нуугдмал-2024”, “Гэрэл-хулгай тээвэр-бүс”, “Шаргын овоо”, “Гэрэл”, “Зочид буудал”, “Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлье”, “Намайг хамгаал”, “За больё-Хэмжээ болсон” зэрэг 11 тусгай арга хэмжээг зохион байгуулж нийт 16.0 сая төгрөгийн санхүүжилтийг



шийдвэрлэсэн. Энэхүү арга хэмжээний үр дүнд гэмт хэргийн илрүүлэлт аймгийн хэмжээнд 48.6 хувь буюу өмнөх оны мөн үеийнхээс аймгийн хэмжээнд 6.0 нэгжээр өссөн үзүүлэлтэй байна. Аймгийн хөгжлийн төлөвлөгөөний хагас жилийн тайланд тус арга хэмжээг 90 хувийн биелэлттэй гэж үнэлсэн боловч хүрсэн түвшинг хагас жилээр тодорхойлоогүй байна.

1.1.3. “Иххэт сумын Цагдаагийн кобаны барилгын их засварын ажил хийх” арга хэмжээг “Ажлын гүйцэтгэл” шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр төлөвлөсөн. Аймгийн Засаг даргын 2024 оны А/41 дүгээр захирамжаар 154,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Иххэт сумын Цагдаагийн кубоны барилгын их засварын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах захиалагчийн эрхийг Иххэт сумын Засаг даргад шилжүүлж барилгын гүйцэтгэл 20 хувьтай үргэлжилж байна. Аймгийн хөгжлийн төлөвлөгөөний хагас жилийн тайланд тус арга хэмжээг 50 хувийн биелэлттэй гэж үнэлсэн боловч хүрсэн түвшинг хагас жилээр тодорхойлоогүй



байна.

1.1.4. “Аймгийн Цагдаагийн газарт шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах” арга хэмжээг “Ажлын гүйцэтгэл” шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр төлөвлөсөн. 2024 оны хагас жилийн байдлаар Мөрдөгчдийг тусгай мэдлэг олгох сургалтад хамраагдахад 750 мянган төгрөг, мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 1.5 сая төгрөг, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх мэдээлэх самбар байршуулахад 3.7 сая төгрөг, "Өөртөө хайртай 72 цаг" эрүүл мэнд, сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээнд албан хаагчдийг хамруулахад 2 сая төгрөг, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөөврийн камер худалдан авахад 9 сая төгрөг, нийт 17.1 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн.

1.1.5. “Мөрдөгчдийн ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах” арга хэмжээг “Зохион байгуулсан арга хэмжээ” шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр төлөвлөсөн. 2024 оны хагас жилийн байдлаар мөрдөгчдийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 23 заалт бүхий сэдэвчилсэн сургалтын төлөвлөгөөг гарган “Шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээдээр хийлгэж болох шинжилгээний талаар”, “Хэргийн газрын үзлэг явуулах арга зүй”, “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн нэмэлт өөрчлөлт”, “Шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээдээр хийлгэж болох шинжилгээний талаар”, “Хэргийн газрын үзлэг явуулах арга зүй” зэрэг сэдвээр 5 удаа 6 цагийн сургалтын зохион байгуулж давхардсан тоогоор 53 мөрдөгч нарыг хамруулсан. Аймгийн хөгжлийн төлөвлөгөөний хагас жилийн тайланд тус арга хэмжээг 90 хувийн биелэлттэй гэж үнэлсэн боловч хүрсэн түвшинг хагас жилээр тодорхойлоогүй байна.



1.2. “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр” хөтөлбөрийн “Иргэдийн мэдээллээр илрүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн тоог 10 хувиар нэмэгдүүлнэ.”, “Архины хамааралтай иргэдийн тоог бууруулна.” хоёр хөтөлбөрийн үр дүнг 6 чиглэлийн үйл ажиллагаа, төслийн дагуу шалгуур үзүүлэлтээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

1.2.1. “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулах” арга хэмжээг “Хэсэгчилсэн арга хэмжээ” шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр төлөвлөсөн.



2024 оны хагас жилийн байдлаар “Цахим”, “Сүм хийд-2024”, “Хамтдаа сэргийлье”, “ШТС-2024”. “Нуугдмал-2024”, “Мөнгө эрсдэлээс хамгаалж ирээдүйгээ баталгаажуулья”, “Гэрэл-хулгай тээвэр-бүс”, “Шаргын овоо”, “Гэрэл”, “Зочид буудал”, “Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлье” зэрэг 11 тусгай арга хэмжээг зохион байгуулж биелэлт үр дүнг тооцож ажилласан. Дээрх арга хэмжээний үр дүнд гэмт хэргийн илрүүлэлт аймгийн хэмжээнд 48.6 хувь буюу өмнөх оны мөн үеийнхээс аймгийн хэмжээнд 6.0 нэгжээр өссөн эерэг үзүүлэлтэй байна. Аймгийн хөгжлийн төлөвлөгөөний хагас жилийн

тайланд тус арга хэмжээг 100 хувийн биелэлттэй гэж үнэлсэн боловч хүрсэн түвшинг хагас жилээр тодорхойлоогүй байна.

1.2.2. “Камержуулалтын ажил хийх” арга хэмжээг “Ажлын гүйцэтгэл” шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр төлөвлөсөн. 2024 оны хагас жилийн байдлаар Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 14/02 тоот тогтоолоор Сайншанд, Замын-Үүд сумдад камерын хяналт, удирдлагын нэгдсэн системийг 101 байршилд 278 камер шинээр нэвтрүүлэхээр 2,1 тэр бум төгрөгийг төсөвт тусган шийдвэрлэсэн. Энэ хүрээнд 1,3 тэрбум төгрөгөөр Сайншанд суманд 63 цэг байршилд 163 камер, сувагчлалын ажлыг эхлүүлсэн бөгөөд 2024 оны 07 дугаар сард багтаан камержуулалтыг хийж дуусгахаар гэрээг байгуулсан.



Аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар 32 цэгт 68 камер ажиллаж байсан бол 2024 оны 05 дугаар сарын байдлаар 39 цэгт чанарын шаардлага хангасан 100 камер ажиллаж байна. Аймгийн хөгжлийн төлөвлөгөөний хагас жилийн тайланд тус арга хэмжээг 50 хувийн биелэлттэй гэж үнэлсэн боловч хүрсэн түвшинг хагас жилээр тодорхойлоогүй байна.

1.2.3. “Олон нийтийн цагдаагийн урамшуулал олгох” арга хэмжээг “Урамшуулалд хамрагдсан олон нийтийн цагдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр төлөвлөсөн.



2024 оны хагас жилийн байдлаар Аймгийн нийт 33 олон нийтийн цагдаагийн орон тоо баталснаас 20 олон нийтийн цагдаа аймаг, сум орон нутаг ажиллаж байна. Аймгийн төв дээр 6, Замын-Үүд сумын сум дундын цагдаагийн хэлтэст 4, бусад суманд 10 хүн ажиллаж байна. Цаашид сул орон тоог нөхөн хангах чиглэлээр иргэдийг бүртгэл судалгаанд хамруулж байна. 2024 оны 05 дугаар сарын урамшуулал 1 хүний сард 1.1 сая төгрөг бөгөөд 5 дугаар сарын байдлаар нийт 115 сая олгогдсон байна. Мөн хугацаанд хамт олноо хошуучлан идэвх санаачлагатай ажилласан 1 алба хаагчид урамшуулал болгон 40 хувь буюу 460 төгрөгийг урамшуулал олгосон.

1.2.4. “Хууль сахиулах чиг үүргийн байгууллагуудын зөвлөгөөн зохион байгуулах” арга хэмжээг “Зөвлөгөөнд хамрагдсан албан хаагчид” шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр төлөвлөсөн. 2024 оны хагас жилийн байдлаар хууль сахиулах чиг үүргийн байгууллагуудын албан хаагчдыг



чадавхжуулж, тэдгээрийн уялдааг холбоог хангасан нэмэгдүүлэх зөвлөгөөнийг 2024 оны 03 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд 2024 оны 05 дугаар сарын 16-ний өдөр төрийн цэргийн болон хууль сахиулах чиг үүргийн байгууллагын албан хаагчдад зориулсан сургалт, лекцийг зохион байгуулж 200 гаруй албан хаагчдыг хамруулсан. Тус сургалтаар төрийн албан хаагчийн харилцаа хандлага, ёс зүй, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, хувь хүний хөгжлийг дэмжих агуулгаар зохион байгуулсан. Үүний үр дүнд төрийн албан хаагчийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд нөлөө үзүүлсэн. Аймгийн хөгжлийн төлөвлөгөөний хагас жилийн тайланд тус арга хэмжээг 50 хувийн биелэлттэй гэж үнэлсэн боловч хүрсэн түвшинг хагас жилээр тодорхойлоогүй байна.

1.2.5. “Аж ахуйн үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах” арга хэмжээг “Дэмжлэгийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ” шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр төлөвлөсөн. 2024 оны хагас жилийн байдлаар архины хамааралтай 75, орон гэргүй тэнэмэл 4 иргэнийг гэмт хэрэг, зөрчилд өртөж холбогдохоос урьдчилан сэргийлж, судалгааг шинэчлэн гаргасан. Аж ахуйн бүлгийн үйл ажиллагааг дэмжих бүлгийн хурлыг зохион байгуулж 2024 оны төлөвлөгөөг батлан 30 гаруй аж ахуйн нэгж байгууллагын 1200 гаруй албан хаагчдад сургалт зохион байгуулж 2024 оны 04 дүгээр сард Замын-Үүд суманд бүсийн уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулсан. Мөн Сайншанд сумын архины хамааралтай 13 иргэнийг эрүүл мэндийн байгууллагын үзлэг оношилгоонд хамруулж, орон гэргүй тэнэмэл 4 иргэнийг нийгэмшүүлэх зорилгоор холбогдох байгууллагуудтай хамтран 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Аймгийн хөгжлийн төлөвлөгөөний хагас жилийн тайланд тус арга хэмжээг 50 хувийн биелэлттэй гэж үнэлсэн боловч хүрсэн түвшинг хагас жилээр тодорхойлоогүй байна.



1.2.6. “Итгэл” төслийг орон нутагт хэрэгжүүлэх” арга хэмжээг “Төсөлд хамрагдсан иргэд” шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр төлөвлөсөн боловч хагас жилд тус төсөл нь хэрэгжээгүй.




1.3. “Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх дадалтай иргэдийн тоог 20 хувиар нэмэгдүүлнэ.” хөтөлбөрийн “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” хөтөлбөрийн үр дүнг 5 чиглэлийн үйл ажиллагаа, төслийн дагуу шалгуур үзүүлэлтээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

1.3.1. “Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа зохион байгуулах” арга хэмжээг “Сургалт, сурталчилгаа” шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр төлөвлөсөн. 2024 оны хагас жилийн байдлаар Сайхандулаан сумын Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хүүхдийг замын хөдөлгөөнд оролцох үед баримтлах дүрмийн тухай ойлголт өгөх, эцэг, эх асран хамгаалагчийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхдийг тээвэрлэх үеийн аюулгүй байдал, 10 хүртэлх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх талаар Сайншанд болон Замын-Үүд суманд үйл ажиллагаа явуулдаг 15 цэцэрлэгийн багш ажилчид, ахлах болон бэлтгэл бүлгийн 120 хүүхдэд сургалт зохион байгуулсан. “Хүүхдийн аюулгүй байдал-таны хариуцлагаас” аяныг аймгийн хэмжээнд зарлаж 3 сарын турш хэрэгжүүлэн иргэдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл, зөвлөмжөөр хангаж ажилласан. Аяны хүрээнд бага насны хүүхдэд түгээмэл тохиолддог осол гэмтэл түүнээс урьдчилан сэргийлэх нь, осол гэмтлийн тэргүүлэх өвчлөлийг таниулах, урьдчилан сэргийлэх, анхны тусламж үзүүлэх зэрэг сэдвийн хүрээнд аймаг болон сумдын цэцэрлэгийн багш ажилчид, эцэг эх, асран хамгаалагчид, ЕБС-ийн хүүхдүүдэд сургалтыг хийж нийт 30 удаагийн сургалтаар 1250 хүнийг хамруулж эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлсэн. Аймгийн хэмжээнд хагас жилийн байдлаар бүртгэгдсэн халдварт бус өвчлөлийн 2.3 хувийг осол гэмтлийн шалтгаант өвчлөл эзэлж, 10,000 хүн амд 130,8 байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 1.8 түвшнээр буурсан үзүүлэлттэй байна. Осол гэмтлийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаанд нь 35.5 хувийг бүх төрлийн уналт, 18.4 хувийг амьгүй механик хүчинд өртөх, 15.4 хувийг хүчирхийлэл, 15 хувийг зам тээврийн осол, 4.3 хувийг амьтай механик хүчинд өртөж гэмтсэн тохиолдол эзэлж байна. Аймгийн хөгжлийн төлөвлөгөөний хагас жилийн тайланд тус арга хэмжээг 70 хувийн биелэлттэй гэж үнэлсэн боловч хүрсэн түвшинг хагас жилээр тодорхойлоогүй байна.



1.3.2. “Чойр - Сайншанд - Замын-Үүд чиглэлийн босоо тэнхлэгийн замд жолоочийн нойр сэргээгч дэржгэнүүр хийх” арга хэмжээг “Шинээр хийсэн дэржгэнүүр” шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр төлөвлөсөн. 2024 оны хагас жилийн байдлаар Чойр-Сайншанд-Замын-Үүд чиглэлийн босоо тэнхлэгийн А0102, А0103 Олон Улсын болон орон нутгийн автозамд нойр сэргээгч буюу дэржигнүүр тайлангийн хугацаанд шинээр хийгдээгүй байна. Аймгийн хөгжлийн төлөвлөгөөний хагас жилийн тайланд тус арга хэмжээг 30 хувийн биелэлттэй гэж үнэлсэн боловч хүрсэн түвшинг хагас жилээр тодорхойлоогүй байна.



1.3.3. “Урьдчилан сэргийлэх санамж, сэрэмжлүүлгийн самбар байршуулах” арга хэмжээг “Шинээр нэмж байршуулсан самбар” шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр төлөвлөсөн. 2024 оны хагас жилийн байдлаар Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/328 дугаар захирамжаар зам тээрийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор авто замын хөдөлгөөнд оролцож байгаа иргэд, жолооч нарт тээврийн хэрэгслийн зөвшөөрөгдсөн хурдыг хэтрүүлэхгүй байх талаар 4 ширхэг “Мэдээлэх самбар” байршуулахад зориулж аймгийн Цагдаагийн газарт 3.7 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн. Аймгийн хөгжлийн төлөвлөгөөний хагас жилийн тайланд тус арга хэмжээг 30 хувийн биелэлттэй гэж үнэлсэн боловч хүрсэн түвшинг хагас жилээр тодорхойлоогүй байна.



1.3.4. “Зөөврийн хурд хэмжигч худалдан авах” арга хэмжээг “Хурд хэмжигчийн тоо” шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр төлөвлөсөн. 2024 оны хагас жилийн байдлаар Цагдаагийн газарт шаардлагатай зөөврийн хурд хэмжигч, худалдан авах талаар саналаа хүргүүлж байгаа боловч эх үүсвэргүй учир энэ арга хэмжээ хэрэгжээгүй байна.

1.3.5. “Ханги хилийн боомтын дагуу авто замд байнгын хяналтын цэг байгуулах” арга хэмжээг “Хяналтын цэгийн тоо” шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр төлөвлөсөн. Хяналтын цэг байгуулах ажил тайлант хугацаанд хэрэгжээгүй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хүрээнд орон нутагт 16 чиглэлийн арга хэмжээ төлөвлөснөөс 2024 оны хагас жилийн байдлаар 16 арга хэмжээний 3 арга хэмжээ хэрэгжээгүй бөгөөд нийт 16 арга хэмжээний гүйцэтгэл дунджаар 60 хувь байна. Тус арга хэмжээнүүд нь төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн “Гэмт хэргийн зөрчлийг бууруулах” хөтөлбөрийн үр дүнтэй шууд уялдаатай төлөвлөгдсөн байна. Хүрэх үр дүнг буюу гэмт хэрэг, зөрчлийг Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 3 хувь, төсвийн хүрэх үр дүнд 1 хувиар бууруулахаар тус тус төлөвлөсөн нь ялгаатай байгаа тул цаашид бодлогын зорилт, төлөвлөгөөний хүрэх үр дүнг ижил байдлаар төлөвлөх шаардлагатай.

Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 44%

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 5.9 тэрбум төгрөг төлөвлөгдсөн бөгөөд үүнээс 2024 оны эхний 6 сард 3.0 тэрбум төгрөг хуваарилсан. Нийт төсвийн 44 хувьтай тэнцэх буюу 1.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 148.7%

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Гэмт хэргийг бууруулна” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 148.7% байна.

Хөтөлбөрийн гүйцэтгэл: 148.7%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлттэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 148.7 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: 23.2%

Хөтөлбөрийн үр ашиг нь 104.5 хувь буюу “үр ашигтай” гарсан.

Зураг № 15 ГЭМТ ХЭРГЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ



Аргачлал: Аймгийн хэмжээнд тайлант хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоо хэмжээний өөрчлөлтөөр тооцох бөгөөд буурах шинжтэй үзүүлэлт.


Ахиц дэвшил: Аймгийн жилийн хөгжлийн төлөлөгөө болон төсвийн хөтөлбөр нь уялдаатай төлөвлөн гүйцэтгэл үр дүнгийн мэдээллийг бодитоор хэмжих нөхцөл бүрдсэн.

Анхаарах асуудал: Шалгуур үзүүлэлтийн хүрэх үр дүн ялгаатай тогтоогдсон байгаа нь цаашид бодлогын зорилтын хүрэх үр дүнг ижил тогтоож, нэгдсэн аргачлал авах үр дүнтэй. Гэмт хэрэг, зөрчлийн бууралт нь буурах аргачлалаар тооцдог үзүүлэлт тул хагас жилээр тоон үзүүлэлт бага байгаа нь хөтөлбөрийн гүйцэтгэлийг өндөр үнэлэхэд нөлөөлсөн ба энэ нь жилийн эцсийн хүлээгдэж буй үр дүнг шууд илэрхийлэх боломжгүй юм.

Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага – 70106

Тус хөтөлбөрт аймгийн болон сумдын засаг даргын тамгын газар, түүний чиг үүргийн байгууллага, алба нэгжийн үйл ажиллагааны болон хөтөлбөрийн зардал хамаарч байна. Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газар нь аймгийн хэмжээнд төрийн үйлчилгээг зохион байгуулах, нутгийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх, бодлого боловсруулах зэрэг үүрэгтэй гол байгууллага юм. Энэхүү байгууллага нь аймгийн Засаг дарга болон түүний орлогч, аймгийн ИТХ-ын дарга зэрэг албан тушаалтнуудын удирдлага дор үйл ажиллагаагаа явуулдаг.

Зураг № 16 ДОРНОГОВЬ АЙМГИЙН ТАМГЫН ГАЗРЫН БҮТЭЦ, АЛБАН ХААГЧИЙН ТОО



- Засаг дарга: Аймгийн Засаг дарга нь аймгийн хэмжээнд төрийн захиргааны байгууллагуудыг удирдаж, бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлдэг¹¹.

- Засаг даргын орлогч: Засаг даргын орлогч нь тодорхой чиглэлүүдэд хариуцлага хүлээж, Засаг даргын үйл ажиллагаанд туслалцаа үзүүлдэг.

Тамгын газрын хэлтэс, албад:

- Эрх зүйн хэлтэс: Хууль зүйн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд хяналт тавих үүрэгтэй.

- Санхүү, эдийн засгийн хэлтэс: Санхүүгийн зохицуулалт, төсөв боловсруулах, аймгийн эдийн засгийн төлөвлөгөөг хариуцдаг.

- Нийгмийн бодлогын хэлтэс: Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн асуудалд анхаарал тавьж, зохицуулалт хийдэг.

¹¹ Эх сурвалж: Дорноговь аймгийн засаг даргын тамгын газар. <https://dornogovi.gov.mn/>

- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс: Аймгийн хөгжлийн урт болон богино хугацааны төлөвлөлт, төсөл хөтөлбөрүүдийг зохицуулж, хэрэгжилтэд хяналт тавьдаг.
- Хүний нөөцийн хэлтэс: Төрийн албаны ажилтан, хүний нөөцийг удирдах, сургах, хөгжүүлэх үүрэгтэй.
- Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс: Захиргаа, дотоод зохицуулалт, төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангах чиглэлээр ажилладаг.

Энэхүү бүтэц нь Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын гол чиг үүргүүдийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байна.

АЗДТГ нь 2024 оны хагас жилд орон нутгийн гүйцэтгэх удирдлагын засаглал хөтөлбөрт 5 арга хэмжээний 3,162.2 сая.төг-ийн төсөвтэй, 76 орон тоотой ажиллахаас 2466.9 сая.төг-ийн зардалтай, 68 орон тоотой ажиллаж, зардлыг 695.3 сая.төг-өөр буюу 22%-иар, орон тоог 8 хүнээр хэмнэсэн байна. Зардлыг арга хэмжээ тус бүрээр задалбал:

1. Үндсэн үйл ажиллагааны зардалд (80101) 2085.9 сая.төг-ийн төсөвтэй ажиллах ёстойгоос 1586.3 сая.төг-ийн гүйцэтгэлтэй ажиллаж төсвийг 24%-иар хэмнэсэн шалтгаан нь 8 орон тоо дутуу ажилласнаас болсон.
2. Мэдээлэл сурталчилгааны зардалд (80205) 2 телевиз, 2 сонины газартай гэрээ байгуулан хамтран ажиллаж Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг иргэд, ард олонд сурталчилсан.
3. Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг (80802) зардалд 7 албан хаагчийн ар гэрт 3.1 сая.төг-ийн буцалтгүй тусламж, нийт албан хаагчдын дархлааг сэргээж, витаминжуулахад 2.7 сая.төг зарцуулсан.
4. Орон нутгийн нөөц хөрөнгийн (81102) зардалд 1000.0 сая.төг-ийн төсөвтэй ажиллаж 844.8 сая.төг-ийн гүйцэтгэл гаргасан. Үүнийг задалбал 2023 оны ажлаа дүгнэж сайн ажилласан малчин, төрийн албан хаагч, тэргүүний хамт олны шагналд 185.4 сая.төг, талын түншлэл хээрийн сургууль зохион байгуулахад 99.6 сая.төг, 4 иргэнд 4.5 сая.төг-ийн эмчилгээний зардал, 13 иргэнд дэмжлэг болон хүндэтгэл үзүүлэхэд 44.7 сая.төг, 14 байгууллагад 111.2 сая.төг-ийн дэмжлэг, сургалт, зөвөлгөөн, чуулган, өдөрлөг, арга хэмжээ болон бусад зардалд 399.4 сая.төг зарцуулсан байна.
5. Улсын их баяр наадам (82801) зардалд 30.0 сая.төг-ийн төсөвтэйгээс аймгийн баяр наадам 2024.07.26-нд болсон тул гүйцэтгэл гараагүй.

Орон нутгийн төрийн байгууллагын үйл ажиллагаа явуулах орчин нөхцлийг сайжруулах зорилгоор урсгал засвар үйлчилгээнд 3 төсөл арга хэмжээний гүйцэтгэлд 111,8 сая төгрөгийн санхүүжилт олгосон.Төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулах, иргэдэд түргэн шуурхай хүргэх зорилгоор машин, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшлоор хангахад 11 төсөл арга хэмжээний гүйцэтгэлд 982,1 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

АЗДТГ-ын дэргэдэх Нийтлэг үйлчилгээний газар нь 2024 оны хагас жилийн байдлаар орон нутгийн гүйцэтгэх удирдлагын засаглалын хөтөлбөрт 3 арга хэмжээний 771,4 сая төгрөгийн төсөвтэй, 37 орон тоотой ажиллахаас 744,2 сая төгрөгийн төсөвтэй 37 орон тоотой ажилласан. Тайлант хугацааны байдлаар зардлыг 26,2 сая төгрөг буюу 3,5% хэмнэсэн.

1. Үндсэн үйл ажиллагааны зардал 80101 -764,3 сая төгрөгийн төсвөөс 739,8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж төсвийг 3,3% хэмнэсэн. Төсөв хэмнэгдсэн шалтгаан нь засвар, болон зарим албан хаагчийн өвлийн нормыг шинэчлэхээр, 2 тээврийн хэрэгсэл эвдрэлийн улмаас үйлчилгээнд яваагүй учир тээвэр шатахууны зардал тус тус хэмнэгдсэн.

2. Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг 80802-зардалд нийт албан хаагчдад “Сар шинэ”-ийн баярын хүндэтгэл 3,1 сая, дархлаажуулалтын зардал 1,4 сая төгрөгийг тус тус зарцуулсан.

3. Нэмэлт санхүүжилт 80102- зардал 19,7 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авснаас 13,5 сая төгрөгийн зарцуулсан. Үүнээс ЗДТГ-ын цэвэрлэгээ үйлчилгээний зардалд 9,5 сая, амрах өрөөний тохижилт эд хогшил худалдан авах 3,0 сая, туршлага солилцох зардал нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 1,0 сая төгрөгийг тус тус зарцуулсан.

Орон нутгийн гүйцэтгэх засаглалын байгууллагын үйл ажиллагааны үр дүнд аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд дараах зорилтуудад уялдуулан төлөвлөсөн байна.

7.5. Төрийн бүтээмжийн сэргэлт: 4 хөтөлбөрийн 18 шалгуур үзүүлэлт


7.6. Хөгжлийн бодлого, төлөвлөлт: 1 хөтөлбөр 4 шалгуур үзүүлэлт

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд аймгийн засаглал, төрийн байгууллагын үйл ажиллагааг үнэлэх сэтгэл ханамжийн шалгуур үзүүлэлт тусгагдаагүй ба зөвхөн нийгмийн халамжийн үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан хүний тоон шалгуур үзүүлэлтийг оруулсан. Иймд хөгжлийн бодлогын баримт бичгийн хөтөлбөр болон төсвийн хөтөлбөрийг харьцуулах боломжгүй.

Дорноговь аймгийн орон нутгийн гүйцэтгэл засаглалын үр дүнг тооцоход төсвийн гүйцэтгэлийн хувь хэмжээг Сангийн яамны төрийн сангийн нэгдсэн мэдээнээс залруулга хийн тайлагнасан бөгөөд нийт гүйцэтгэлийн хувь 29 хувьтай байгаа нь тус хөтөлбөрт шууд бус хамаарах бусад арга хэмжээ хамт төлөвлөж байгаатай холбоотой байна.

Тус хөтөлбөрт 2024 онд нийт 128 тэрбум төгрөг батлагдснаас нийт төсвийн 37 хувь буюу 46.5 тэрбум төгрөг нь хөрөнгө оруулалтын шинж чанартай буюу орон нутгийн хөгжлийн сан, хөрөнгө оруулалт зориулалтаар, 36 хувь буюу 46.5 тэрбум төгрөг нь татаас, төвлөрүүлэх шилжүүлэгт, 26 хувь буюу 33.8 тэрбум төгрөг нь төрийн захиргааны байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зориулалтын төсөв буюу засаг даргын тамгын газрын байгууллагын бүтцийн урсгал зардал, ажлын алба, нийтлэг үйлчилгээ, засаг даргын арга хэмжээний зардалд тус тус хуваарилагдсан байна¹².

Зураг № 17 Орон нутгийн гүйцэтгэх засаглал хөтөлбөрийн 2024 оны батлагдсан төсвийн бүтэц, тэрбум төгрөгөөр



Иймд татаас төвлөрүүлэх болон хөрөнгө оруулалтын зориулалтын төсвийн хэрэгжих хугацаа болоогүй учраас гүйцэтгэл гараагүй эсхүл гүйцэтгэл бага байгаагаас шалтгаалан тус хөтөлбөрийн нийт төсвийн гүйцэтгэлийн хувь бага байна.

Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 29%

Орон нутгийн гүйцэтгэх засаглалын байгууллагын үйл ажиллагаа хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 128.1 тэрбум төгрөг төлөвлөгдсөн бөгөөд үүнээс 2024 оны эхний 6 сард 62.2 тэрбум төгрөг хуваарилсан. Нийт төсвийн 29 хувьтай тэнцэх буюу 18.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

¹² Эх сурвалж: Дорноговь аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 108%

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 108% байна.

Хөтөлбөрийн гүйцэтгэл: 107.6%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлтэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 107.6 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: 78.5%

Хөтөлбөрийн үр ашиг нь 78.5 хувь буюу “үр ашигтай” гарсан.

ЗУРАГ № 18 Орон нутгийн гүйцэтгэх засаглал, удирдлага хөтөлбөрийн биелэлт



Аргачлал: Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжилтэд үндэслэн тооцсон.

Ахиц дэвшил: Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтээ иргэдийн сэтгэл ханамжийн хувиар тодорхойлсон боловч аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд аймгийн засаглал, төрийн байгууллагын үйл ажиллагааг үнэлэх сэтгэл ханамжийн шалгуур үзүүлэлт тусгагдаагүй ба зөвхөн нийгмийн халамжийн үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан хүний тоон шалгуур үзүүлэлтийг оруулсан.

Анхаарах асуудал: Хөтөлбөр, үр дүнгийн тайланд тус хөтөлбөрт сумдын тайлан мэдээллийг нэгтгэн тайлагнахгүй байгаа нь цаашид үр дүн тооцоход хүндрэлтэй байна. Иймд цаашид төлөвлөлт, тайлагналын бүх шатанд сумдын дүнг нэгтгэсэн байдлаар ашиглаж байх нь зүйтэй. Засгийн газрын 2020 оны 206 тоот тогтоолын дагуу 02 дугаар сарын 01-ний дотор аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах эрх зүйн зохицуулалттай тул хагас жилийн үр дүнгийн тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх боломжгүй байдаг нь энэхүү үзүүлэлтийг үнэн бодит гарсныг бүрэн баталгаажуулахад хүндрэлтэй. Цаашид төрийн үйлчилгээ хүлээн авч байгаа иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээг тогтмол хийж хэвших шаардлагатай байна. Мөн сэтгэл ханамж, төрийн үйлчилгээний хүртээмж, хугацааг нэмэгдүүлэхэд төрийн нөөцийг оновчтой хуваарилах, хүний нөөцийг нэмэгдүүлэх, чадавхжуулах, цахим үйлчилгээг сайжруулахад анхаарах хэрэгтэй.

Нээлттэй Дорноговь – 70106

Дорноговь аймаг нь 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 11/01 тоот ИТХ-ын тогтоолоор “Нээлттэй Дорноговь аймаг” зорилтот хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөр нь 2023-2024 оны 1 дүгээр улирал дуустал нийт 15 сарын хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Тус хөтөлбөрийн төсөв нь “Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага” хөтөлбөрийн хүрээнд батлагдсан төсвөөс орон нутагтаа хуваарилтаа хийж зарцуулж байгаа тул “Нээлттэй Дорноговь” хөтөлбөрийн гүйцэтгэлийг аймгаас ирүүлсэн мэдээлэл тулгуурлан үнэлсэн.

“Нээлттэй Дорноговь” хөтөлбөр нь Дорноговь аймгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, засаглалын ил тод байдлыг хангах, аймгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилготой орон нутгийн хөгжлийн хөтөлбөр юм. Энэхүү хөтөлбөр нь иргэд, төрийн байгууллага болон орон нутгийн бусад талуудын хамтын ажиллагааг сайжруулж, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог дэмжих зорилготой байдаг.

"Нээлттэй Дорноговь" хөтөлбөрийн гол зорилгууд:

1. Ил тод, нээлттэй засаглал: Төрийн үйлчилгээг иргэдэд ил тод, хүртээмжтэй байдлаар хүргэж, мэдээлэл, шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах.
2. Иргэдийн оролцоо: Иргэдэд чөлөөтэй мэдээлэл авах, санал бодлоо илэрхийлэх боломжийг бүрдүүлэх замаар аймгийн хөгжилд оролцох боломжийг нэмэгдүүлэх.
3. Нийгэм, эдийн засгийн хөгжлийн дэмжлэг: Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд иргэдийн санаачилгыг тусгах.
4. Хариуцлагатай засаглал: Орон нутгийн төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх.


Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Иргэдэд мэдээлэл хүргэх, санал авах уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулах.
- Олон нийтийн санал, хэрэгцээнд тулгуурлан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх.
- Мэдээллийн ил тод байдлыг хангах үүднээс цахим хуудас болон нийгмийн сүлжээгээр дамжуулан мэдээлэл түгээх.
- Орон нутгийн иргэдэд зориулсан сургалт, семинар, уулзалт зохион байгуулах.

Үр дүн: "Нээлттэй Дорноговь" хөтөлбөрийн ачаар аймгийн иргэдийн оролцооны түвшин нэмэгдэж, орон нутгийн засаглал ил тод, хариуцлагатай болж, орон нутгийн хөгжлийн асуудлууд илүү нээлттэйгээр шийдвэрлэгддэг. "Нээлттэй Дорноговь" арга хэмжээний хүрээнд айл өрхийн бичил цэвэрлэх байгууламжийн худалдаа суурилуулалтын чиглэлээр "Юнилоос" ХХК, стандартын бие засах газрын чиглэлээр "Пластик центр" ХХК-ыг урьж оролцуулан, 14 сумын 1000 гаруй иргэнд танилцуулж гарын авлага материал түгээсэн.

Энэхүү ажлын хүрээнд Гэр хороолол, аялал жуулчлалын газруудын ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлагад нийцүүлэх чиглэлээр Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2 удаагийн албан бичгийг сумдад хүргүүлж худалдаа үйлчилгээ, шатахуун түгээх станц зэрэг 13 аж ахуйн нэгж стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болсон. Орон нутгийн төсвийн 157.5 сая төгрөгийн санхүүжилтээр Сайншанд сумын наадмын талбайн 5 цэгт, Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газрын Энергийн төвийн орчинд 1 цэгт, Даланжаргалан сумын Халзан-Уул рашаан сувилал, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мод үржүүлгийн талбайд нэг нийт 8 стандартын шаардлага хангасан нийтийн ариун цэврийн байгууламж шинээр байгуулан ашиглалтад оруулсан¹³.

ЗУРАГ № 19 АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦ, ХААЛНЫ ТООГООР, ОНЫ ДҮНГЭЭР



"Алсын хараа-2050" Монгол улсын Засгийн газрын урт хугацааны хөгжлийн бодлогын "Хөдөөгийн сэргэлт" зорилтын хүрээнд орон нутагт шилжин суурьшсан иргэдэд ипотекийн зээлийг 2023-2024 онд нийт 28 хүнд 2.4 тэрбум төгрөгийг олгосон. Цаашид Дорноговь аймгийн зүгээс шилжин ирсэн болон суурьшмал иргэдийн амьдрах орчин нөхцлийг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нэг бол аймгийн орон сууцны нөхцөл юм. Аймгийн Засаг даргын "Хөгжлийн төлөө хамтдаа-2" үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд аймгийн

иргэдийг хямд өртөгтэй орон сууцаар ханган амьдралын чанарыг сайжруулах зорилгоор 2023 онд орон нутгийн хэмжээнд анх удаа Түрээсийн орон сууц хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд үүний хүрээнд жил бүр ашиглалтад оруулсан орон сууцны хэмжээ өссөн байна.

¹³ Эх сурвалж: Дорноговь аймгийн статистикийн хэлтэс. Дорноговь аймгийн 2023 оны статистикийн эмхэтгэл.

"Сайншанд сумын газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар тусгагдсан нийт 43 нэгж талбарыг нийслэлээс хөдөө орон нутагт шилжин суурьсан 7 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр газар эзэмшүүлсэн бол 6 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр өмчлүүлсэн.

Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 79%

Нээлттэй Дорноговь хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 3,180.0 сая төгрөг төлөвлөгдсөн бөгөөд үүнээс 2024 оны эхний 6 сард 2,700.0 сая төгрөг хуваарилсан. Нийт төсвийн 79 хувьтай тэнцэх буюу 2,143.3 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 11%

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Шилжин ирсэн иргэд” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 11% байна.

Хөтөлбөрийн гүйцэтгэл: 11.3%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлттэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 11.3 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: -68.1%

Хөтөлбөрийн үр ашиг нь -68.1 хувь буюу “үр ашиггүй” гарсан.

ЗУРАГ № 20 НЭЭЛТТЭЙ ДОРНОГОВЬ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ



Аргачлал: Шилжин ирсэн иргэдийн тооны биелэлтээр тооцдог.

Ахиц дэвшил: "Алсын хараа-2050" Монгол улсын Засгийн газрын урт хугацааны хөгжлийн бодлогын “Хөдөөгийн сэргэлт” зорилтын хүрээнд орон нутагт шилжин суурьшсан иргэдэд ипотекийн зээлийг 2023-2024 онд нийт 28 хүнд 2.4 тэрбум төгрөгийг олгосон.


"Сайншанд сумын газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар тусгагдсан нийт 43 нэгж талбарыг нийслэлээс хөдөө орон нутагт шилжин суурьшсан 7 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр газар эзэмшүүлсэн бол 6 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр өмчлүүлсэн.

Анхаарах асуудал: Тусгайлсан хөтөлбөрийг төсвийн хөтөлбөрийн хуваарилалт дээр тусад нь батлуулж хэрэгжүүлэх нь үр дүнг тооцоход хялбар болох боломжтой.

Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх – 70426

Засгийн газрын 2016 оны “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” 09 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын 2016 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн “Орон нутгийн өмчийн газар байгуулах тухай” А/429 дугаартай захирамжаар худалдан авах ажиллагааны алба, Орон нутгийн өмчийн албыг нэгтгэн Орон нутгийн өмчийн газар болгон

ЗУРАГ № 21 Аймгийн нийт төрийн болон орон нутгийн өөрчлөн байгуулагдан ажиллаж байна. ӨМЧИЙН БҮТЭЦ



Дорноговь аймгийн нийт төрийн болон орон нутгийн өмчийн хэмжээ 2022 оны тооллогын үр дүнд нийт 290. тэрбум төрийн өмч тоологдсон бөгөөд энэ нь 2016 онтой харьцуулахад 70 хувиар буюу 143.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нийт хөрөнгийн 61 хувь буюу 176.7 тэрбум төгрөгийн хөрөнгийг барилга байгууламж, 13 хувь буюу 37.3 тэрбум хөрөнгийн машин тоног төхөөрөмж,

үлдсэн 26 хувийг бусад биет болон биет бус хөрөнгө эзэлж байна¹⁴.

Эдгээр хөрөнгө нь нийт 10 төрлийн 267 байгууллагад харьяалагдаж байгаа бөгөөд 2016 онтой харьцуулахад 122 байгууллагаар нэмэгдсэн байна. Иймд тасралтгүй өсөн нэмэгдэж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг төсөв, санхүүтэй уялдсан, үр дүнтэй зөв удирдлагаар хангаж, үр ашгийг нэмэгдүүлэхээр зохион байгуулах шаардлага үүсэж байна.

Дорноговь аймгийн 2024 оны АХЖТ-нд төрийн өмчийн бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд “Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашгийг 20 хувиар нэмэгдүүлнэ” гэж тусгасан бол төсвийн хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг Орон нутгийн өмчийн байгууллагын өмч хөрөнгийн ашиглалтын гэрээний хэрэгжилтийн хувиар тогтоосон.

ТЕЗ-ын 2024 оны хагас жилийн санхүүгийн байдлын тайланд 133,861,1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй ба үүнээс барилга байгууламж 1.129 ширхэг, бусад үндсэн хөрөнгө 26.190 ширхэг бүртгэлтэй байна.

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 17/02, 18/03, 19/02 дугаар тогтоолуудаар хөрөнгө акталж данснаас хасах 13 байгууллагын 477 нэр төрлийн 1.2 тэрбум төгрөг, орон нутгийн өмчөөс орон нутгийн өмчит шилжүүлэх 18 байгууллагын 714 нэр төрлийн 478.6 сая төгрөг, орон нутгийн өмчөөс төрийн өмчит шилжүүлэх 2 байгууллагын 7116 нэр төрлийн 934.4 сая төгрөг, орон нутгийн өмчөөс иргэнд хувьчлах 2 байгууллагын 214.9 сая төгрөг, худалдан борлуулах 1 байгууллагын 28.0 сая төгрөг, өртөг нэмэгдүүлж ашиглалтын хугацаа сунгах 6 байгууллагын 788 нэр төрлийн 562.4 сая төгрөг, нийт орон нутгийн өмчит 42 байгууллагын 9098 нэр төрлийн 3.4 төгрөгийн хөрөнгийн хөдөлгөөний материалыг хэлэлцүүлэн батлуулсан.

Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 55%

Төрийн өмчийг хэрэгжүүлэх хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 606.0 сая төгрөг төлөвлөгдсөн бөгөөд үүнээс 2024 оны эхний 6 сард 339.9 сая төгрөг хуваарилсан. Нийт төсвийн 55 хувьтай тэнцэх буюу 186.3 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 95%

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Орон нутгийн өмчийн байгууллагын өмч хөрөнгийн ашиглалтын гэрээний хэрэгжилт” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 95% байна.

Хөтөлбөрийн гүйцэтгэл: 95.2%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлттэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 95.2 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: 40.4%

¹⁴ Эх сурвалж: Засаг даргын 2022 оны “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын, үзлэг тооллогын ажлыг зохион байгуулах тухай” А/262 дугаар захирамж гарч ажлын хэсгийн тайлан.

Хөтөлбөрийн үр ашиг нь 40.4 хувь буюу “үр ашигтай” гарсан.

ЗУРАГ № 22 Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн биелэлт



Аргачлал: Орон нутгийн төсвийн байгууллагын тоо/Өмч ашиглалтын гэрээний хэрэгжилт ирүүлсэн байгууллагын тоо*100%

Ахиц дэвшил: Орон нутгийн төсвийн байгууллагуудтай байгуулсан өмч хөрөнгийн ашиглалтын гэрээгээ дүгнэн шалгуур үзүүлэлт болгон оруулж жил бүр тооцон хөрөнгийн менежментийг сайжруулах, дотоод үр ашгийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн.

Анхаарах асуудал: Бодлогын баримт бичгийн шалгуур үзүүлэлттэй нэг үр дүнг хангах шалгуур үзүүлэлтийг тодорхойлох шаардлагатай.

Худалдан авах ажиллагаа – 70418

Засгийн газрын 2016 оны “Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн “Худалдан авах ажиллагааны газар байгуулах тухай” А/742 дугаартай захирамжаар худалдан авах ажиллагааны алба байгуулагдан ажиллаж байна.

Дорноговь аймгийн 2024 оны төсөв батлах тухай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 15/08 дугаар тогтоолоор 134 төсөл арга хэмжээний 99.6 тэрбум төгрөг батлагдсаны дагуу аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах 2024 оны төлөвлөгөөг төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулсан. Үүнээс аймгийн Засаг даргын захирамжаар 27.5 тэрбум төгрөгний 69 төсөл арга хэмжээг захиалагчийн эрх шилжүүлсэн. Аймгийн Засаг даргын Тамгын газраас 205.0 сая төгрөгний 1 төсөл арга хэмжээ нэмэгдэж ирсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар яамдуудаас 10 төсөл арга хэмжээний 24.7 тэрбум төгрөгний эрх шилжиж ирсэн.

Хагас жилийн байдлаар нийт цахим системээр зарлагдах 66 төсөл арга хэмжээнээс 40 төсөл арга хэмжээг зарласан. Үүнээс: 8 төсөл арга хэмжээний 1.4 тэр бум төгрөгний гэрээ байгуулсан. 6 төсөл арга хэмжээг нээж нарийвчилсан үнэлгээ хийгдэж байна. 4 төсөл арга хэмжээ хүчингүй болсон. 20 төсөл арга хэмжээний тендерийг нээнэ. Сангийн яаманд 2 төсөл арга хэмжээнд гомдол гарсан. Ажлын тоо хэмжээ хүлээгдэж байгаа 21 төсөл арга хэмжээ байна. Гүйцэтгэл 60.6 хувьтай байна. Сумдруу эрх шилжсэн 69 төсөл арга хэмжээнээс цахим системээр зарлагдах 61 төсөл арга хэмжээний 53 төсөл арга хэмжээ зарлагдсан байна. Гүйцэтгэл 86.8 хувьтай байна. /Хилийн хамгаалах байгууллага руу 8 төсөл арга хэмжээ/

Аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд “Төрийн бүтээмжийн сэргэлт” зорилгын хүрээнд “Төрийн худалдан авалтын үр ашгийг 5 хувиар нэмэгдүүлнэ” зорилтыг тодорхойлсон. Тус үр дүнгийн хүрээнд “Төрийн худалдан авалт” хөтөлбөрийг төлөвлөж, Аймгийн 2024 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд төлөвлөөний хэрэгжилтийг 100 хувь байхаар төлөвлөсөн бол хагас жилийн байдлаар гүйцэтгэл 50 хувь байна. Аймгийн ЖХТ-ний гүйцэтгэлийн дагуу худалдан авах ажиллагааны хөтөлбөрт “Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулиар Дорноговь аймагт 17 төсөл арга хэмжээний 44,9 тэрбум төгрөг батлагдсан. Үүнээс орон нутагт худалдан авах ажиллагааг зохион

байгуулах 10 төсөл арга хэмжээний эрх шилжиж ирсэн. 05 дугаар сарын 31-ний өдрөөр 10 төсөл арга хэмжээний цахим тендерийг зарлаж 100 хувийн гүйцэтгэлтэй байна. Орон нутгийн 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх нийт 65.5 тэрбум төгрөгийн 134 төсөл, арга хэмжээ батлагдсан. Тухайн онд батлагдсан төсөл арга хэмжээнээс аймагт худалдан авах ажиллагааг зохион байгуулах 56 төсөл, арга хэмжээнээс 45 төсөл арга хэмжээг зохион байгуулж 83.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Сумдад эрхийг нь шилжүүлсэн 71 төсөл арга хэмжээнээс 49 ажлын тендерийг зарлаж 69.1% гүйцэтгэлтэй явагдаж байна” туссан байна.

Иймд худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн үр дүн эх сурвалж болон тооцсон хугацаа, арга зүйгээс шалтгаалан зөрүүтэй байдлаар тайлагдаж байгааг цаашид сайжруулах шаардлагатай.

Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 70%

Худалдан авах ажиллагаа хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 388.3 сая төгрөг төлөвлөгдсөн бөгөөд үүнээс 2024 оны эхний 6 сард 214.8 сая төгрөг хуваарилсан. Нийт төсвийн 70 хувьтай тэнцэх буюу 150.6 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 87%


Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын арга хэмжээний худалдан авах ажиллагааг бүрэн зохион байгуулна.” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 87% байна.

Хөтөлбөрийн гүйцэтгэл: 87.%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлттэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 87 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: 16.7%

ЗУРАГ № 23 ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ



Аргачлал: Нийт батлагдсан төсөл арга хэмжээ/амжилттай хэрэгжсэн төсөл арга хэмжээ*100%

Ахиц дэвшил: АЖХТ-ний шалгуур үзүүлэлт болон төсвийн хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтээ ижил тогтоон тухайн шалгуур үзүүлэлтийг тогтвортой, үр дүнг бодитоор тооцох боломжийг бүрдүүлсэн.

Анхаарах асуудал: Тендерт оролцогчийн ирүүлсэн цахим материалын мэдээллийг системд оруулж шийдвэр үнэлгээнд хамааруулдаг байх мөн амжилттай хэрэгжүүлсэн буюу хэрэгжилтийг тооцох арга зүйг баталгаажуулж, бүх шатны бодлогын баримт бичгийн гүйцэтгэл, тайлагналын хэрэгжилтийг ижил болгох нь цаашид харьцуулах, эх сурвалж баттай байх нөхцлийг хангана.

Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага – 70429

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 327 дугаар тогтоолоор санхүүгийн хяналт шалгалтын чиг үүрэг Сангийн яаманд шилжсэнтэй холбогдуулан аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Санхүүгийн хяналт шалгалтын хэлтэс нь аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг болон

Санхүүгийн хяналт, аудитын алба нэртэйгээр шинээр байгуулагдан, аймгийн засаг даргын 2019 оны 07-р сарын 31- ний өдрийн А/661 дугаар захирамжаар тус байгууллагын бүтэц орон тоог 10 хүний бүрэлдэхүүтэйгээр шинэчлэн баталж үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус онд төсвийн 66 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт, 57 байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийгдэхээс 2024 оны хагас жилийн байдлаар 18 байгууллагад төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалт, 14 байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит тус тус хийж гүйцэтгэсэн. Шалгалтаар 213.2 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрч, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 131 акт тогтоон, 3 албан шаардлага бичиж 161.3 сая төгрөгийн төлбөрийг барагдуулсан.

- 2010-2021 онд тогтоогдсон актны төлбөрийн 4.2 тэрбум төгрөгийн үлдэгдлээс тайлант хугацаанд 2.3 тэрбум төгрөгийн төлбөрийг барагдуулж, өмнөх оны актны төлбөрийн барагдуулалт 54.1 хувьтай хэрэгжсэн.

Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 70%

Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдлийн удирдлага хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 596.1 сая төгрөг төлөвлөгдсөн бөгөөд үүнээс 2024 оны эхний 6 сард 314.0 сая төгрөг хуваарилсан. Нийт төсвийн 70 хувьтай тэнцэх буюу 219.9 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 36%

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Төсөв санхүүгийн сахилга бат хөрөнгийн үр ашгийг дээшлүүлнэ” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 36% байна.

Хөтөлбөрийн гүйцэтгэл: 35.8%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлтэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 35.8 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: -34.2%

Хөтөлбөрийн үр ашиг нь -32.2 хувь буюу “үр ашиггүй” гарсан.

ЗУРАГ № 24 САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТ, ЭРСДЛИЙН УДИРДЛАГЫН ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ



Аргачлал: Барагдуулсан зөрчлийн мөнгөн дүнг сая төгрөгийн хэмжээгээр тооцно.

Ахиц дэвшил: Төрийн бүтээмжийг дээшлүүлэх хүрээнд бодлогын баримт бичиг болон хөтөлбөр, үр дүнгийн тайлагнал дээр шалгуур үзүүлэлт тодорхойлон төлөвлөж, хянаж байгаа нь дэвшилттэй байна.

Анхаарах асуудал: Илрүүлсэн зөрчлийн мөнгөн дүнгээр тухайн хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг тогтоосон нь зөрчил их байж, актын төлбөр их тавигдах нь сайн мэтээр сөрөг утгыг илэрхийлж байгаа тул шалгуур үзүүлэлтийг солих. Тухайн жилд хийхээр төлөвлөсөн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэх явцад удирдах дээд шатны байгууллага, албан тушаалтны шийдвэрүүдээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт олноор хийгддэг нь тухайн жилийн төлөвлөгөөт

хяналт, шалгалтууд хугацаандаа хийгдэхгүй байх, төлөвлөгөөний биелэлт хангагдахгүй байх асуудал үүсч байна.

Хүрээлэн буй орчин

Хүрээлэн буй орчны бодлого удирдлага хөтөлбөр сумдад, хүрээлэн буй орчны бохирдол доройтол хөтөлбөр нь Аймгийн засаг даргын тамгын газрын удирдлага дор хэрэгжиж, ногоон хөгжил, иргэдийн амьдрах таатай орчныг бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах зэрэг олон талт зорилтын хүрээнд хэрэгждэг.

ЗУРАГ № 25 ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ, АНГИЛЛААР



Дорноговь аймаг 10 947.2 мянган га газар нутагтай бөгөөд 2023 оны эцэст уг газар нутгийн 9352.4 (85.4 %) мянган га нь хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 1112.6 (10.2 %) мянган га нь улсын тусгай хэрэгцээний газар, 217.7 (2.0 %) мянган га нь хот, тосгон бусад суурин газар, 158.6 (1.4 %) мянган га нь ой сан бүхий газар, 65.1 (0.6 %) мянган га нь зам, шугам сүлжээний газар, 27.8 (0.4%) мянган га нь усны сан бүхий газар байна. Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллаар 2023 онд хот, тосгон бусад суурин газарт 6.3 мянган га, зам, шугам сүлжээний газарт 2.1 мянган га газрыг ашиглалтанд олгожээ¹⁵.

Хүрээлэн буй орчны чиглэлээр 2024 оны эхний хагас жилд аймгийн хэмжээнд дараах арга хэмжээ зохион байгуулагдсан.

- Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 200,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын хүн амын ундны усан хангамжийн эх үүсвэрийн 1 худагт усны хатуулаг, хүнцэл бууруулах төхөөрөмж, Улаанбадрах, Мандах сумдад 40,0 сая төгрөгөөр 2 худагт ус цэвэршүүлэх төхөөрөмж, Орон нутгийн хөгжлийн сангийн 5,0 сая төгрөгөөр Өргөн суманд 1 худаг, Эрдэнэ суманд 100,0 сая төгрөгөөр 3 худаг нийт 7 ус хангамжийн эх үүсвэрийн худгуудад 345,0 сая төгрөгийн санхүүжилтээр ус цэвэршүүлэх, зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх төхөөрөмж суурилуулж усны чанар, стандартыг сайжруулсан.

- (2) 2024 онд Усны чанар, стандартыг сайжруулах ажлын хүрээнд Улаанбадрах суманд аймаг, орон нутгийн төсвийн нийт 240,0 сая төгрөгийн хөрөнгөөр тус сумын 2 дугаар багийн Хонгор, Цэвүүн нэртэй 2 худаг, 3 дугаар багийн Наймаа, Гүнсүхайт нэртэй 2 худагт ус цэвэршүүлэх, зөөлрүүлэх, усны хатуулаг, хүнцэл бууруулах төхөөрөмж суурилуулах, худгийн барилга байгууламж барих ажил хийхээр төлөвлөн ажлыг эхлүүлээд байна.

- Дэлгэрэх суманд үйл ажиллагаа явуулдаг “Дэртийн булаг”ХХК-ний 250,0 мянган төгрөгийн санхүүжилтээр тус сумын хүүхдийн цэцэрлэгийн 1 худагт бага оврын ус цэвэршүүлэх, зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулах ажил хийгдсэн. аймгийн Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний 2023 оны 186,4 сая төгрөгийн санхүүжилтээр Сайншанд суманд 2 цэгт цэвэршүүлсэн усны төв байгуулах захиалагчийн эрх шилжүүлсний дагуу "Баялаг говь" шалгарч 6 сард багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

- Ахмадын сувилал, Хүүхдийн зуслан, Иргэдийн цэцэрлэгт хүрээлэнгийн мод услах зориулалтын усалгааны автомашин худалдан авсан, Сайншанд сумын Ерөнхий боловсролын сургуулиудад “Говийн Эко сургууль” төслийг төр, хувийн хэвшлийн оролцоотой 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 04 дүгээр сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулан ангилан ялгах цэг байгуулж хог хаягдлын талаар соён гэгээрүүлэх нөлөөллийн ажилд 7347 сурагчийг хамруулж, 18000 ширхэг хуванцар савыг цуглуулан түүхий эдийн нөөцөө бүрдүүлж, орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулсан.

Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 55%

¹⁵ Эх сурвалж: Дорноговь аймгийн статистикийн хэлтэс. Дорноговь аймгийн 2023 оны статистикийн эмхэтгэл.

Аймгийн ИТХ-аар баталсан 2024 оны төсвийн тогтоолын дагуу “Хүрээлэн буй орчин” хөтөлбөрт төсвийн “Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага”, “Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол” хөтөлбөрүүдэд батлагдсан төсвийг багтаасан байна.

Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 1,707.2 сая төгрөг төлөвлөгдсөн бөгөөд үүнээс 2024 оны эхний 6 сард 1,041.5 сая төгрөг хуваарилсан. Нийт төсвийн 55 хувьтай тэнцэх буюу 615.0 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 33%

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Байгаль орчны салбарын хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 33% байна.

Хөтөлбөрийн гүйцэтгэл: 33.0%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлттэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 33 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: -22%

Хөтөлбөрийн үр ашиг нь -22 хувь буюу “үр ашиггүй” гарсан.

Зураг № 26 Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн биелэлт



Аргачлал: Зохион байгуулсан арга хэмжээний тооны хэрэгжилтээр тооцно.

Ахиц дэвшил: Хүрээлэн буй орчны бодлого, хэрэгжилтэд хамаарах хоёр хөтөлбөрийг нэгтгэн тооцож, аймаг, сумын нийт үр дүнгээр хөтөлбөрийн үр дүнг тооцож байгаа нь дэвшилттэй. Цаашид төсвийн төлөвлөх, хуваарилах явцад нэг хөтөлбөрийг ашиглах нь зүйтэй.

Анхаарах асуудал: Зохион байгуулсан арга хэмжээний тоо буюу арга хэмжээний шалгуур үзүүлэлт сонгосон нь тухайн хөтөлбөрийн бодит үр дүнг хэмжих боломжгүй болгож байна. Иймд цаашид байгаль орчин, хүрээлэн буй орчин болон иргэдийн амьдрах орчинд үзүүлэх үр нөлөөг багтаасан, хэмжих боломжтой шалгуур үзүүлэлтийг тогтоох шаардлагатай.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх – 71413


Дорноговь аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэх нь экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, орон нутгийн хөгжилд чухал ач холбогдолтой. Тус бүс нутагт байгалийн баялгийн олборлолт, усны эх үүсвэрийн хомсдол, уур амьсгалын өөрчлөлт зэрэг асуудлууд нөлөөлж байгаа тул байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай байдаг.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлууд

1. Усны нөөцийг хамгаалах: Усны эх үүсвэрийг хамгаалж, нөхөн сэргээх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах. Усны хомсдол нь тус бүс нутагт тулгарч буй гол асуудлын нэг тул энэ чиглэлд анхаарах нь зүйтэй.

2. Төлөвлөлт ба хяналт: Уул уурхайн үйл ажиллагаа, газар ашиглалтын төлөвлөгөөг нарийвчлан гаргаж, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээг заавал авах.
3. Ойн зурвас байгуулах: Цөлжилтөөс сэргийлэх зорилгоор мод тарих, ойн зурвас байгуулах, ургамлын төрөл зүйлүүдийг хамгаалж, нөхөн сэргээх ажлуудыг орон нутгийн иргэдийн оролцоотой хэрэгжүүлэх.
4. Хог хаягдлын менежмент: Хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах, хаягдал багатай амьдрах соёлыг түгээх ажлуудыг аймгийн түвшинд хэрэгжүүлэх.
5. Байгаль орчны боловсрол: Орон нутгийн иргэд, сурагчдад байгаль орчны талаар мэдлэг олгох, орчиндоо хариуцлагатай хандахыг дэмжих сургалтуудыг тогтмол зохион байгуулах нь байгаль хамгаалах ажлыг тогтвортой хэрэгжүүлэхэд тусална.

ЗУРАГ № 27 БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ ХӨТӨЛБӨРИЙН БҮТЭЦ, ЗОРИУЛАЛТААР



Дорноговь аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зориулалтаар дараах гурван чиглэлээр төсөв батлагдсан байна. Нийт төсвийн 45 хувь буюу 1.2 тэрбум төгрөг сумдад байх байгаль орчны чиглэлийн төрийн албан хаагч, албадын үйл ажиллагааны урсгал зардалд хуваарилагдсан ба хагас жилийн байдлаар 102.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу жилийн нийт төсвийн 8 хувь, хагас жилийн төсвийн 16 хувь зарцуулагдсан. Төсвийн 39 хувь буюу 1.1 тэрбум төгрөг аймгийн байгаль орчны албаны жилийн үйл ажиллагааны урсгал зардалд 1.1 тэрбум төгрөг батлагдсан. Хагас жилийн байдлаар 291.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу жилийн нийт төсвийн 27 хувь, хагас жилийн төсвийн 54 хувь зарцуулагдсан. Нийт төсвийн үлдсэн нь буюу 16 хувь буюу 427.7 сая төгрөг нь нөхөн сэргээлтийн санд хуваарилагдсан байна. Эхний хагас

жилийн байдлаар 13.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй бөгөөд төсвийг эхний 6 сард бүрэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч 3 хувийн гүйцэтгэл гарсан байна¹⁶.

Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь 2024 оны хагас жилд орон нутгийн гүйцэтгэх удирдлагын засаглал хөтөлбөрт 3 арга хэмжээний 971.5 сая.төг-ийн төсөвтэй, 24 орон тоотой ажиллахаас 692.7 зардалтай, 21 орон тоотой ажиллаж, зардлыг 278.8 сая.төг-өөр буюу 28%-иар, орон тоог 3 хүнээр хэмнэсэн байна. Зардлыг арга хэмжээ тус бүрээр задалбал:

- Үндсэн үйл ажиллагааны зардалд (80101) 970,9 сая.төг-ийн төсөвтэй ажиллах ёстойгоос 992,1 сая.төг-ийн гүйцэтгэлтэй ажиллаж төсвийг 28%-иар хэмнэсэн шалтгаан нь 3 орон тоо дутуу ажилласнаас болсон.
- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг (80802) зардалд нийт 21 албан хаагчдын хүүхдүүдэд хүүхдийн баярын бэлэг 522,000.төг зарцуулсан.
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал (81701) зардалд 586,4 сая.төг-ийн төсвөөс 402,0 сая.төг-ийг зарцуулж 183,7 сая.төгрөг буюу 31%р хэмнэгдсэн.
- Нэмэлт санхүүжилт (80102) зардалд 31,1 сая төг-ийн төсвөөс 15,5 сая төг-ийг зарцуулж 15,6 сая төгрөг буюу 50%р хэмнэгдсэн.

Аймгийн ХЖТ-д байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хүрээнд нийт 6 хөтөлбөр, 27 хөтөлбөрийн хүрэх үр дүн, 27 шалгуур үзүүлэлтээр хэмжихээр төлөвлөсөн. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагааны нийт үр дүнгээр төсвийн ерөнхийлөн захирагчийн “Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх” хөтөлбөрийн үр дүн илэрхийлэгдсэн байна.

- “Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашгийг 5 хувиар нэмэгдүүлнэ.” Зорилгыг тодорхойлж “Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 9

¹⁶ Эх сурвалж: Дорноговь аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс.

хувиар нэмэгдүүлнэ” үр дүнд чиглэсэн “Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалал” хөтөлбөрийн хүрээнд нийт 2 хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийн хүрээнд үйл ажиллагааг төлөвлөн, хэрэгжүүлсэн байна.

- “Нийт усны хэрэглээнд эзлэх цэнгэг усны хэрэглээг 9.6 хувиас хэтрүүлэхгүй.” зорилгыг тодорхойлж “Ус хэрэглээний үр ашигт байдлыг 3 хувиар нэмэгдүүлнэ.” үр дүнд чиглэсэн “Усны нөөцийн зохистой ашиглалт хөтөлбөр”, “Суурин газрын усан хангамж” хөтөлбөрүүдийн хүрээнд нийт 8 хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийн хүрээнд үйл ажиллагааг төлөвлөн, хэрэгжүүлсэн байна.

- “Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг 1.07 хувьд хүргэнэ.” зорилгыг тодорхойлж “Тарьсан модны ургалтыг 70 хувьд хүргэнэ.” үр дүнд чиглэсэн “Ойжуулалт” хөтөлбөрийн хүрээнд нийт 4 хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийн хүрээнд үйл ажиллагааг төлөвлөн, хэрэгжүүлсэн байна.

- “Цөлжилтийн нэн хүчтэй, хүчтэй зэрэглэлд өртсөн газрыг 2.7 хувиар бууруулна.” зорилгыг тодорхойлж “Бэлчээрийн даац хэтрэлтийг 1 хувиар бууруулна.” үр дүнд чиглэсэн “Мал аж ахуй хөтөлбөр” хөтөлбөрийн хүрээнд нийт 13 хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийн хүрээнд үйл ажиллагааг төлөвлөн, хэрэгжүүлсэн байна.

- “Монгол орны биологийн олон янз байдлыг 2020 оны түвшинд хадгална.” зорилгыг тодорхойлж “Ашиглалтад өртөмтгий амьтан, ургамлын ашиглалтын нөөцийг бүсчлэн бий болгоно.” үр дүнд чиглэсэн “Биологийн төрөл зүйлийг хамгаалах үндэсний хөтөлбөр” хөтөлбөрийн хүрээнд нийт 2 хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийн хүрээнд үйл ажиллагааг төлөвлөн, хэрэгжүүлсэн байна.

Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 26%

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 2,746.2 сая төгрөг төлөвлөгдсөн бөгөөд үүнээс 2024 оны эхний 6 сард 1,592.5 сая төгрөг хуваарилсан. Нийт төсвийн 26 хувьтай тэнцэх буюу 407.5 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 40%

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Байгаль орчны салбарын хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 40% байна.

Хөтөлбөрийн гүйцэтгэл: 40.0%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлттэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 40 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: 14.4%

Хөтөлбөрийн үр ашиг нь 14.4 хувь буюу “үр ашигтай” гарсан.

Зураг № 28 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хөтөлбөрийн биелэлт



Аргачлал: Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор хэмжинэ.

Ахиц дэвшил: АЖХТ-д Агаар, орчны чанарыг стандарт түвшинд хүргэх, Ногоон хөгжлийн сэргэлт зэрэг хөтөлбөрийн хүрэх үр дүнг тухайн төсвийн хөтөлбөрийн шалгуур үзүүлэлттэй уялдуулан батлуулсан.

Анхаарах асуудал: Зохион байгуулсан арга хэмжээний тоо буюу арга хэмжээний шалгуур үзүүлэлт сонгосон нь тухайн хөтөлбөрийн бодит үр дүнг хэмжих боломжгүй болгож байна. Цаашид бодлогын баримт бичгүүдэд туссан олон талт үйл ажиллагааны үр дүнд бий болж буй нөлөөллийг үнэлэх боломжтой шалгуур үзүүлэлтийг цаашид ашиглах нь зүйтэй.

Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт– 71405

Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт орших 116 газрыг улс болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах ажлыг зохион байгуулсан. Нийт тусгай хамгаалалттай газар нутгийн 0.86 хувийг дархан цаазтай газар, 53.44 хувийг байгалийн нөөц газар, 45.7 хувийг байгалийн болон түүх соёлын дурсгалт газар эзэлж байна. Улс, аймгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэсийг тэмдэгжүүлж 157 ширхэг самбар, 11 ширхэг багана байршуулсан.

Аймгийн ХЖТ-д тус салбарын зорилтыг “Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашгийг 5 хувиар нэмэгдүүлнэ.” гэж тодорхойлсон. Тус хоёр зорилтын хүрээнд “Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 9 хувиар нэмэгдүүлнэ” үр дүнг тодорхойлж, “Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт” хөтөлбөрийг 2 хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтээр хэмжихээр төлөвлөсөн. Үүнд:

1. “Аймгийн нутаг дэвсгэрт амьдарч буй уулын туруутан амьтдын тархац нутгийг хамгаалах, амьдрах орчныг тэтгэх” арга хэмжээнд “Тусгай хамгаалалтад авсан газрын хэмжээ” шалгуур үзүүлэлтээр хэмжиж, 2024 онд нийт 35 га газрыг хамгаалалтад авахаар төлөвлөсөн. Аймгийн хэмжээнд өвөлжилт хүндэрч зэрлэг ан амьтан идэш тэжээлийн хомсдолд орж зүй бус хорогдолд гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2023 оны А/867, 868 дугаар захирамжуудын дагуу иргэн Х.Анхбаяр-тай гэрээг байгуулж нийт 1681 боодол өвс худалдан авсан. Өвөлжилт хүндэрсэн Даланжаргалан суманд 400, Иххэт суманд 270, Өргөн суманд 200, Сайншанд суманд 250, Сайхандулаан суманд 200 нийт 1320 боодол өвсийг сумын Засаг даргын тамгын газарт олгож зэрлэг амьтдын тархац нутагт биотехникийн арга хэмжээ авах ажлыг зохион байгуулсан. Замын булаг, Хонгил цав, Бор өндөр, Хоёр зааны хөндий, Бор овооны тал зэрэг экологийн хувьд ач холбогдолтой газруудыг 122247 га талбайг тусгай хамгаалалтад авахаар төлөвлөсөн байна. Тус арга хэмжээний хэрэгжилт эхний хагас жилийн байдлаар 50 хувь байна.

2. “Биологийн төрөл зүйлийг хамгаалах чиглэлээр сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах” арга хэмжээнд “Зохион байгуулсан арга хэмжээ” шалгуур үзүүлэлтээр хэмжиж, 2024 онд 2 арга хэмжээ хэрэгжүүлэхээр зорьсон. Тайлант хугацааны хагас жилд Эрдэнэ, Өргөн сумдад “Тогтвортой зэрэгцэн оршихуй”, “Биологийн олон янз байдлыг хамгаалах, хулгайн антай тэмцэх” сэдэвт гэрэл зургийн үзэсгэлэн гаргаж, 360 малчдад сургалт зохион байгуулж мэдээлэл өгсөн. Мөн “Амьтны экологи эдийн засгийн үнэлгээ”, зарим туруутан амьтдын танилцуулга зэрэг цахим мэдээллийг 580 хүн үзэж сонирхсон. Тус арга хэмжээний хагас жилийн хэрэгжилт 70 хувь байна.

Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 92%

Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 570.0 сая төгрөг төлөвлөгдсөн бөгөөд үүнээс 2024 оны эхний 6 сард 435 сая төгрөг хуваарилсан. Нийт төсвийн 92 хувьтай тэнцэх буюу 401.2 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 93%

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтыг сайжруулна.” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 93% байна.

Хөтөлбөрийн гүйцэтгэл: 93.%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлттэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 93 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: 1.2%

Хөтөлбөрийн үр ашиг нь 1.2 хувь буюу “үр ашигтай” гарсан.

ЗУРАГ № 29 ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГИЙН ХАМГААЛАЛТ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ



Аргачлал: Тусгай хамгаалтанд авсан газрын хэмжээ /га/

Ахиц дэвшил: АЖХ-ын төлөвлөгөөнд улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 9 хувиар нэмэгдүүлнэ гэж тодорхойлсон нь төсвийн хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болсон.

Анхаарах асуудал: Тусгай хамгаалалттай газар нутгуудыг бүрэн тэмдэгжүүлэх, улс болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтыг сайжруулах, эзэнжүүлэх ажлыг зохион байгуулах.

Нийгмийн халамж – 71902

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр 2023 онд нийгмийн халамжийн сангаас 50171 иргэнд 43940.3 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад хамрагдсан иргэдийн тоо 24666 (2.0 дахин)-аар, олгосон тэтгэвэр, тэтгэмж 33128.3 (4.0 дахин) сая төгрөгөөр тус тус өссөн байна. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн дүн өндөр өсөлттэй байгаа нь 2023 оноос эхлэн Нийгмийн халамжийн сангийн зарцуулалтын төрөлд сар бүр олгодог хүүхдийн мөнгөн тэтгэмжийг мэдээллэж байгаатай холбоотой юм.

ЗУРАГ № 30 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ИРГЭДИЙН ТОО, 2023 ОН



Дорноговь аймагт 2024 оны хагас жилд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлтөд хамрагдах хүсэлт гаргасан 6057 иргэний хүсэлтийг хүлээн авч хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэж 26572 хүүхдэд 10,636.8 сая төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмж, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж тусламж хөнгөлөлтөд 20295 иргэнд 5,229.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 8 иргэнд 9.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс тус тус олгосон. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нийт тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлтөд хамрагдсан хүний тоо 2547-

оор, зарцуулсан мөнгөн дүн 2,249.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн. Эдгээр халамж нь улсын төсвийн нийгмийн халамжийн сангаас санхүүждэг¹⁷.

Орон нутгийн төсөвт батлагдсан нийгмийн халамжийн хөтөлбөр нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй асран хамгаалагчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй асран хамгаалагчид, өрх толгойлсон эх эцэг / 3 буюу түүнээс хүүхэдтэй/ эдгээр иргэдэд өрхийн бизнесд /бизнесийн үйл ажиллагаа/ дэмжлэг болгож шалгарсан төсөлд 3 хүртлэх сая төгрөгийг олгодог. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төслийг 4 сард зарлаж 20 төсөл ирснээс шаардлага хангасан 6 төсөлд 18 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Орон нутгийн төсвийн хөтөлбөрийн хүрэх үр дүнг “Зорилтот бүлгийг халамжийн үйлчилгээнд бүрэн хамруулна” гэж тодорхойлсон нь аймгийн ЖХТ-нд “Нийгмийн халамжийн зорилтот бүлгийн иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлнэ” үр дүнгийн хүрээнд “Зорилтот бүлгийг хэрэгцээнд нийцсэн нийгмийн халамжийн үйлчилгээнд бүрэн хамруулна” зорилготой уялдаж байна. АХЖТ-ний тус хөтөлбөрийн үр дүн нь хөтөлбөр, 13 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд үүнд “Нийгмийн тодорхой бүлэгт чиглэсэн хөтөлбөр” болон нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэмжтэй холбоотой арга хэмжээ багтсан байна.

Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 25%

Нийгмийн халамж хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 146.4 сая төгрөг төлөвлөгдсөн бөгөөд үүнээс 2024 оны эхний 6 сард 73.2 сая төгрөг хуваарилсан. Нийт төсвийн 25 хувьтай тэнцэх буюу 18.0 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 174%

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Зорилтот бүлгийг халамжийн үйлчилгээнд бүрэн хамруулна.” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 174% байна.

Хөтөлбөрийн гүйцэтгэл: 174.%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлттэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 174 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: 149.3%

Хөтөлбөрийн үр ашиг нь 149.3 хувь буюу “үр ашигтай” гарсан.

Зураг № 31 Нийгмийн халамж хөтөлбөрийн биелэлт



Аргачлал: Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэд /өссөн дүнгээр/

Ахиц дэвшил: Нийгмийн халамжийн хөтөлбөрийг хэрэгжүүлж буй зорилготой уялдуулан хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон нь дэвшилттэй.

¹⁷ Эх сурвалж: Дорноговь аймгийн статистикийн хэлтэс. Дорноговь аймгийн 2023 оны статистикийн эмхэтгэл


Анхаарах асуудал: АЖХ-ын төлөвлөгөөнд хөтөлбөрийн хүрэх үр дүнг бүрэн илэрхийлэх шалгуур үзүүлэлтүүд сонгосон боловч төсвийн хөтөлбөрт Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо буюу шаардлага ханган, төсөлд хамрагдсан иргэдийн нийт өссөн дүнг шалгуур үзүүлэлт сонгосон. Иймд орон нутгийн төсөвт батлагдсан тус нийгмийн халамжийн хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг үр дүн, үр нөлөө уялдсан байдлаар тогтоох шаардлагатай бөгөөд өссөн дүнгээр тооцох үндэслэл, хэдэн жилээр тасалбар болгон тооцох зэргийг тодорхой болгох шаардлагатай.

Эрүүл мэнд

Нийгмийн эрүүл мэнд – 71601, Эмнэлгийн тусламж үйлчилгээ – 71602

Аймгийн хүн амын дундаж наслалт 2023 оны жилийн эцсийн байдлаар 72.9 байна. Аймгийн хэмжээнд төр ба хувийн хэвшлийн нийт 117 эрүүл мэндийн байгууллага орон нутгийн

ЗУРАГ № 32 ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ



бүртгэлтэй болон бүртгэлгүй түр оршин суугч, хөдөлгөөнт хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Эрүүл мэндийн газрын мэдээллээр Дорноговь аймагт 2023 онд 116 эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагийн 4 нь эрүүл мэндийн төв, 13 нь сумын эрүүл мэндийн төв, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг 1, аймгийн төвийн нэгдсэн эмнэлэг 1, ортой хувийн эмнэлэг 4, үүдэн хувийн эмнэлэг 31, сувилал 1, эм ханган нийлүүлэх байгууллага 4, хувийн эмийн сан чиглэлээр 50 байгууллага үйл ажиллагаа эрхэлж байна¹⁸.

Тайлант онд тусгай зөвшөөрлийн комисс 6 удаа хуралдаж, 16 асуудлыг 100% шийдвэрлэж, 4 байгууллагад эрүүл мэндийн чиглэлээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатайгаар шинээр олгож, 6 эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийг 5 жилээр сунгалтыг хийснээр 2023 - 2024 онд нийт 7 эмнэлэг, 9 эмийн санд шинээр тусгай зөвшөөрлийг олгож, тусгай зөвшөөрөлтэй эрүүл мэндийн байгууллагын тоо суурь түвшнээс 14%, зорилтот түвшнээс 5%-иар өссөн байна. Тус онд

аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааг өргөтгөж, төмөр замын хэсэгт аймгийн нэгдсэн эмнэлэгийн салбар "Амбулатори-2" - ийг нээснээр ачаалал ихтэй шүд, мэдрэл, хүүхдийн кабинетуудыг ажиллуулж, хүн амд үзүүлэх тусламжийн хүлээгдлийг бууруулсан. Мөн "Дээрэт" олон улсын Энэрлийн байгууллагын 136 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгтэйгээр аймгийн нэгдсэн эмнэлэгт "Эрэгтэйчүүдийн кабинет"-ийг шинээр нээж, тусламж үйлчилгээг цаг алдалгүй орон нутагтаа авах боломжийг бүрдүүлснээр эрчүүдэд үзүүлэх тусламжийн л чирэгдлийг бууруулан ажиллаж байна. 2023 онд орон нутгийн төсвийн 1,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Ханги хилийн боомтод эмнэлгийн 5 ортой барилга шинээр баригдаж, 2024 оноос үйл ажиллагаагаа явуулж, хилийн боомтын албан хаагч, аж ахуй нэгжийн ажилчид, бүс нутгийн малчин иргэд, хөдөлгөөнт хүн ам нийт 1000 гаруй хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэх боломжтой болсон.

Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 47%

Аймгийн ИТХ-аар баталсан 2024 оны төсвийн тогтоолын дагуу “Эрүүл мэнд” хөтөлбөрт төсвийн “Эмнэлгийн тусламж үйлчилгээ”, “Нийгмийн эрүүл мэнд” хөтөлбөрүүдэд батлагдсан төсвийг багтаасан байна.

Эмнэлгийн тусламж үйлчилгээ хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 8.1 тэрбум төгрөг төлөвлөгдсөн бөгөөд үүнээс урсгал зардал нь 4.2 тэрбум буюу 51 хувь, хөрөнгө оруулалтын зардал нь 4.0 тэрбум буюу 49 хувь тус тус эзэлж байна. Тайлант оны эхний 6 сард 4.6 тэрбум төгрөг хуваарилсан. Нийт төсвийн 47 хувьтай тэнцэх буюу 2.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан

¹⁸ Эх сурвалж: Дорноговь аймгийн статистикийн хэлтэс. Дорноговь аймгийн 2023 оны статистикийн эмхэтгэл.

байна. Үүнээс хөрөнгө оруулалтын төсөв 35 хувь, урсгал зардал 59 хувийн тус тус гүйцэтгэлтэй байна.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 100%

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Хүн амын дундаж наслалтын хувийг нэмэгдүүлнэ.” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 100% байна.

Хөтөлбөрийн гүйцэтгэл: 100.0%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлттэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 100 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: 53.1%

Хөтөлбөрийн үр ашиг нь 53.1 хувь буюу “үр ашигтай” гарсан.

ЗУРАГ № 33 ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ



Аргачлал: Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал (ҮСХ-ны даргын 2013 оны 12 сарын 25-ны өдрийн 01/149 тоот тушаал) Шинээр төрсөн (төрөх үеийн) хүүхдийн цаашид үргэлжлэн амьдрах дундаж хугацааг (жил) хэлнэ.

Ахиц дэвшил: АЖХТ-д нийгмийн эрүүл мэнд, эмнэлэгийн тусламж үйлчилгээ гэсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн тухайн шалгуур үзүүлэлтийн үр дүнг ханган ажилласан.

Анхаарах асуудал: ҮСХ-ын статистик тайлан мэдээгээр баталгааждаг шалгуур үзүүлэлт сонгосон ба тухайн үр дүнг шууд болон шууд бусаар хангахад чиглэсэн хөтөлбөрийн хүрэх үр дүнг тооцох шаардлагатай. Улсын төсвийн эрүүл мэндийн салбарын төсвийн хөтөлбөрийн хүрэх үр дүнд “Нийгмийн эрүүл мэнд” салбар 3 үр дүнгийн хүрээнд 7 шалгуур үзүүлэлт, “Эмнэлгийн тусламж, үйлчилгээ” салбар 2 үр дүнгийн хүрээнд 4 шалгуур үзүүлэлтийг тус тус баталсан байна. Дорноговь аймгийн хувьд эрүүл мэндийн салбарын нийгэмд үзүүлэх үр нөлөөг “Дундаж наслалт” шалгуур үзүүлэлтийг авсан нь дэвшилттэй бөгөөд цаашид улсын төсөвт дурдсан зарим шалгуур үзүүлэлтийг судлан “Нийгмийн эрүүл мэнд”, “Эмнэлгийн тусламж үйлчилгээ” хөтөлбөрийг тусад нь төлөвлөх боломж, шаардлагагыг судлаж үзэх нь зүйтэй.

Биеийн тамир спорт – 71701


Дорноговь аймгийн биеийн тамир, спортын салбар спорт цогцолбор, ордон, усан спорт сургалтын төв болон цэнгэлдэх төв зэрэг 4 байгууламжийн хүрээнд нийт хүн амын хэрэгцээнд нийцүүлэн биеийн тамир, спортын салбарын бодлогын үр нөлөөг дээшлүүлэн олон талт, тэгш, хүртээмжтэй чанартай үйлчилгээг хэрэгжүүлэх замаар бие бялдрын боловсролтой, ёс суртахууны төлөвшилтэй, эрүүл чийрэг иргэнийг төлөвшүүлэх зорилгоор үйл ажиллагаа явуулж байна.

ХҮСНЭГТ № 2 БИЕЙН ТАМИРЫН СОРИЛЫН МЭДЭЭЛЭЛ

| Нийт сорилд хамрагдагчид | | | | Сорилд хамрагдагчдын үнэлгээ | | | |
|--------------------------|---------|----------------|---------|------------------------------|------|------|-----|
| Нийт | Эмэгтэй | Илүүдэл жинтэй | Эмэгтэй | А | В | С | Д |
| 3557 | 2069 | 752 | 488 | 707 | 1350 | 1170 | 330 |

Аймгийн 2024 оны хагас жилийн биеийн тамир спортын статистик мэдээгээр нийт иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорил 90.7 хувьтай байна. Өөрөөр хэлбэр 6-64 насны сорилд хамрагдсан нийт 3557 иргэдийн 90.7 хувь нь А-С үнэлгээтэй байна¹⁹.

Зураг № 34 Аймгийн эхний хагас жилийн зохион байгуулагдсан арга хэмжээнд хамрагдагчид



Аймгийн хэмжээнд хагас жилийн байдлаар нийт 29 арга хэмжээ зохион байгуулсан бөгөөд үүнд нийт 5015 тамирчид, иргэд хамрагдсан байна. Мэргэжлийн уралдаан тэмцээнээс гадна олон төрлийн нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байна. Үүнд:

"Шинэ эхлэл" хүүхдийн лигийн тэмцээнийг 27.3 сая төгрөгөөр зохион байгуулж 1000 гаруй өсвөрийн тамирчид, холбоодууд болон дасгалжуулагчдыг оролцуулан, 3 сарын турш үргэлжилж, 10000 гаруй хүн үзсэн. Дорноговь, Өмнөговь, Дундговь аймгийн Засаг дарга нарын ивээл дор Говийн бүсийн шагайн харвааны тэмцээн зохион байгуулагдсан. Тус

тэмцээнд 7 аймгийн 48 багийн 400 гаруй харваачид оролцож 500 гаруй шагайн харваа сонирхогчид үзэж сонирхсон. Энэхүү тэмцээн нь улсын цолтой 80 гаруй харваачид байгаагаараа онцлог болсон. Мөн аймгийн хэмжээнд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг аймгийн аварга шалгаруулах бильярын тэмцээнийг зохион байгуулж 80 гаруй тамирчин оролцож, 150 гаруй хүн үзсэн.

Спортын үйл ажиллагааг дэмжих зорилгоор орчин нөхцлийг сайжруулахад 3 төсөл арга хэмжээний гүйцэтгэлд 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. Аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд "Хэвийн" биеийн жинтэй иргэдийн тоог 5.6 хувиар нэмэгдүүлнэ" гэж салбарын үр дүнг тодорхойлж, "Өдөрт 30 минут дасгал хөдөлгөөн хийдэг иргэдийн тоог 10 хувиар нэмэгдүүлнэ" зорилт тавьсан. Тус зорилтын хүрээнд 3 хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

1. "Нийтийн биеийн тамир" хөтөлбөрийн хүрээнд 7 хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн хүрээнд 7 шалгуур үзүүлэлт бүхий арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд хагас жилийн гүйцэтгэл 70 хувь байна.
2. "Мэргэжлийн спортын хөгжил" хөтөлбөрийн хүрээнд 5 хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн хүрээнд 5 шалгуур үзүүлэлт бүхий арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд хагас жилийн гүйцэтгэл 82 хувь байна.
3. "Үндэсний уламжлалт спортын хөгжил хөтөлбөр" хөтөлбөрийн хүрээнд 3 хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн хүрээнд 3 шалгуур үзүүлэлт бүхий арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд хагас жилийн гүйцэтгэл 77 хувь байна.

Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 41%

Биеийн тамир спорт хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 3,033.7 сая төгрөг төлөвлөгдсөн бөгөөд үүнээс 2024 оны эхний 6 сард 1,644.7 сая төгрөг хуваарилсан. Нийт төсвийн 41 хувьтай тэнцэх буюу 676.5 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 202%

¹⁹ Эх сурвалж: Дорноговь аймгийн Биеийн тамир, спортын газар

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Спортын төрлөөр хичээллэгсэдийн тоог нэмэгдүүлнэ.” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 202% байна.

Хөтөлбөрийн гүйцэтгэл: 202%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлттэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 202 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: 160.4%

Хөтөлбөрийн үр ашиг нь 160.4 хувь буюу “үр ашигтай” гарсан.

ЗУРАГ № 35 БИЕЙН ТАМИРЫН ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ



Аргачлал: Тайлант хугацаанд бүх төрлийн арга хэмжээнд хамрагдсан нийт хүний тоогоор /давхардсан байдлаар/ тооцно.

Ахиц дэвшил: Тус шалгуур үзүүлэлт нь тооцоход хялбар болон аймгийн хэмжээнд биеийн тамир, спортын салбарын бүх арга хэмжээний тоо дүнг нэгтгэн гаргах боломжийг бүрдүүлж байна.

Анхаарах асуудал: Биеийн тамирын салбарын хөтөлбөрийн хүрэх үр дүнг “Спортын төрлөөр хичээллэгсэдийн тоог нэмэгдүүлнэ” гэж тодорхойлсны дагуу “спортоор хичээллэгсэд /хүний тоо/” шалгуур үзүүлэлтээр үр дүнг хэмжиж байна. Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газраас мэдээлсэн хагас жилийн статистик мэдээгээр спортын тамирчдын тоо 3030, арга хэмжээнд хамрагдагчдын тоо 5015 нийт 8045 тамирчид арга хэмжээнд хамрагдсан мэдээлэл байна²⁰. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хагас жилийн тайлангаар:

- Биеийн тамир спортыг бүх нийтэд түгээн дэлгэрүүлэх арга хэмжээнд 9900 орчим хүн оролцсон.
- "Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөнд 8400 орчим хүн оролцсон.
- “Унадаг дугуй” арга хэмжээнд 360 орчим хүн оролцсон.
- Жюү жицүгийн “Дорноговь опен” Дэлхийн чансааны 800 оноо олгох бүсийн зэрэглэлийн Олон улсын тэмцээнийг зохион байгуулж 4 улсын 30-аад клубийн 600 орчим тамирчин оролцсон.
- Өсвөрийн тамирчид, залууст зориулан "Хөгжлийн лиг-2024", "Шинэ эхлэл" хүүхдийн лиг, "Gobi guys" Сагсан бөмбөгийн лигийн тэмцээнийг зохион байгуулж 1500 гаруй тамирчид өрсөлдсөн.
- Шагайн харвааны аймгийн аварга шалгаруулах тэмцээн, Дугуйн тэмцээн, чөлөөт бөх, жүдо бөх, Даам, шатрын өсвөрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн, Боксын аймгийн аварга шалгаруулах тэмцээн, аймгийн ЕБ 1 дүгээр сургуулийн 100 жилийн ойд зориулсан сагсан бөмбөг, волейболын тэмцээн зэрэг Олон улсын болон аймгийн аварга шалгаруулах тэмцээнүүдэд аймаг орон нутагтаа зохион байгуулж давхардсан тоогоор 25772 тамирчин оролцсон.

²⁰ Эх сурвалж: Дорноговь аймгийн Биеийн тамир, спортын газар /тайлант хугацааны нэрээр/. <https://dornogovi.sport.gov.mn/n/6134/>

- Бага олимпийг зохион байгуулах арга хэмжээнд 2000 хүн оролцохоор төлөвлөсөн талаар дурдсан байна.

Эдгээр арга хэмжээний нийт оролцсон тамирчид, хичээллэсэн хүний тоо 45732 болж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны хагас жилийн хөтөлбөр, үр дүнгийн тайлангаар Дорноговь аймаг спортоор хичээллэгсэд 32241 хүн гэж тайлагнасан. Иймд тус шалгуур үзүүлэлтийг тооцох тогтсон арга аргачлал байхгүй, статистик мэдээ зөрүүтэй, олон төрлийн зохион байгуулсан арга хэмжээнд тухайн аймгийн хүмүүсээс гадна оролцсон хүмүүсийг оруулж тооцох эсэх нь тодорхойгүй, ямар арга хэмжээг хамааруулах, “спортоор хичээллэгч” гэсэн тодорхойлолт байхгүй зэрэг нь хөтөлбөрийн үр дүнг бодитой үнэлэх, тооцох боломжийг бүрдүүлээгүй байна.


Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн дагуу “биеийн тамир, спорт” хөтөлбөрийн хүрэх үр дүнг “Идэвхтэй амьдралын хэвшилтэй хүний тоог нэмэгдүүлнэ”, “Тив, дэлхийн спортын амжилтыг нэмэгдүүлнэ.” гэж тодорхойлсноос хөтөлбөрт “6-64 насны бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдсан хүмүүст А, В, С үнэлгээ авсан хүний эзлэх хувь /хүйсээр/” гэж шалгуур үзүүлэлтийг тогтоосон байна. Улсын хэмжээнд тус үзүүлэлтийг 59.0 хувьд хүргэхээр төлөвлөсөн бол Дорноговь аймгийн статистик мэдээгээр тус үзүүлэлт нь 90.7 хувь байна.

Иймд тус хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг чанарын үзүүлэлтэд шилжүүлэх аймгийн бодлогын баримт бичигт туссан салбарын үр дүн эсхүл улсын төсвийн үзүүлэлттэй ижил төстэй байдлаар ашиглах нь илүү хэмжигдэхүйц, бодитой байх боломжийг бүрдүүлнэ.

Соёл урлаг – 71702

Дорноговь аймагт 14 соёлын төв /үүнээс хоёр соёлын ордон/, Саран хөхөө театр, Орон нутгийн музей, Номын сан нийт 17 соёл урлагийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Тус салбар нь хагас жилийн байдлаар 3803 соёл урлагын үзвэр үйлчилгээг, 128423 иргэнд /давхардсан тоогоор/ үзвэр, үйлчилгээ үзүүлсэн байна²¹.

Соёл урлагийн салбар “Ноён хутагтын өв: Өнгөрсөн, одоо, ирээдүй” эрдэм шинжилгээний номыг 500 ширхэг, орон нутгийн соёлын байгууллагууд, уран бүтээлчид, эрдэмтэн судлаачдад танилцуулж, баримтат өв болгон авч үлдсэн. Мөн “Болор эгшиглэн” үндэсний хөгжмийн хамтлаг, ЗУРАГ № 36 СОЁЛ УРЛАГИЙН САЛБАРЫН “Эвийн эгшиг” уртын дууны дугуйлан урлагийн хуртээмж, үйлчлүүлэгчийн тоогоор



тоглолт зохион байгуулж 2000 гаруй хүнд үзүүлж, 100 гаруй уран бүтээлч, хүүхдүүдийг оролцуулсан. Аймаг орон нутгас “Монгол гэр” үзэсгэлэн арга хэмжээнд “Ноён хутагтын өргөө” гэрээр оролцож 9 хоногийн турш Улаанбаатар хотын төв талбайд сурталчлан алдаршууллаа. Үзэсгэлэнгээр зочилсон зочдын тоо 10,000 гаруй, боловсролын хөтөлбөрт 1700 гаруй хүн хамрагдсан. Мөн Монгол Улсад орчин цагийн музей байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Дорноговь аймаг "Музейтэй Дорноговь" аян сарын аяныг

зарлаж музейн албан хаагчдын дунд сургалт, урлагийн тоглолт, тусгай үзэсгэлэн зэрэг арга хэмжээг зохион байгуулж 1000 гаруй хүнийг хамруулсан.

Дорноговь аймгийн 2024 оны аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, “Нээлттэй Дорноговь” хөтөлбөрийн хүрээнд 2024 оны эхний хагас жилийн байдлаар дараах арга хэмжээг зохион байгуулсан байна. -

- 2024.04.23-ны А/372 дугаар захирамжаар “Өнгөрсөн, одоо, ирээдүй” эрдэм шинжилгээний судалгааны ажлыг эмхэтгэж ном хэвлүүлсэн.
- 2024.05.17 -ны А/449 дугаар захирамж “Дэмжлэг үзүүлэх тухай” Дорноговь аймгийн “Болор эгшиглэн” үндэсний хөгжмийн хамтлаг Улаанбаатар хотод аймаг орон нутгаа

²¹ Дорноговь аймгийн Соёл урлагийн газар /тайлант хугацааны нэрээр/ <https://do.moc.gov.mn/>

төлөөлөн хотын сургуулиудын хөгжмийн багш нарт сайн туршлага түгээж, тоглолт, арга хэмжээнд оролцоход 17,1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

- 2024.04.26-ны А/393 дугаар захирамжаар “Гэр үзэсгэлэн” арга хэмжээнд орон нутгаа төлөөлөн оролцох соёлын албан хаагчдад өв соёлын гэр худалдан авахад 10 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.
- 2024.06.20 А/521 дугаар захирамж “Дэмжлэг үзүүлэх тухай” Монгол Улсад орчин цагийн музей байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Дорноговь аймаг "Музейтэй Дорноговь" аян сарын аяныг зохион байгуулсан.

Соёл урлагийн үйл ажиллагааг ард иргэдэд түгээн дэлгэрүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг дэмжих зорилгоор Соёлын байгууллагын орчин нөхцлийг сайжруулж засвар үйлчилгээ хийж, тоног төхөөрөмжөөр хангахад 13 төсөл арга хэмжээний гүйцэтгэлд 1.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.

Аймгийн ЖХТ-ний дагуу соёл урлагийн салбарт дараах хоёр салбарын үр дүн тодорхойлсон байна. Үүнд:

3.1. “Үндэсний соёлын дархлааг 66 хувьд хүргэнэ” зорилтын хүрээнд “Үндэсний соёлын өв тээгчдийн тоог 10 хувиар нэмэгдүүлнэ” үр дүн тодорхойлсон. Тус зорилтын хүрээнд салбарт нийт 3 хөтөлбөрийн хүрээнд 17 шалгуур үзүүлэлт бүхий арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд хагас жилийн байдлаар нийт 17 хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн дундаж гүйцэтгэл 61 хувьтай байна.

3.2. “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг 1 хувиар нэмэгдүүлнэ.” зорилтын хүрээнд “Соёлын үйлдвэрлэл эрхлэгч, иргэн, хуулийн этгээдийн тоог 10 хувиар нэмэгдүүлнэ” үр дүн тодорхойлсон. Тус зорилтын хүрээнд салбарт нийт 3 хөтөлбөрийн хүрээнд 4 шалгуур үзүүлэлт бүхий арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд хагас жилийн байдлаар нийт 14 хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн дундаж гүйцэтгэл 50 хувьтай байна.

Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 33%

Соёл урлаг хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 6,994.7 сая төгрөг төлөвлөгдсөн бөгөөд үүнээс 2024 оны эхний 6 сард 3.6 тэрбум төгрөг хуваарилсан. Нийт төсвийн 33 хувьтай тэнцэх буюу 1.2 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 65%

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Соёл урлагийг түгээн дэлгэрүүлнэ.” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 65% байна.

Хөтөлбөрийн гүйцэтгэл: 65%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлттэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 65 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: 32%

Хөтөлбөрийн үр ашиг нь 32 хувь буюу “үр ашигтай” гарсан.

ЗУРАГ № 37 СОЁЛ УРЛАГ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ



Аргачлал: Тухайн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлант хугацаанд дахь иргэдэд хүргэсэн соёл урлагийн арга хэмжээний тоогоор тооцно.


Ахиц дэвшил: Соёл урлагийн салбарын бүх чиглэлийн үйл ажиллагааг нэгтгэсэн байдлаар дүгнэх боломжтой үзүүлэлтээр буюу соёл урлагийн байгууллагын үндсэн бүтээгдэхүүн болох арга хэмжээний тоогоор үнэлсэн нь музей, номын сан, соёлын төв, театр чуулгын үр дүнг нэгтгэх, аймаг, улсын хэмжээнд нэгтгэх, харьцуулах боломжийг бүрдүүлж байна.

Анхаарах асуудал: Төсвийн хөтөлбөр болон АХЖТ гэх мэт бодлогын баримт бичгийн шалгуур үзүүлэлтүүд хүртээмжид хамаарах хүний буюу үзэгчийн, оролцогчийн тоо зэрэг үзүүлэлтээр илэрхийлэгдсэн байгаа нь дотоод үр ашгийг харуулах боломжийг хязгаарлаж байна. Улсын төсөвт соёл урлагийн салбарыг хүнд амд ногдох байдлаар шалгуур үзүүлэлтийг тогтоосон байгаа тул цаашид аймгийн хэмжээнд дотоод үр ашиг, чанарт чиглэсэн шалгуур үзүүлэлтийг нэмэлтээр ашиглах боломжийг судлах нь зүйтэй.

Сургуулийн өмнөх боловсрол – 71801

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдаж байгаа хүүхдийн тоо 2023/2024 оны хичээлийн жилд 5063 болж, өмнөх оноос 288 (6.0%)-аар өссөн нь байна. Нийт хамрагдаж буй хүүхдийн 4720 нь буюу 93.2 хувь нь үндсэн сургалтад, 343 нь буюу 6.8 хувь нь хувилбарт сургалтад хамрагдаж байна.

ЗУРАГ № 38 СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДСАН ХҮҮХДИЙН ТОО



Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 2023/2024 оны хичээлийн жилд 200 үндсэн багш ажиллаж, 1 багшид дунджаар 25 хүүхэд ногдож байна. Энэ хичээлийн жилд СӨБ-д хамрагдсан хүүхдийн 26.9 хувь нь бэлтгэл бүлэгт, 20.8 хувь нь дунд бүлэгт, 19.1 хувь нь ахлах бүлэгт, мөн 19.1 хувь нь бага бүлэгт, 14.2 хувь нь холимог бүлэгт хамрагдаж байна²².

“Чадварлаг багш” арга хэмжээний хүрээнд цэцэрлэгийн менежмент, сургалтын арга зүй, багшийн хөгжлийг дэмжих зорилгоор аймгийн Засаг даргын 2024 оны А/167 дугаар захирамжаар СӨБ-ын багш нарт мэргэшүүлэх үе шаттай сургалт зохион байгуулахад зориулж, 11,542,400 төгрөгийг дэмжлэг үзүүлсэн. Сургалтад нийт СӨБ-ын 366 багш бүрэн хамрагдаж мэдлэгээ дээшлүүлсэн. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын дунд сургалт болон “Ур чадвар-2024” сайн хичээл-үйл ажиллагааг 2 үе шаттай зохион байгуулж, шалгарсан багш, удирдах ажилтнууд мэргэжил онол, арга зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилготой эрхлэгч, арга зүйч, багш нарын бүрэлдэхүүнтэй 7 төрлийн үйл ажиллагаанд мэдлэг, ур чадвараа сорин оролцож баруун бүсийн цэцэрлэгүүд багаараа шалгарч, арга туршлагаа аймгийн хэмжээнд түгээн дэлгэрүүлээ. Мөн “Хамтын оролцоонд суурилсан

²² Эх сурвалж: Дорноговь аймгийн статистикийн хэлтэс. Дорноговь аймгийн 2023 оны статистикийн эмхэтгэл.

сургалтын байгууллагын менежментийг хөгжүүлэх нь” сэдэвт аймгийн багш нарын эрдэм шинжилгээний хурлыг цахим болон танхим хосолсон хэлбэрээр 2 үе шаттай зохион байгуулсан ба шалгарсан илтгэл улсын эрдэм шинжилгээний хуралд амжилттай оролцсон.

Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр 2023 онд байгууллага-87.2%, багшийн гүйцэтгэлийн үнэлгээ-89.2% үнэлэгдэж 14 цэцэрлэг, 49 багш урамшуулалд хамрагдсан бол 2024 оны гүйцэтгэлийн үнэлгээгээр төрийн өмчийн 33, төмөр замын 5 цэцэрлэг 147 багш хамрагдсанаас 72 багш урамшуулалд хамрагдаж өмнөх оноос 23-аар нэмэгдсэн. Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр 82.26 буюу өмнөх оноос 6.82 хувиар буурсан. Сургалтын орчны үзүүлэлт 90.8 хувь буюу 2.6 хувиар ахисан байна.

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд “Ерөнхий боловсролын сургуульд элсэгчдийн бэлтгэгдсэн байдлын үнэлгээг 4 хувиар нэмэгдүүлнэ.” зорилгын хүрээнд 9 хөтөлбөрийн хүрэх үр дүн бүхий шалгуур үзүүлэлт төлөвлөсөн байна. Тус хөтөлбөрийн хүрээнд ерөнхий боловсролын сургалт, дэд бүтэц, багш, чиглэлийн тоон болон чанарын үзүүлэлтүүд багтсан байна.

Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 60%

Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 2.9 тэрбум төгрөг төлөвлөгдсөн бөгөөд үүнээс 2024 оны эхний 6 сард 1.7 тэрбум төгрөг хуваарилсан. Нийт төсвийн 60 хувьтай тэнцэх буюу 1.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 106%

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх.” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 106% байна.

Хөтөлбөрийн гүйцэтгэл: 106%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлттэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 106 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: 45%

Хөтөлбөрийн үр ашиг нь 45 хувь буюу “үр ашигтай” гарсан.

ЗУРАГ № 39 СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ



Аргачлал: Тайлангийн хугацаанд хамаарах хичээлийн жилийн аймгийн хэмжээнд албан ёсны статистик мэдээнд суурилсан сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жингийн хэмжээгээр тооцно. Хамран сургалтын цэвэр жинг боловсролын тухайн түвшинд элсэн суралцаж буй зохих насны суралцагчдын тоог хамрагдвал зохих насны нийт хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

Ахиц дэвшил: Сургуулийн өмнөх боловсролын шалгуур үзүүлэлтийг улсын хэмжээнд ашиглаж байгаа, улсын төсвийн шалгуур үзүүлэлтийн нэг болох, албан ёсны үзүүлэлт ашиглаж байгаа нь


давуу тал болж байна. Дорноговь аймгийн хувьд бусад аймгуудаас дэвшилттэй байгаа нь чанарын үзүүлэлтийг шалгуураар сонгосон байна. Төсвийн хувьд засаг дарга²³ нь хуулийн дагуу орон нутгийн төсвөөс боловсролын салбарт зөвхөн ашиглалтын зардлыг хариуцаж байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор дийлэнх аймгууд тухайн зардалтай уялдсан шалгуур үзүүлэлт сонгох хандлага байдаг. Гэхдээ Засаг дарга нь Боловсролын ерөнхий хуулийн дагуу тухайн орон цэцэрлэгийг байгуулах, татан буулгах болон бүх шатны боловсролын үйлчилгээний чанар үр дүнг Засгийн газрын өмнө хариуцдаг, харьяа нутаг дэвсгэртээ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаас гадна боловсролын асуудлаар олон талт бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Мөн аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд 9 хүрэх үр дүн бүхий шалгуур үзүүлэлтэй байна. Иймд зөвхөн олгох төсвөөр хязгаарлахгүй салбарын хүрэх үр дүн өргөжүүлсэн байдлаар, чанартай уялдуулан тогтоох нь зүйтэй.

Анхаарах асуудал: Улсын төсвийн “Сургуулийн өмнөх боловсрол” хөтөлбөрт “ургуулийн өмнөх боловсролын тэгш хамран сургалтыг нэмэгдүүлнэ..”, “Сургуулийн өмнөх боловсролын чанарт ахиц гаргана.” 4 хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн хүрээнд 3 шалгуур үзүүлэлтээр хэмжихээр баталсан. Үүнээс орон нутгийн хувьд нэг жилийн хугацаанд үнэлэх боломжтой хүртээмжийн, сургалтын үзүүлэлтийг ашиглан, цаашид сургуулийн өмнөх боловсролын салбарын үр дүнд олон талаас нь дүгнэх боломжийг олгох боломжтой.

Ерөнхий боловсрол – 71802

Аймгийн хэмжээнд 2023/2024 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 22 сургууль үйл ажиллагаа явуулж байна. Ерөнхий боловсролын сургуульд нийт 15825 суралцагчид ерөнхий

Зураг № 40 ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД, ХУВИАР



боловсрол олгох үйл ажиллагаанд хамруулж байгаа нь өмнөх оноос 470 суралцагчаар нэмэгдсэн байна. Бага боловсролын хамран сургалтын бохир жин 97.8% болж, өмнөх оноос 2.0%-иар, суурь боловсролын хамран сургалтын бохир жин 94.1% болж, өмнөх оноос 1.1%-иар тус тус өссөн үзүүлэлтэй байна. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын 49.9 хувь нь бага ангид, 35.3 хувь нь дунд ангид, 14.8 хувь нь ахлах ангид суралцаж байна. Бүх шатны боловсролын байгууллагын элсэгчдийн тоо 2023/2024 оны хичээлийн жилд 4512 болж, өмнөх оноос 266

(6.3%)-аар нэмэгджээ²⁴.

“Чадварлаг багш” арга хэмжээний хүрээнд сургуулийн менежмент, сургалтын арга зүй, багшийн хөгжлийг дэмжих зорилгоор аймгийн Засаг даргын 2024 оны А/164 дугаар захирамжаар ЕБС-ын багш нарт мэргэшүүлэх үе шаттай сургалт зохион байгуулахад зориулж нийт 38,218,800 төгрөгийг дэмжлэг үзүүлсэн. Сургалтад ЕБС-ын 722 багш бүрэн хамрагдаж мэдлэгээ дээшлүүлсэн. Аймгийн хэмжээнд бага ангийн 21 ментор багш сургуулиудад 5 хоногийн хугацаатай ажиллаж, өөрийн арга зүй болон сургуулийн арга туршлагаа түгээн дэлгэрүүлсэн. Medle.mn цахим сургуульд 6 багш хичээл зааж, 9 сургуулийн 230 сурагч хамрагдсан. Хичээл төрлийн олимпиадын хоёрын даваанд амжилттай оролцож шалгарсан 11 судлагдахууны 16 багш, 46 сурагч улсын олимпиадад оролцож, 3 багш, бэлтгэсэн шавь нараас нь 9 сурагч шагналт байруудад шалгарсан. Аймгийн Засаг даргын 2024 оны А/259 захирамжаар 11,475,240 төгрөгийг шийдвэрлэн, “Зорилгын хүч-5” сургалт, үйл ажиллагааг зорилгын хуудас бөглүүлэх, танхимын сургалт зохион байгуулах, анги хамт олны бүтээлч ажил өрнүүлэх, дэвжээ тэмцээн зэрэг шинэлэг байдлаар зохион байгуулж, 10 сургуулийн элсэлтийн шалгалт өгөх 12-р ангийн 27 бүлгийн 711 суралцагчийг хамруулсан. “Зорилгын-Хүч-5” үйл ажиллагааны хүрээнд 10 судлагдахуунаар

²³ 20.1.18.төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар;

²⁴ Эх сурвалж: Дорноговь аймгийн статистикийн хэлтэс. Дорноговь аймгийн 2023 оны статистикийн эмхэтгэл.

мэргэжлийн зэрэгтэй 35 багш удирдан 278 цагийн сургалт хийж, давхардсан тоогоор 3128 суралцагчийг хамруулсан.

Ерөнхий боловсролын 22 сургалтын байгууллага гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдаж, 2024 онд 75.2 %-ийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн нь өмнөх оныхоос 5.35%-иар ахисан. Багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд 612 багш хамрагдаж 70.85 % үнэлэгдсэн нь өмнөх оноос 0.78%-иар буурсан байна. Гүйцэтгэлийн үнэлгээгээр амжилттай үнэлэгдсэн 3 сургууль, 139 багш урамшуулалд хамрагдсан.

Ерөнхий боловсролын сургуулийн багш ажилчид, сурагчдын ажиллах, сурах таатай орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор шинээр барилга барьж, зарим сургуулиудад засвар үйлчилгээ хийж, машин тоног төхөөрөмжөөр хангахад 7 төсөл арга хэмжээний гүйцэтгэлд 2.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд “Боловсролын чанарын үзүүлэлтийг 12 хувиар нэмэгдүүлнэ” зорилгын хүрээнд 29 хөтөлбөрийн хүрэх үр дүн бүхий шалгуур үзүүлэлт төлөвлөсөн байна. Тус хөтөлбөрийн хүрээнд ерөнхий боловсролын сургалт, дэд бүтэц, багш, цахим хөгжил, сэтгэл зүй, хүүхдийн хоол чиглэлийн тоон болон чанарын үзүүлэлтүүд багтсан байна.

Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 83%

Ерөнхий боловсрол хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 10,443.8 сая төгрөг төлөвлөгдсөн бөгөөд үүнээс 2024 оны эхний 6 сард 5.8 тэрбум төгрөг хуваарилсан. Нийт төсвийн 83 хувьтай тэнцэх буюу 4.8 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 159%

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Сургалтын чанарыг сайжруулах.” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 159% байна.

Хөтөлбөрийн гүйцэтгэл: 159%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлттэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 159 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: 75%

Хөтөлбөрийн үр ашиг нь 75 хувь буюу “үр ашигтай” гарсан.

Зураг № 41 Ерөнхий боловсрол хөтөлбөр



Аргачлал: Ерөнхий боловсролын салбарын чанарын үнэлгээний гүйцэтгэлийн хувиар хэмжинэ.

Ахиц дэвшил: Ерөнхий боловсролын салбарын чанарын үзүүлэлтээр хэмжиж байгаа нь давуу тал бөгөөд улсын хэмжээнд төсвийн шинэчлэлийн хүрээнд санхүүжилттэй уялдсан үнэлгээний тогтолцоо нэвтэрсэн бөгөөд тогтмол, хөндлөнгийн үнэлгээ тогтолцоо нь үр дүнгийн үзүүлэлтийн найдвартай байдлыг хангаж байна. Дорноговь аймгийн хувьд бусад аймгуудаас дэвшилттэй

байгаа нь чанарын үзүүлэлтийг шалгуураар сонгосон байна. Төсвийн хувьд засаг дарга²⁵ нь хуулийн дагуу орон нутгийн төсвөөс боловсролын салбарт зөвхөн ашиглалтын зардлыг хариуцаж байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор дийлэнх аймгууд тухайн зардалтай уялдсан шалгуур үзүүлэлт сонгох хандлага байдаг. Гэхдээ Засаг дарга нь Боловсролын ерөнхий хуулийн дагуу тухайн орон нутгийн ерөнхий боловсролын сургуулийг байгуулах татан буулгах болон бүх шатны боловсролын үйлчилгээний чанар үр дүнг Засгийн газрын өмнө хариуцдаг, харьяа нутаг дэвсгэртээ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаас гадна боловсролын асуудлаар олон талт бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Мөн аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд 29 хүрэх үр дүн бүхий шалгуур үзүүлэлтэй байна. Иймд зөвхөн олгох төсвөөр хязгаарлахгүй салбарын хүрэх үр дүн өргөжүүлсэн байдлаар, чанартай уялдуулан тогтоох нь зүйтэй.

Анхаарах асуудал: Улсын төсвийн “Ерөнхий боловсрол” хөтөлбөрт “Ерөнхий боловсролын 7-14 настай суралцагчийн суурь чадварын түвшинд ахиц гаргана.”, “Сургалтын болон дотуур байрны орчин, нөхцөл, хэрэглэгдэхүүн, хоолны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.”, “Ерөнхий боловсролын тэгш хамран сургалтыг нэмэгдүүлнэ.”, “Цахим сургалтын хүртээмжийг нэмэгдүүлнэ.” 4 хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн хүрээнд 14 шалгуур үзүүлэлтээр хэмжихээр баталсан. Үүнээс орон нутгийн хувьд нэг жилийн хугацаанд үнэлэх боломжтой хүртээмжийн, сургалтын үзүүлэлтийг ашиглан, цаашид ерөнхий боловсролын салбарын үр дүнд олон талаас нь дүгнэх боломжийг олгох боломжтой.

Мэргэжлийн боловсрол – 71804

Дорноговь аймаг дахь Магадлан Итгэмжлэгдсэн Политехник коллеж нь мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга, зорилгыг бүрэн хэрэгжүүлж, иргэнд мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх, мэргэжлийн ур чадвар олгох, дээшлүүлэх сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгад нийцүүлэн зохион байгуулах үүрэг бүхий мэргэжлийн боловсрол олгодог 35 жилийн түүхтэй сургалтын байгууллага юм. Мэргэжлийн боловсрол, сургалтын зорилго нь иргэний авьяас, сонирхол, хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн мэргэжлийн ур чадвар, боловсрол эзэмшүүлэх, мэргэшлийг дээшлүүлэх, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэх юм. Аймгийн хэмжээнд 2023/2024 оны хичээлийн жилд политехник коллежид 804 оюутан суралцаж, өмнөх онтой харьцуулахад политехникийн коллежид суралцагчид 152 (23.3%)-оор өссөн байна.

2023-2024 оны хичээлийн жилд Политехник коллежийг мэргэжлийн боловсролын 1 жилийн ангийг галт тэрэгний ашиглалт, засвар үйлчилгээ, төмөр замын тээврийн удирдлага зохион байгуулалт, зүтгүүрийн аж ахуй, галт тэрэгний ашиглалт, засвар үйлчилгээ, төмөр замын барилга, зам, замын ашиглалт, оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нягтлан бодох бүртгэл, хүлэмжийн аж ахуй, гагнуур мэргэжлээр 167, техникийн боловсролыг цахилгаан хэрэгслийн засвар үйлчилгээ, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ, барилгын техник, технологи мэргэжлээр 19 суралцагч, нийт 186 суралцагч төгссөн.

Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 80%

Мэргэжлийн боловсрол хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 306.3 сая төгрөг төлөвлөгдсөн бөгөөд үүнээс 2024 оны эхний 6 сард 177.7 сая төгрөг хуваарилсан. Нийт төсвийн 80 хувьтай тэнцэх буюу 141.5 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 93%

²⁵ 20.1.18.төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар;

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Мэргэжлийн боловсрол эзэмшигчдийн тоог нэмэгдүүлнэ.” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 93% байна.

Хөтөлбөрийн гүйцэтгэл: 93%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлттэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 93 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: 13.4%

Хөтөлбөрийн үр ашиг нь 13.4 хувь буюу “үр ашигтай” гарсан.

ЗУРАГ № 42 МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ХӨТӨЛБӨР



Аргачлал: Мэргэжлийн болон техникийн боловсролын чиглэлээр тухайн жилд суралцаж буй нийт суралцагчийн тоогоор хэмжинэ.

Ахиц дэвшил: Мэргэжлийн болон техникийн боловсролд суралцах хүүхдүүдийг идэвхжүүлэх, тоог нэмэгдүүлэх чиглэлээр орон нутгийн “Инженер, программчлалын цогц хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх” хөтөлбөр хэрэгжүүлж, Аймгийн “Шинжлэх ухаан технологийн салбар зөвлөл”-ийн 2024 оны төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөний дагуу “Инженер, программчлалын цогц хөтөлбөр”-ийг боловсруулан, суралцагчдын асуудлыг шийдвэрлэх, бие даан суралцах, бусадтай харилцаа холбоо тогтоох, хамтран ажиллах, бүтээлч, инженер сэтгэлгээний чадварыг нэмэгдүүлэх, суралцах чадварыг ахиулж шинэлэг инновац санааг хөгжүүлэх зорилгоор асуудлаа хэрхэн олж харах, судалгааны ажил хэрхэн хийх талаар сургалтыг ЕБ-ын 9-12 дугаар ангийн 450 суралцагчдад зохион байгуулж, холбогдох зөвлөмж, мэдээллийг ерөнхий боловсролын сургуулиуд болон мэргэжлийн боловсролын байгууллагад хүргүүлсэн. Мөн “Ирээдүйн энтрепренерүүд” судалгааны ажил хийх уралдаанд 4 сургууль шалгарсан.

Анхаарах асуудал: Улсын төсвийн “Мэргэжлийн боловсрол” хөтөлбөрт “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хүртээмж, хамрагдалтыг нэмэгдүүлнэ”, “Мэргэжлийн болон техникийн боловсролын чанар, нийцлийг сайжруулна” хоёр хөтөлбөрийн хүрэх үр дүн “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтад хамрагдсан суралцагчийн тухайн насны хүн амд эзлэх хувь”, “Төгсөөд ажлын байртай болсон төгсөгчийн хувь /тухайн жилд төгсөөд ажлын байртай болсон төгсөгчийг нийт төгсөгчийн тоонд харьцуулж тооцсон хувь/”, “Олон улсад магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын тоо” шалгуур үзүүлэлтийг тогтоосон байна. Улсын хэмжээнд мэргэжлийн боловсролын үр дүнг тухайн салбарт суралцаж төгссөн суралцагчийн үр дүнгээр хэмжиж байгаа тул орон нутгийн хэмжээнд мөн суралцагчдын мөшгих судалгааг хөгжүүлж, үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг боловсруулах боломжтой юм.

Мал аж ахуйг хөгжүүлэх – 70801

Мал, амьтны гоц халдварт 1 төрлийн өвчнөөр давхардсан тоогоор 8 суманд оношлогдож, нийт 278 толгой мал өвчилснөөс 10 толгой мал хорогдож, 78 толгой малын шинж тэмдэг арилж, 190

толгой малыг зориудын аргаар устгасан. Малын гоц халдварт хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад Айраг, Замын-Үүд, Даланжаргалан сумын голомт, сэжигтэй бүсийн 10000 толгой хонийг хамруулсан. Өвчний гаралт, тархалт буурахгүй байгаатай холбогдуулан нэмэлтээр ирсэн М 100,000 мянган тун вакциныг дахин хуваарилан Айраг, Даланжаргалан, Иххэт, Сайхандулаан сумын голомт, сэжигтэй бүс болон халдварын эрсдэлийг бууруулах зорилгоор хамгаалалтын бүс үүсгэн 96600 толгой малыг дархлаажуулалтад хамруулж ажлын гүйцэтгэл 96.6 хувьтай явагдаж байна. Одоогийн байдлаар нэмж өвчилсөн мал бүртгэгдээгүй байна. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтад 3889 өрхийн 75996 толгой мал, амьтныг хамруулахаар төлөвлөн 76800 тун вакциныг сумдад хуваарилан хүргүүлж байна.

Мал, амьтны шимэгчлэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 2024 оны угаалга 767.9 толгой мал, туулгалт 265.5 толгой мал, боловсруулалт 288.5 толгой мал, гуурын боловсруулалт 21.6 толгой мал, нийт 1343.5 толгой мал хамруулахаар төлөвлөж, мөн Үхрийн арьс гууртах 828 толгой малыг хамруулсан байна.

Бэлчээрийн менежментийг дэмжих зорилгоор сумдуудад худаг шинээр гаргаж, мөн засварлахад 1 төсөл арга хэмжээний гүйцэтгэлд 117.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Аймгийн жилийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд “Бэлчээрийн даац хэтрэлтийг 1 хувиар бууруулна” зорилгын хүрээнд “Мал аж ахуйн хөтөлбөр” хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэсэн 11 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд дараах арга хэмжээ байна:

1. Ангилаан ялгалт хийх
2. Малчдыг бэлчээрийн даацдаа тохируулан сүргийн эргэлт тооцоолол хийх талаар бүсчилсэн сургалт хийх
3. Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй хортон, мэрэгч амьтдыг устгах
4. Сумдад малын тэжээлийн ургамал тариалалтыг нэмэгдүүлэх
5. Сумдын мал нядалгааны цэгийг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн засварлах
6. Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажил, отор нүүдэлд хяналт тавих
7. Сумдад инженерийн хийцтэй худаг шинээр гаргах
8. Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт сумдын бэлчээрт хөнөөл учруулж буй үлийн цагаан оготнотой тэмцэх
9. Хур тундасны хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор үүлэнд зориудаар нөлөөлөх
10. Мал, амьтны халдваргүйтгэлийн ДУК автомашин худалдан авах
11. “Масс мессеж” үйлчилгээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх

Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 81%

Мал аж ахуйг хөгжүүлэх үйл ажиллагаа хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 994.3 сая төгрөг төлөвлөгдсөн бөгөөд үүнээс 2024 оны эхний 6 сард 441.6 сая төгрөг хуваарилсан. Нийт төсвийн 81 хувьтай тэнцэх буюу 357.1 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 5%

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Малын гоц халдварт өвчнийг бууруулна.” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 5% байна.

Хөтөлбөрийн гүйцэтгэл: 5%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлттэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 5 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: -75.4%

Хөтөлбөрийн үр ашиг нь 97.4 хувь буюу “үр ашигтай” гарсан.

ЗУРАГ № 43 МАЛ АЖ АХУЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ



Аргачлал:Тухайн онд вакцинд хамрагдсан малын тоо


Ахиц дэвшил: Төсвийн хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг АЖХ-ын төлөвлөгөөны МААХ-хөтөлбөрт 9 шалгуур үзүүлэлттэй уялдуулан баталсан нь гүйцэтгэл үр дүнгийн мэдээллийг бодитой гаргах боломж бүрдсэн.

Анхаарах асуудал: Вакцинд хамрагдсан малын тооноос хамаарч ямар өвчлөл хэрхэн буурсан болон, эдийн засгийн ямар эерэг өөрчлөлт үзүүлсэн зэрэг чанарын шалгуур үзүүлэлтийг сонгох нь зүйтэй.

Гамшгаас хамгаалах– 70708

Дорноговь аймгийн онцгой байдлын газраас ирүүлсэн мэдээллээр 2023 онд нийт тохиолдон гамшиг, аюулт үзэгдэл 120 болж, өмнөх оноос 42 (53.8 %)-оор нэмэгджээ. 2023 онд гамшиг аюулт

ЗУРАГ № 44 СҮҮЛИЙН ХОЁР ЖИЛД ТОХИОЛДСОН ГАМШИГ, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ



үзэгдлээс аварсан хүний тоо 34, аварсан хөрөнгийн хэмжээ 73.0 тэрбум төгрөг болж өмнөх оноос хүний тоо 18 (2.1 дахин)-аар, аварсан хөрөнгийн хэмжээ 66.4 (11.1 дахин) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Тохиолдсон гамшиг, аюулт үзэгдлийг төрлөөр нь авч үзэхэд 2023 онд гал түймэр 67, цасан болон шороог шуурганы улмаас хүн төөрсөн 32, хүчтэй шороон шуурга 15, малын гоц халдварт өвчин 3, газар хөдлөлт 3, зам тээврийн осол /хүн хавчуулагдсан/ 2 бүртгэгдсэн байна. Өмнөх оноос гал түймэр 14 (26.4 %)-өөр, хүчтэй шороон шуурга 11 (3.7 дахин)-ээр, газар хөдлөлт 2 (3.0

дахин)-оор тус тус нэмэгдсэн бол малын гоц халдварт өвчин 11 (78.6 %)-ээр буурчээ²⁶.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2-т заасны дагуу Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн төсөвт 50.0 сая төгрөг, орон нутгийн төсөвт гамшгаас хамгаалах зардал 1.2 тэрбум төгрөгийг тусган аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулсан нь өмнөх онтой харьцуулахад 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Иххэт, Даланжаргалан, Айраг сумдад гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага, сургуулийг 2023 оны 04, 09 дүгээр сард, Алтанширээ суманд гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг 04 дүгээр сард, Улаанбадрах суманд Команд штабын сургуулийг 04 дүгээр сард тус тус зохион байгуулсан.

Гамшгаас хамгаалах дадлага, сургуульд дээрх 5 сумын Онцгой комисс, ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн 329 томилгоот бүрэлдэхүүн, 594 иргэн, 71 техник хэрэгсэлтэйгээр ажиллан ерөнхий зориулалтын мэргэжлийн анги, аж ахуй нэгж, байгууллагын удирдлагын зүгээс сургуулийн бэлтгэл ажлыг сайн хангасан, нөөц бүрдүүлэлт, гамшгаас хамгаалах бүтээлч ажил, санал санаачлагыг харгалзан үзэж шалгасан. Орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах,

²⁶ Эх сурвалж: Дорноговь аймгийн статистикийн хэлтэс. Дорноговь аймгийн 2023 оны статистикийн эмхэтгэл.

гамшигтай тэмцэх чадавхыг дээшлүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2023 оны А/146 дугаар захирамжаар “Гамшгаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулах”-д 15,9 сая төгрөгийг шийдвэрлэж зарцуулсан байна.

Орон нутгийн 2024 оны төсөвт гамшгаас хамгаалах зардалд 2,0 тэрбум төгрөг төлөвлөж гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, хүн, малын гоц халдварт өвчин, байгалийн гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах нөхцөл боломжийг бүрдүүлсэн.

Дорноговь аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд “Орчны эрсдэлийг суурь түвшнээс 1 хувиар бууруулна” зорилгын хүрээнд “Гамшгийн эрсдэлийг даван туулах чадавхыг 30 хувиар нэмэгдүүлнэ” үр дүнгийн хүрээнд Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хөтөлбөр 5 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 99%

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 2,131.1 сая төгрөг төлөвлөгдсөн бөгөөд үүнээс 2024 оны эхний 6 сард 1.8 тэрбум төгрөг хуваарилсан. Нийт төсвийн 99 хувьтай тэнцэх буюу 1.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 67%

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Гамшиг ослын эрсдэлийг хохирол багатай даван туулна.” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 5% байна.

Хөтөлбөрийн гүйцэтгэл: 67%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлттэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 5 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: -32.8%

Хөтөлбөрийн үр ашиг нь -32.8 хувь буюу “үр ашигтай” гарсан.

ЗУРАГ № 45 ГАМШГААС ХАМГААЛАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ



Аргачлал: Өмнөх оны гарсан гамшиг осол-энэ онд гарсан гамшиг осол/суурь түвшин

Ахиц дэвшил: АЖХ-ын төлөвлөгөөнд гамшгаас урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн 5 шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд төсвийн хөтөлбөрийн шалгуур үзүүлтийн үр дүнг уялдуулан батласан.

Анхаарах асуудал: ҮСХ-ын статистик тайлан мэдээгээр баталгааждаг шалгуур үзүүлэлт сонгосон ба тухайн үр дүнг шууд болон шууд бусаар хангахад чиглэсэн хөтөлбөрийн хүрэх үр дүнг тооцох шаардлагатай.

Ахмад настны хөгжил хамгаалал – 72208

Тайлант онд аймгийн ахмадад зориулсан 1 ордон, 14 өргөө, 18 танхимд үйл ажиллагаа явуулж байна. Бүх сумдын өргөө танхимд ахмадуудад тогтмол үйл ажиллагаа зохион байгуулдаг. Мэргэжлийн байгууллагуудын ахмадын зөвлөлүүдээс аймгийн Нэгдсэн эмнэлэг, Онцгой байдлын газар байгууллагынхаа дэргэд Ахмадын өргөөтэй болж ахмадууддаа тогтмол үйлчилж байна. Ахмадуудын хөшүүн байдлыг арилгах, тэдэнд тохирох хөдөлгөөнт дасгалыг Ахмадын хорооны дэргэдэх “Энэрэл” төвийн ажилтан, ахмадуудаар бичлэг болгон, орон нутгийн телевизээр болон өөрийн пэйж хуудсаар нийт ахмадуудын хүртээл болголоо. Аймгийн Хийн дасгалын аварга шалгаруулах тэмцээнд 10 сумын ахмадын 18 баг оролцож, аймгийн Ахмадын Хорооны “Энэрэл” баг амжилттай оролцож Мөнгөн медаль хүртсэн. Ахмадын Хорооны 208 тоот танхимд өглөө бүр 8 цагт хийн дасгал тогтмол явуулдаг. “Өдрийн үйлчилгээ” төсөлд хамрагдсан ахмадуудад Аялгуут дасгал, Саваат дасгал зэргийг тогтмол явуулж, бие эрхтний хөшүүн байдлыг арилгах, тогтмол хийж сургах ажлуудийг зохион байгуулсан.

Дорноговь аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд ахмад настны хөгжил хамгааллын чиглэлээр “Гэр бүлийн эрүүл, тогтвортой байдлыг хангана” зорилтын хүрээнд “Эрүүл, идэвхтэй ахмад настныг 20 хувиар нэмэгдүүлнэ.” Үр дүнд чиглэсэн 6 арга хэмжээ бүхий “Нийгмийн хөгжил хөтөлбөр” хэрэгжүүлэхээр тусгасан. Тус хөтөлбөрийн хүрээнд:

ЗУРАГ № 46 АХЖТ-нд ТУССАН АХМАД НАСТНЫ ХӨГЖИЛ ХАМГААЛАЛЫН АРГА ХЭМЖЭЭ



1. “Ахмад настнуудад эрүүл мэнд (гериатр), сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлж, “Гериатр эмч, сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагдсан ахмад”, “Ажиллаж байгаа мэргэжлийн эмч” хоёр шалгуур үзүүлэлтээр хэмжихээр тодорхойлсон. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлэхээр магадлан итгэмжлэгдсэн 2 байгууллага буюу аймгийн Ахмадын хороо ТББ, Улаан загалмайн хороонд тус бүр 1 удаа үйлчилгээний журам болон шалгуурын талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн. Уг үйлчилгээний “Ахмадын өдрийн үйлчилгээ”-г аймгийн Ахмадын хороо ТББ-р гэрээлэн гүйцэтгүүлж Замын-Үүд, Өргөн, Эрдэнэ сумын 89 ахмадыг хамруулж улсын төсвөөс 9,0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Үйлчилгээг сумдаас ахмадуудыг хамруулсан нь хүртээмжийг нэмэгдүүлсэн давуу талтай байна.

2. “Говийн бүсийн төрөлжсөн асрамжийн үйлчилгээг үзүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлж, “Асрамжийн үйлчилгээнд хамрагдсан ахмад” шалгуур үзүүлэлтээр хэмжихээр тодорхойлсон. Тус асрамжийн газарт одоогийн байдлаар 16 асруулагч асруулж буй бөгөөд 2024 оны хагас жилийн байдлаар 3 асруулагчийг холбогдох журмын дагуу хүлээж авч үйлчилгээ үзүүлсэн. Үүнээс оролцооны бүлгийн 9 ахмад, бие даах чадваргүй 7 ахмад тус бүрд тохирсон хөгжлийн ажлын болон эрүүл мэндийн төлөвлөгөө боловсруулан чадамжийг бууруулахгүй байхад анхаарч ажилласнаар бие даах чадваргүй ахмадын тоо нэмэгдээгүй үр дүнтэй байна. Салбар дундын уялдаа холбоог сайжруулан асруулагч ахмадуудад чиглэсэн үйлчилгээ үзүүлэхэд анхаарч АШУҮИС-ийн Дорноговь дахь салбар сургууль, Уламжлалт Анагаах ухааны төв, Өрхийн эмнэлэг, Саран хөхөө театр, аймгийн Ахмадын холбоо, Үсчин гоо сайханчдын холбоо зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран 5 сарын байдлаар 16 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулсан. Мөн Хүүхэд гэр бүл, хөгжил хамгааллын газраас мэргэжлийн сэтгэл зүйчийн үйлчилгээ авахаар хамтран ажиллах гэрээ байгуулсан. Говийн бүсийн ахмад настны төрөлжсөн асрамжийн газрын барилгын санхүүжилтийн асуудлыг бүрэн шийдвэрлэж 07 дугаар сарын 01-нд ашиглалтад хүлээж авахаар, 90 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна. Барилга ашиглалтад

орсноор тус газарт 30 ахмадыг хүлээн авах боломжтой болж өөрийн гэсэн үр хүүхэдгүй, төрөл төрөгсөдгүй ганц бие ахмадуудын эрүүл, аюулгүй орчинд амьдрах орчин сайжрах юм. Харин шаардлагатай тавилга, тоног төхөөрөмжийг орон нутгийн төсвийн 108,6 сая төгрөгөөр худалдан авсан.

3. “Ахмадын сувиллын үйл ажиллагаа явуулах” арга хэмжээг “Сувиллаар үйлчлүүлсэн ахмад” шалгуур үзүүлэлтээр хэмжихээр төлөвлөж 2024 онд 100 ахмадыг хамруулахаар төлөвлөж, хагас жилийн байдлаар бүрэн хамруулсан байна. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх “Төвшин сайхан” амралтын газар амрагчдыг 2024 оны 5 дугаар эхлэн 7 хоног бүр хүлээн авч байна. Уг амралтын газрын 7 хоногийн төлбөр иргэнээс 56,0 мянган төгрөг, нийгмийн халамжийн сангаас 245.0 мянган төгрөгийн хөнгөлөлт үзүүлж нийт 301,0 мянган төгрөгийн зардлаар 1 иргэнийг амрааж байгаа бөгөөд үйл ажиллагаагаа тогтмол явуулж эхэлснээс хойш нийт 180 ахмадыг хүлээн авч үйлчилгээ үзүүлсэн. Хагас жилийн байдлаар 8 ээлжийн 364 ахмадад үйлчилгээ үзүүлж улсын төсөвт 109,5 сая төгрөгийг төвлөрүүлсэн.

4. “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг үзүүлэх” арга хэмжээг “Зөвлөх үйлчилгээнд хамрагдсан ахмад” шалгуур үзүүлэлтээр хэмжихээр төлөвлөж, 2024 онд 12 үйлчилгээ хэрэгжүүлэхээс хагас жилийн байдлаар 90 хувийн гүйцэтгэлтэй байна. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төслийг 4 сарын 01-19-ны хооронд хүлээн авахаар зар мэдээллийг олон нийтэд түгээж, холбогдох албан бичгийг сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн. Үүний хүрээнд нийт 19 байгууллагаас төслийг албан бичгээр хүлээн авч, төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэг 04-р сарын 29-ны өдөр хуралдаж 15 байгууллагын төслийг дэмжин 13 ахмадын материалыг хүлээж авч Айраг сумын ЭМТ-өөс ирүүлсэн 2 ахмад мэргэжилтний судалгааг хянаж зөвлөх үйлчилгээнд хамруулсан.

5. “Ахмадын хөгжлийн үйлчилгээ үзүүлэх” арга хэмжээг “Үйлчилгээнд хамрагдсан ахмадын тоо” шалгуур үзүүлэлтээр 4500 ахмад хамааруулахаар төлөвлөснөөс хагас жилийн байдлаар 90 хувийн гүйцэтгэлтэй байна. Ахмад настны тухай хуульд заасан хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд хамрагдах иргэдийн хүсэлтийг цахим системээр дамжуулан хүлээн авч 3999 ахмадад 161,2 сая төгрөг олгосон. Үйлчилгээний төрлөөр задалбал: харьяалалгүй 3570 ахмад настанд 35,7 сая төгрөг, рашаан сувилал болон амралт сувиллын хөнгөлөлт 146 ахмадад 47,6 сая төгрөг, ортопед протез тусгай хэрэгслийг 279 ахмадад 69,9 сая төгрөг, оршуулгын тэтгэмж 4 ахмадад 8,0 сая төгрөг тус тус олгосон. Өмнөх оны мөн үед 3946 ахмадад 87,0 сая төгрөг халамжийн сангаас олгосон. Үйлчилгээг журамд заасны дагуу нарийн мэргэжлийн эмчийн тодорхойлолт болон Эмнэлэг хяналтын комиссын шийдвэрийг үндэслэн үзүүлж байна.

6. “Хувиараа хөдөлмөр эрхэлдэг ахмадуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх” арга хэмжээ “Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан ахмад” шалгуур үзүүлэлтээр хэмжихээр төлөвлөж, 2024 онд 8 төсөлд дэмжлэг үзүүлэхээр төлөвлөснөөс хагас жилийн байдлаар 17 төсөлд дэмжлэг үзүүлсэн байна. Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын цахим хуудас, орон нутгийн телевиз болон бусад мэдээллийн сувгуудаар санхүүгийн дэмжлэгт хамрагдах ахмадын төслийг хүлээн авах зар мэдээллийг 2024.04.02-22-ны хооронд хүргэж, нийт 33 төслийг хүлээн авснаас 17 ахмадын 120.0 сая төгрөгийн төслийг дэмжиж санхүүжилтийг олгосон. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад санхүүгийн дэмжлэгт хамрагдсан ахмадын тоонд өөрчлөлт ороогүй.

Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 43%

Ахмад настны хөгжил хамгаалал хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 360.5 сая төгрөг төлөвлөгдсөн бөгөөд үүнээс 2024 оны эхний 6 сард 183.5 сая төгрөг хуваарилсан. Нийт төсвийн 43 хувьтай тэнцэх буюу 78.4 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 120%

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Ахмад настны талаарх төрийн тодорхой чиг үүргийг гүйцэтгэж, ахмад настанд чиглэсэн арга хэмжээний тоог нэмэгдүүлнэ..” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 120% байна.

Хөтөлбөрийн гүйцэтгэл: 120%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлттэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 120 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: 77.3%

Хөтөлбөрийн үр ашиг нь 77.3 хувь буюу “үр ашигтай” гарсан.

ЗУРАГ № 47 АХМАД НАСТНЫ ХӨГЖИЛ ХАМГААЛАЛ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ



Аргачлал: Зохион байгуулсан арга хэмжээний тоо

Ахиц дэвшил: Тус хөтөлбөрийн нийгмийн тодорхой бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс тусад нь хөтөлбөрөөр үр дүн тооцсон нь дэвшилттэй.

Анхаарах асуудал: Урт болон богино хугацааны бодлогын баримт туссан үр дүнг хангаууц, арга хэмжээний бус шалгуур үзүүлэлтийг сонгох нь зүйтэй

Авто зам – 71101

Дорноговь аймаг нь хилийн болон уул уурхай, цэргийн бүстэй, Монгол Улсын БНХАУ-тай холбосон үндсэн авто зам байршдаг онцлогтой. Тус аймаг нь 2013 оноос Улаанбаатар хоттой тасралтгүй хатуу хүчилттай замаар холбогдсоноос хойш тасралтгүй хатуу хучилттай зам, явган хүний зам болон бусад төрлийн замуудыг шинээр болон шинэчлэн сайжруулах үйл ажиллагаа тасралтгүй жил бүр төлөвлөн хэрэгжүүлдэг байна. Тус онд Сайншанд-Замын-Үүд чиглэлийн олон улсын чанартай хатуу хучилттай А0103 авто замаас Өргөн сум хүртэлх нийт 18.2 км хатуу хучилттай авто замын санхүүжилт шийдвэрлэгдээгүйн улмаас үлдээд байсан 9.3 км авто замыг улсын төсвийн 3.4 тэрбум төгрөгийн хөрөнгөөр "Дорноговь- АЗЗА" ТӨХК гүйцэтгэж ашиглалтад оруулсан орон нутгийн чанартай авто замын сүлжээг өргөжүүлэн иргэдийн аюулгүй, шуурхай зорчих нөхцөлийг бүрдүүлсэн.

Улсын төсвийн 16.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Сайншанд сумын 2-р баг, Хамарын хийдийн 3 замын уулзвараас Зүүнбаян баг хүртэлх 20 км хатуу хучилттай автозам барих ажлын гүйцэтгэгчээр "Борхойн зам" ХХК шалгарч, ажлыг эхлүүлээд байна. Дэд бүтцийг хөгжүүлэх, аюулгүй таатай орчинд зорчих нөхцөл боломжоор хангах зорилгоор автозам барих, засварлах ажил нийт 14 төсөл арга хэмжээний гүйцэтгэлд 3.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.

Дорноговь аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд “Орчны эрсдэлийг суурь түвшнээс 1 хувиар бууруулна” зорилтын хүрээнд “Сайншанд, Замын-Үүд сумдын авто зам, авто зогсоол, явган хүний зам, дугуйн зам, гэрэлтүүлэг, тохижилтыг сайжруулах”, “Хамарын хийдийн 3 замын уулзвараас Зүүнбаян чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 18.2 км авто зам барих” арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 26%

Авто замын хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 6.3 сая төгрөг төлөвлөгдсөн бөгөөд үүнээс 2024 оны эхний 6 сард 2.6 тэрбум төгрөг хуваарилсан. Нийт төсвийн 26 хувьтай тэнцэх буюу 0.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 50%

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Орон нутгийн авто зам, замын байгууламжийг нэмэгдүүлэн иргэдийн аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 50% байна.


Хөтөлбөрийн гүйцэтгэл: 50%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлттэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 50 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: 24.1%

Хөтөлбөрийн үр ашиг нь 24.1 хувь буюу “үр ашигтай” гарсан.

ЗУРАГ № 48 АВТО ЗАМ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ



Аргачлал: Тухайн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлант хугацаанд дахь зохион байгуулахаар төлөвлөсөн арга хэмжээний тооны эзлэх хувиар тооцно.

Ахиц дэвшил: Тус хөтөлбөрийн хүрээнд аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тодорхойлсон авто зам, түүний бүтээн байгуулалт, авто тээвэр, зам тээврийн осол зэрэг олон чиглэлийг хамарсан арга хэмжээг нэгтгэн, үр дүнг илэрхийлэх боломжтой шалгуур үзүүлэлтийг сонгосон.

Анхаарах асуудал: Зохион байгуулсан арга хэмжээний тооны шалгуур үзүүлэлтийг сонгосон тохиолдолд гүйцэтгэлийн үр дүнг бүрэн баталгаажуулах боломжгүй, нийгэм эдийн засаг болон орон нутгийн иргэдэд үзүүлэх үр нөлөөнөөс үл хамаарсан үйл ажиллааг чиглэсэн шалгуур үзүүлэлт болж байна. Иймд шалгуур үзүүлэлтийг цаашид хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй уялдсан байдлаар сайжруулах боломжийг судлах шаардлагатай.

Санхүүгийн зах зээлийн зохицуулалт – 70204

Тус хөтөлбөр нь аймгийн засаг даргын хэрэгжүүлэх төсвийн хүрээнд хэрэгждэг хөтөлбөр. Тайлант онд буюу 2024 онд Дорноговь аймгийн Засаг даргын төсөвт энэ хөтөлбөрт нөөцийн махны бэлтгэхэд олгох санхүүгийн дэмжлэг төлөвлөсөн бөгөөд эхний хагас жилийн байдлаар хэрэгжилт эхлээгүй байна.

Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 0%

Санхүүгийн зах зээлийн зохицуулалт хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 200.0 сая төгрөг төлөвлөгдсөн бөгөөд эхний хагас жилд хугацаа болоогүй тул хуваарилаагүй тул гүйцэтгэл гараагүй.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 0%

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Нөөцийн махны хэмжээ, тонноор” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 0% байна.

Хөтөлбөрийн гүйцэтгэл: 0%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлттэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 0 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: 0%

Хөтөлбөрийн үр ашиг нь 0 хувь буюу “үр ашигтай” гарсан.

Зураг № 49 Санхүүгийн зах зээлийн зохицуулалт хөтөлбөрийн биелэлт



Аргачлал: Тайлант хугацаанд бэлтгэсэн тонн махны хэмжээний төлөвлөсөн хэмжээнд хувиар тооцно.

Ахиц дэвшил: Санхүүгийн зохицуулалтыг хэрэгжүүлэх салбарын хүрэх үр дүнгээр тодорхойлсон нь хөтөлбөрийн талаарх мэдээллийг тодорхой харуулж байна.


Анхаарах асуудал: Цаашид тус хөтөлбөрт нөөцийн мах бэлтгэхээс гадна өөр чиглэлийн арга хэмжээ хэрэгжүүлсэн тохиолдолд шалгуур үзүүлэлт тогтворгүй байх тул динамик өөрчлөлт харах боломжгүй болно. Иймд хөтөлбөрийн үр дүнг илүү тодорхой болгох эсхүл хөтөлбөрийн нэрийг хэрэгжүүлэх чиглэлийн дагуу нарийвчлах шаардлагатай.

Нийгмийн тодорхой бүлэгт чиглэсэн хөтөлбөр

Нийгмийн тодорхой бүлэгт чиглэсэн хөтөлбөрт улсын төсвийн 6 хөтөлбөрийг нэгтгэн тайлагнасан байна. Үүнд:

1. Гэр бүлийн хөгжил, хамгаалал
2. Жендэрийн тэгш байдлыг хангах
3. Залуучууд болон оюутнууд
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгаалал
5. Хүүхдийн хөгжил, хамгаалал
6. Ангилалдаагүй бусад

Зураг № 50 Суурин хүн ам, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар, 2022,2023



Нийт хүн амын дүнд эзлэх хувийг өмнөх онтой харьцуулахад 0-14 насны хүүхдийн эзлэх хувь 0.6 пунктээр буурч, 15-59 насны хүн амын эзлэх хувь 0.1 пунктээр, 60-аас дээш насны хүн амын эзлэх хувь 0.5 пунктээр тус тус нэмэгдсэн. Хүн амын насны бүтцийн өөрчлөлтийг илүү харуулж чадах, эдийн засгийн тодорхой ач холбогдолтой үзүүлэлт бол хүн ам зүйн ачаалал юм. Хүн ам зүйн ачаалал буюу хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох хүүхэд, өндөр настны тоо нь хүн амын нийгэм, эдийн засгийн чухал үзүүлэлтийн нэг билээ. Хүн ам зүйн ачаалал 2023 онд 56.0 хувь болж, өмнөх

оноос 0.8 пунктээр, 2020 оноос 0.3 пунктээр тус тус буурчээ²⁷.

Нийгмийн тодорхой бүлгүүдэд чиглэсэн хэд хэдэн хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бөгөөд аймгийн хэмжээнд “Нийгмийн халамжийн зорилтот бүлгийн иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлнэ” зорилтын хүрээнд халамж, хөдөлмөр эрхлэлт, “Гэр бүлийн эрүүл, тогтвортой байдлыг хангана” зорилтын хүрээнд “хүүхдийн эрхийг хангах, “Хүний эрхийн баталгаа хангагдсан 80 орны нэг болно” зорилтын хүрээнд жендэрийн чиглэлийн хөтөлбөрүүдийг төлөвлөсөн байна.

1. Хүүхдийн эрх, хамгааллын тухай хуулиар хүлээсэн эцэг, эх, асран хамгаалагчийн үүрэг, хариуцлага, гэр бүлийн үнэ цэнэ зэрэг 44 төрлийн гарын авлагыг бэлтгэж хөдөөгийн багийн 3305 өрхөд хүргэсэн. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын албан ёсны цахим хуудсанд 46 цуврал хүүхэд хүмүүжлийн эерэг аргын зөвлөмж постер, 6 төрлийн подкаст, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хялбаршуулсан 15 төрлийн танилцуулгыг бэлтгэн байршуулж, иргэд олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан.

Өсвөрийн парламент, "Байгальд ээлтэй залуусын чуулган", "Би эстрадын дуучин", "Хүрэл тулга-2024", "Яргуй-2024", "Сансрын 7 хоног", "Сэтгэлзүйн өдөрлөг" зэрэг 9 төрлийн хүүхдийн хөгжил оролцоог дэмжсэн үндэсний болон орон нутгийн зөвлөгөөн, хэлэлцүүлэг, сургалт, уралдаан тэмцээн, чөлөөт арга хэмжээнд 4900 гаруй хүүхэд оролцож өөрийн үзэл бодол, авьяас чадвараа таниулсан. Хүүхдийн өмнө үүрэг хүлээгч байгууллага, албан тушаалтнуудыг чадавхжуулах зорилгоор байгууллагуудын эцэг эхийн зөвлөлийн гишүүдийн сургалт, сумдын хамтарсан багийн сургалтыг зохион байгуулж 32 байгууллага, 14 сумын нийт 118 албан тушаалтан хамрагдсан.

2. “Түншлэл ба хөгжил” зорилтот жилийн хүрээнд орон нутагт эмэгтэйчүүдийн оролцоог бэхжүүлэх, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх түүнчлэн эмэгтэйчүүдийн манлайлал болон гэр бүлд чиглэсэн соён гэгээрүүлэх сургалт мэдээллийг хүргэх зорилгоор Аймгийн засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/415 дугаар захирамжийн дагуу ажлын хэсгийн ахлагчаар аймгийн Засаг даргын орлогч Г.Март, нарийн бичгийн даргаар Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга М.Мөнхбат, МЭХ-ны Дорноговь аймаг дахь салбарын тэргүүлэгч Б.Буянжаргал болон нийт 21 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсгийг байгуулсан. Тус чуулганыг Аймгийн Засаг даргын 2024 оны А/419 тоот захирамжийн дагуу 110,841,600 төгрөгийг шийдвэрлэн Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь аймгийн нийт 600 оролцогчдыг хамруулан арга хэмжээг зохион байгуулсан. Арга хэмжээний үр дүнд салбар, салбарын төлөөлөл болсон эмэгтэйчүүд өөрсдийн дуу хоолойгоо өргөж, орон нутгийн эмэгтэйчүүдийн дунд тулгарч буй асуудал болон цаашид орон нутгийн зүгээс жендэр, гэр бүлд чиглэсэн асуудлуудыг дэвшүүлсэн. Түүнчлэн гэр бүлийн соёл, эмэгтэйчүүдийн манлайллын сэдвүүдээр чуулганд оролцогчдод сургалт илтгэлийг хүргэж соён гэгээрүүлсэн.

3. Аймгийн Засаг даргын 2024 оны А/511 тоот захирамжийн дагуу 6,509,600 төгрөгийг шийдвэрлэн 2024 оны 06 сарын 12-ны өдрөөс 06 сарын 14 өдрийн хооронд Дорноговь аймгийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар- Эрүүлжин хөгжих төв, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв хамтран аймгийн тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдүүд болон эцэг эх, асран хамгаалагч нарт эрүүл мэндийн үзлэг оношилгоо хийж, зөвлөгөө мэдээлэл өгч хамтран ажилласан. Тус үзлэгээр давхардсан тоогоор 666 хүүхдэд үзлэг хийж, эцэг эх асран хамгаалагчдад сэргээн засах тусламж үйлчилгээ болон хүүхдийн хөгжил, оролцоо, нийгмийн амьдралд тэгш хамруула, хөгжлийн бэрхшээлийг сэргээн засах зөвлөгөө өгч цаашдын эмчилгээ, хүүхдийн хөгжлийн талаар туслан зөвлөсөн. Уг үзлэг оношилгоог зохион байгуулснаар эмнэлгийн тусламж үйлчилгээ, зөвлөгөө мэдээллийг өөрийн орон нутагт түргэн шуурхай авах нөхцөл боломж бүрдсэн бөгөөд нарийн мэргэжлийн эмч нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд,

²⁷ Эх сурвалж: Дорноговь аймгийн статистикийн хэлтэс. Дорноговь аймгийн 2023 оны статистикийн эмхэтгэл.

тэдний эцэг эх, асран хамгаалагчдын сэтгэцийн эрүүл мэндийн асуудал, хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг багасгахад анхаарах асуудлыг танилцуулан, хөгжлийн бэрхшээлийн талаар эерэг ойлголтыг түгээсэн. Цаашид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвтэй эрүүл мэндийн цогц үзлэг оношилгоог үе шаттайгаар зохион байгуулахад хамтран ажиллах таатай нөхцөл бүрдсэн.

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тус салбарын зорилтыг “Жендерийн тэгш байдлын үзүүлэлтийг 15 хувиар сайжруулна.” , “5.3. Хүний хүчин зүйлээс хамааралтай осол гэмтлийн гаралтыг 5 хувиар бууруулна” гэж тодорхойлсон. Тус хоёр зорилтын хүрээнд нийт 4 хөтөлбөр, 5 хөтөлбөрийн хүрэх үр дүн, 16 шалгуур үзүүлэлтээр хэмжихээр төлөвлөсөн. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагааны нийт үр дүнгээр төсвийн ерөнхийлөн захирагчийн “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” хөтөлбөрийн үр дүн илэрхийлэгдсэн байна.

1. Жендерийн тэгш байдлын үзүүлэлтийг 15 хувиар сайжруулна.

Тус үр дүнгийн хүрээнд “Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, салбар дундын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх”, “Орон нутгийн төрийн захиргааны байгууллагад жендер хариуцсан орон тоог бий болгох” хоёр хөтөлбөрийн хүрэх үр дүн төлөвлөсөн.

1.1. “Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, салбар дундын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх” арга хэмжээг “хэрэгжилтийн хувь” шалгуур үзүүлэлтээр хэмжихээр төлөвлөж, 2024 онд 70 хувьд хүргэхийг төлөвлөснөөс 30 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилтээр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ХГБХХГ-аас зохион байгуулсан жендерийн хэвшмэл ойлголтын талаар "Тэгш хүртээмжтэй байдал залуусын манлайлал" сургалтад аймгийн ХГБХХГ -ын Залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн сургагч багшаар бэлтгэгдэн "Жендэрт хүйс хамаатай юу?", "Охид хөвгүүдийнхээ талаар ярилцъя", "Аз жаргалтай гэр бүлийг бүтээцгээе", "Эрүүл мэндээ хамтдаа хамгаалцгаая" зэрэг 10 сэдвээр 480 иргэнд сургалт мэдээлэл өгсөн. Дорноговь аймгийн ХГБХХГ-ын даргын 2023 оны А/39 дугаар тушаалын төлөвлөгөөний дагуу Жендерийн тэгш байдлын сургалтыг 5 дугаар сарын 4-20-ны өдрийн хооронд Дорноговь аймгийн Сайншанд, Замын-Үүд, Өргөн, Хатанбулаг, Хөвсгөл, Алтанширээ, Их хэт сум болон аймгийн Цагдаагийн газар, ШШГГ, АШУҮИС-ын оюутан, залуучууд, албан хаагч 312 иргэнд жендерийн хэвшмэл ойлголтын хор уршгийн талаарх мэдлэг, мэдээллийг түгээж ажилласан. Жендерийн хэвшмэл ойлголтыг халах зорилгоор "Залуу гэр бүлийн зөвлөгөөн", "Хосын сургалт", "Жендэрт суурилсан гэр бүлийн хүчирхийлэл", "Гэр бүлийн үнэ цэнэ", "Гэр бүлийн үндсэн үүрэг хариуцлага" "Нандин" чуулган, "Охидын өдөр", "Цагаан сарнай" зэрэг 8 төрлийн арга хэмжээг зохион байгуулж 1510 иргэн хамрагдан жендерийн хэвшмэл ойлголт, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг ойлголттой болсон. “Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан” ТББ-ын Замын-Үүд дэх салбараас сургууль, цэцэрлэгийн 100 гаруй залуу эмэгтэй багш ажилчдад “Өөрийгөө хайрлая”, “Жендэрт суурилсан хүчирхийлэл, түүний суурь шалтгаан” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Мөн Дорноговь, Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр аймгуудын 600 гаруй эмэгтэйчүүдийг хамруулж нийгэмд тулгамдаж буй асуудал, оролцох оролцоо, хандлага төлөвшилийг сайжруулах чиглэлээр “Дулаахан” говийн бүсийн эмэгтэйчүүдийн чуулганыг зохион байгуулсан.

1.2. “Орон нутгийн төрийн захиргааны байгууллагад жендер хариуцсан орон тоог бий болгох” арга хэмжээг “батлагдсан орон тоо” шалгуур үзүүлэлтээр хэмжихээр төлөвлөж, 2024 онд 1 орон тоо бий болгохоор төлөвлөсний дагуу Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн баталх тухай 2024 оны 01 сарын 02-ны өдрийн А/02 дугаар захирамжийн дагуу Нийгмийн бодлогын хэлтсийн Жендерийн эрх тэгш байдал, салбар дундын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтний орон тоог батлаж, томилогдон ажиллаж байна.

Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 21%

Нийгмийн тодорхой бүлэгт чиглэсэн үйлчилгээ ажиллагаа хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 2,497.4 сая төгрөг төлөвлөгдсөн бөгөөд үүнээс 2024 оны эхний 6 сард 1.3 тэрбум төгрөг хуваарилсан. Нийт төсвийн 21 хувьтай тэнцэх буюу 0.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 30%

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Эмэгтэйчүүд, залуучууд, гэр бүлийн хөгжлийн чиглэлээр сургалт, нөлөөллийн ажлыг нэмэгдүүлнэ” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 30% байна.

Хөтөлбөрийн гүйцэтгэл: 30%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлттэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 30 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: 8.7%

Хөтөлбөрийн үр ашиг нь 8.7 хувь буюу “үр ашигтай” гарсан.

ЗУРАГ № 51 Нийгмийн тодорхой бүлэгт чиглэсэн хөтөлбөрийн биелэлт



Аргачлал: Тухайн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлант хугацаанд дахь зохион байгуулахаар төлөвлөсөн арга хэмжээний тооны эзлэх хувиар тооцно.

Ахиц дэвшил: Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр нь тусгайлсан зорилтот хөтөлбөрүүдээр хэрэгждэг тул аймгийн ХЖТ-тэй уялдаатай боловсруулагдсан.

Анхаарах асуудал: Төсвийн хөтөлбөрийг үнэлэх “зорилтот хөтөлбөрийн хэрэгжилт” шалгуур үзүүлэлт нь ерөнхий байдлаар тодорхойлогдсон тул гүйцэтгэлийн хувийг хянаж нягтлах боломжгүй байна. Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд туссан жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хоёр хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд тодорхой тул цаашид шалгуур үзүүлэлтийг бодлогын баримт бичгийн шалгуур үзүүлэлттэй уялдаатай байдлаар боловсруулах нь зүйтэй.

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих– 72101

Дорноговь аймгийн зүгээс жижиг, дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр “Хүнс хөтөлбөр, Газар тариалан хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. Эдгээр хөтөлбөрүүд нь бодлогын баримт бичгүүд болон Аймгийн ХЖТ-д туссан.

Аймгийн ХЖТ-д тус салбарын зорилтыг “Гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын хангамжийг 3 хувиар нэмэгдүүлнэ.” гэж тодорхойлсон. Тус хоёр зорилтын хүрээнд нийт 2 хөтөлбөр, 8 хөтөлбөрийн хүрэх үр дүн, 8 шалгуур үзүүлэлтээр хэмжихээр төлөвлөсөн. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагааны нийт үр дүнгээр төсвийн ерөнхийлөн захирагчийн “Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх” хөтөлбөрийн үр дүн илэрхийлэгдсэн байна.

“Хүнс” хөтөлбөрийн хүрээнд нийт 4 хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийн хүрээнд үйл ажиллагааг төлөвлөн, хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. “Орон нутгийн хүнс, хөдөө аж ахуй эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг улс бүсийн үзэсгэлэн худалдаанд дэмжин оролцуулах, сурталчлах” арга хэмжээнд “Үзэсгэлэн худалдаанд оролцогчид” шалгуур үзүүлэлтээр хэмжиж 10 иргэнийг оролцуулахаар төлөвлөсөн болон хагас жилийн байдлаар 9 иргэнийг хамарсан арга хэмжээг зохион байгуулсан. “Орон нутгийн-Онцлох



бүтээгдэхүүн"-ийг цувралаар танилцуулах арга хэмжээнд “Тарвас”, “Загсгал цай”, “Тансаг цагаан” ингэний хоормогийг танилцуулан сурталчилсан. Мөн Монгол-Хятадын эдийн засгийн түншлэлийн хүрээнд Зүүн баян багт зохион байгуулсан “Талын түнш” арга хэмжээнд жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгч 12 иргэн, ААН-ийг хамруулж 5,8 сая төгрөгийн борлуулалт хийсэн.

Улаанбаатар хотод босон “Шинэ-Хоршоо” хөдөлгөөний нээлтийн арга хэмжээнд “Өөлий урлан”, “Мондо урлан”, “Chimivie fashion”, “Эсгий урлал” зэрэг бичил бизнес эрхлэгчид бараа бүтээгдэхүүнээ сурталчлан оролцсон. Орон нутгийн газар тариалан, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх, харилцан туршлага судлуулах зорилгоор “Цагаан сар”, “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдааг 14 сумын хэмжээнд жил бүр зохион байгуулж давхардсан тоогоор 523 иргэн, аж ахуйн нэгж, хоршоо нөхөрлөл, малчид оролцож 453.7 сая төгрөгийн борлуулалт хийсэн.

МҮХАҮТ, “Монгол брэнд” ХХК-тай хамтран өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг төрөлжүүлэн, мэдээллийн нэгдсэн бааз (онлайн платформ)-ыг үүсгэж гадаад, дотоодын зах зээлд таниулан сурталчлах ажлыг эхлүүлсэн.

2. “Хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээл олгох” арга хэмжээнд “Дэмжлэгт хамрагдсан иргэн, аж ахуй нэгж” шалгуур үзүүлэлтээр хэмжиж 62.5 сая төгрөгийн зээл олгохоор төлөвлөснөөс 70 хувийг олгосон байна.



“Хүнсний хангамж-аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 63 дугаар тогтоолоор хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих 5-6 хувийн хүүтэй, хөнгөлөлттэй зээлийг олгохоор шийдвэрлэсний дагуу 2024 онд газар тариалан, жимс жимсгэнийн үйлдвэрлэл эрхлэгч 11 иргэн, аж ахуй нэгж хамрагдаж, нийт 188.0 сая төгрөгийн санхүүжилт аваад байна. Мөн Хөвсгөл сум “Хоршоо хөгжүүлэх сан”-гаас мах нөөцлөх хөргүүртэй агуулах барих 1 иргэнд 120 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон.

3. “Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар төлөвлөгөөт, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалт зохион байгуулах” арга хэмжээнд “Хяналт шалгалтад хамрагдсан



сум, зөрчлийн бууралт” шалгуур үзүүлэлтээр хэмжиж 14 арга хэмжээ төлөвлөснөөс хагас жилийн байдлаар 70 хувийн хэрэгжилттэй байна. Аж ахуйн нэгж, иргэдийн нөөц бүрдүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн явцад хүнсний худалдаа, хоол, үйлдвэр үйлчилгээний чиглэлээр 5 удирдамжийн хүрээнд нийт 194 объектийн хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, 850 зөрчил дутагдлыг илрүүлж 296 буюу 34,82%-ыг арилгуулан, зөрчил ихээр илэрсэн 16 иргэн, аж ахуйн нэгж

байгууллагад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 493 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, 43 иргэн, аж ахуй нэгжид улсын байцаагчийн зөвлөмжийг хүргүүлэн ажиллаж байна.

4. “Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх тохиромжтой байршлуудад ҮТП байгуулах хувийн хэвшлийг инженерийн дэд бүтцээр дэмжих” арга хэмжээнд “дэд бүтцийг дэмжих дэмжлэгийн тоо” шалгуур үзүүлэлтээр хэмжихээр төлөвлөсөн ба эхний хагас жилд 1



дэмжлэг төлөвлөснөөс 70 хувийн гүйцэтгэлтэй үйл ажиллагаа хэрэгжсэн байна. Орон нутгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих зорилгоор Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолборыг байгуулахаар Сайншанд сумын 2-р багийн нутаг дэвсгэрт 849 м2 газрыг аймгийн Засаг даргын 2023 оны А/589 дүгээр захирамжаар шийдвэрлэж хашааг барих, суурь цутгах ажлыг эхлүүлж ажлын явц 90%-тай үргэлжилж байна. “Мөрөөдлийн говь” ХХК нь 180,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд суманд 0,7 га-д хүлэмжийн аж ахуйн цогцолбор байгуулах ажлыг эхлүүлж, гүйцэтгэл 50%-тай явагдаж байна. Орон нутгийн

жиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих ХАА-н үйлдвэрлэлийн цогцолборыг байгуулахаар Сайншанд сумын 2-р багийн нутаг дэвсгэрт 849 м² газрыг аймгийн Засаг даргын 2023 оны А/589 дүгээр захирамжаар шийдвэрлэж ажлын явц 95 %-тай үргэлжилж байна.

“Газар тариалан” хөтөлбөрийн хүрээнд нийт 4 хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийн хүрээнд үйл ажиллагааг төлөвлөн, хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. “Газар тариалангийн эрхлэгчдийн нэгдсэн сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулах” арга хэмжээнд “Зохион байгуулсан сургалт” шалгуур үзүүлэлтээр хэмжихээр төлөвлөж 1 арга хэмжээ



төлөвлөсөн нь бүрэн хэрэгжсэн. “ГАЗАР ТАРИАЛАНГ ХӨГЖҮҮЛЭХЭД ӨРТГИЙН СҮЛЖЭЭГ САЙЖРУУЛАХ НЬ” сэдвийн дор аймгийн тариалан эрхлэгчдийн зөвлөгөөн, сургалтыг аймгийн Засаг даргын Тамыг газар, Best хөтөлбөр, Ус цаг уур орчны шинжилгээний төв, Статистикийн хэлтэс, сумдын ЗДТГ, Дорнын говийн тариаланчид ТББ-тай хамтран 2024 оны 04-р сарын 15-ны өдөр Сайншанд суманд зохион байгуулав. Сургалтанд ХХААХҮЯ-ны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга болон мэргэжилтэн оролцож “Монгол оронд газар тариаланг хөгжүүлэх чиглэлээр

барьж буй төрийн бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, газар тариалангийн цахим систем” сэдвүүдээр 14 сумын тариалан эрхлэгчид, газар тариалан хариуцсан мэргэжилтнүүд болон ТББ-ын төлөөлөл нийт 80 гаруй хүнд мэдээлэл, зөвлөгөө өгсөн. Сургалтын хүрээнд Сайншанд сумаас баруун тийш 4,5 км-т “Хорвоогийн бөмбөлгөн гэрэл” хоршооны талбайд талбайн өдөрлөг зохион байгуулж Улсын улсын аварга ногоочин Л.Лувсанпүрэв хөрс боловсруулах технологийн талаар арга туршлага хуваалцсан.

2. “Өрхийн тариалан эрхлэгчдэд хүлэмжийн дэмжлэг үзүүлэх” арга хэмжээнд “Нийлүүлсэн



хүлэмж, тариалсан талбай” шалгуур үзүүлэлтээр хэмжихээр төлөвлөж, 95 хүлэмж, 12320 м² талбайг хамруулахаар төлөвлөснөөс эхний хагас жилийн байдлаар 90 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна. Сайншанд суманд 0,7 га-д хүлэмжийн аж ахуйн цогцолбор байгуулах ажлыг 2024 онд 180,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Мөрөөдлийн говь” ХХК шалгарч гэрээ байгуулж ажлыг эхлүүлээд, гүйцэтгэл 50%-тай явагдаж байна. Тус цогцолбор 6 нарлаг хүлэмж, 50 ширхэг 20:6 хүлэмж байгуулах ба одоогоор 30 хүлэмжийг барьж тариалалтаа хийгээд байна.

3. “Өрхийн тариалан эрхлэгчдийн техникийн шинэчлэлд дэмжлэг үзүүлэх” арга хэмжээнд “Техник шинэчлэлтэд хамрагдсан тариалан эрхлэгч” шалгуур үзүүлэлтээр хэмжихээр төлөвлөж



нийт 40 тариалан эрхлэгч хамруулахаас эхний хагас жилд 21 иргэн хамруулсан байна. Дэлхийн зөн ОУБ-ын “Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг” төслийн хүрээнд Иххэт суманд малын тэжээлийн ургамал тариалах “Өнгөт” малчдын бүлэгт 79,0 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмжийг олгосноос гадна Аймгийн ИТХ-ын дарга Б.Ганзориг зарим тариаланчдад нэн шаардлагатай байгаа хөрс халаагч, ургамал хамгааллын автомасыг 21 иргэнд өгч дэмжлэг үзүүлсэн. Агропаркын засвар үйлчилгээ болон гар багаж үйлдвэрлэгч иргэн Жаргалсайхан багаж тоног

төхөөрөмжийн үзэсгэлэн гаргаж тариаланчдад нийлүүлэн ажиллаж байна. Энэ онд тус аймагт “Шинэ хөдөө” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж 1,7 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хүнсний ногооны орчин үеийн механикжсан зоорь барихаар тендер зарлах ажлын бэлтгэлийг хангаж байна.

4. “Ургацын урьдчилан баланс тогтоох” арга хэмжээнд “хамрагдсан сумын тоо” шалгуур үзүүлэлтээр хэмжиж, бүх сумдыг буюу 14 сумыг хамруулахаар тооцсоноос эхний хагас жилийн тайлан боловсруулах хугацаанд баланс тогтоох үйл ажиллагаа үргэлжилж байсан бөгөөд урьдчилсан байдлаар 30 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 10%

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 3,774.4 сая төгрөг төлөвлөгдсөн бөгөөд үүнээс 2024 оны эхний 6 сард 2,073.1 төгрөг хуваарилсан. Нийт төсвийн 10 хувьтай тэнцэх буюу 198.3 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 33%

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Орон нутгийн бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжин хөгжүүлэх зорилтот хөтөлбөр хэрэгжүүлнэ.” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 33% байна.

Хөтөлбөрийн гүйцэтгэл: 33%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлттэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 33 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: 23.8%

Хөтөлбөрийн үр ашиг нь 23.8 хувь буюу “үр ашигтай” гарсан.

ЗУРАГ № 52 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн биелэлт



Аргачлал: Тухайн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлант хугацаанд дахь хэрэгжилтийн хувиар тооцно.

Ахиц дэвшил: Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр нь тусгайлсан зорилтот хөтөлбөрүүдээр хэрэгждэг тул аймгийн ХЖТ-тэй уялдаатай боловсруулагдсан.

Анхаарах асуудал: Төсвийн хөтөлбөрийг үнэлэх “зорилтот хөтөлбөрийн хэрэгжилт” шалгуур үзүүлэлт нь ерөнхий байдлаар тодорхойлогдсон тул гүйцэтгэлийн хувийг хянаж нягтлах боломжгүй байна. Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд туссан жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хоёр хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд тодорхой тул цаашид шалгуур үзүүлэлтийг бодлогын баримт бичгийн шалгуур үзүүлэлттэй уялдаатай байдлаар боловсруулах нь зүйтэй.

Засгийн газрын өрийн үйлчилгээ– 70203

Монгол Улсын Засгийн газар Азийн Хөгжлийн банкны хооронд байгуулсан “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3388 төсөл” буюу аймгийн төвийн цэвэрлэх байгууламж барих буюу 2019-2022 оны ажлын гүйцэтгэлийн санхүүжилт хийгдэж цэвэрлэх байгууламж нь баригдаж дууссан. Тус ажлын орон нутаг эргэн төлөгдөх зээлийг жил болгон Сангийн яамны баталсан хуваарийн дагуу төлж барагдуулах үүрэгтэй бөгөөд хагас жилийн байдлаар орон нутгийн орлогын төлөвлөрүүлэлт хангалтгүй байсан тул 2024 оны эхний хагас жилд төлөлт хийгдээгүй байна.

Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 4%

Засгийн газрын өрийн үйлчилгээ хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 577.7 сая төгрөг төлөвлөгдсөн бөгөөд үүнээс 2024 оны эхний 6 сард 300.0 сая төгрөг хуваарилсан. Нийт төсвийн 0 хувьтай тэнцэх буюу гүйцэтгэл гараагүй.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 0%

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Гадаад зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан дээлдүүлсэн зээлийн өрийг барагдуулна.” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 0% байна.

Хөтөлбөрийн гүйцэтгэл: 0%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлтэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 0 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: 0%

Хөтөлбөрийн үр ашиг нь 0 хувь буюу “үр ашигтай” гарсан.

ЗУРАГ № 53 ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ



Аргачлал: Тайлант хугацаанд төлөвлөсөн өрийг хэмжээг барагдуулан төвлөрүүлсэн дүнгийн хувиар тооцно.

Ахиц дэвшил: Өр төлбөр барагдуулах үйл ажиллагааг хөтөлбөр, үр дүнгийн тайланд багтааж, шалгуур үзүүлэлттэй болгон үнэлэж байгаа нь дэвшилттэй.

Анхаарах асуудал: Өрийн удирдлагын бодлого, зохицуулалтын хүрээнд өрийн зохистой түвшинг хангах, дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх, Засгийн газар, орон нутаг зээллэг хийх замаар улс орны төсөв, эдийн засагтай шууд уялдах тус арга хэмжээг Аймгийн ЖХТ-нд тусган хэрэгжүүлэх нь зүйтэй.

Хот байгуулалт, тохижилт – 71502

Сайншанд, Замын-Үүд сумдын Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, Хот тохижилтын байгууллагын үйл ажиллагаанд чиг үүргийн шинжилгээ хийх үүрэг хүргүүлж, чиг үүргийн шинжилгээг асуулга, ажлын байрны зураг авалтын аргаар хийж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан ирүүлснийг үндэслэн, сумын Захирагчийн ажлын алба, Хот тохижилтын байгууллагыг нэгтгэх замаар чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах арга хэмжээ авч ажилласан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог чиг үүргийн оновчтой хуваарилж зарчмаар шинэчилж аймгийн Засаг даргын 2024 оны А/02 дугаар захирамжаар баталсан. Аймгийн Засаг даргын 2024 оны А/09 захирамжаар аймгийн Худалдан авах ажиллагааны газрын, мөн А/10 захирамжаар аймгийн Орон нутгийн өмчийн газрын бүтэц орон тоог тус тус шинэчлэн баталж, байгууллагуудын удирдлагын сонгон шалгаруулалтыг явуулж, томилон ажиллаж байна.

Худалдан авах ажиллагааны газрыг 2023 онд багтаан шинээр байгуулан ажиллагсдын цалин хөлсний зардалд 11.2 сая төгрөгийг ОНӨГ-аас төсвөөс шилжүүлэн орон нутгийн 2023 оны төсвийн зохицуулалтаар шийдвэрлэсэн.

Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 73%

Хот тохижилт хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 22.1 тэрбум төгрөг төлөвлөгдсөн бөгөөд үүний 22.1 тэрбум төгрөг нь хөрөнгө оруулалтын зардал байна. Нийт төсвөөс 2024 оны эхний 6 сард 7.6 тэрбум төгрөг хуваарилсан. Нийт төсвийн 73 хувьтай тэнцэх буюу 5.6 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 29%

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Ард иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 29% байна.

Хөтөлбөрийн гүйцэтгэл: 29%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлттэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 29 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: -44%

Хөтөлбөрийн үр ашиг нь -44 хувь буюу “үр ашигтай” гарсан.

ЗУРАГ № 54 ХОТ БАЙГУУЛАЛТ, ТОХИЖИЛТ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ



Аргачлал: Тайлант хугацаанд хот тохижилт, нийтийн ахуйн үйлчилгээний чиглэлээр төлөвлөсөн ажил, арга хэмжээний хэрэгжилтийн хувь

Ахиц дэвшил: Хот тохижилт, нийтийн ахуйн үйлчилгээний чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний тоон шалгуур үзүүлэлт нь “Ард иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ” гэсэн зорилтод шууд хамаарах арга хэмжээг тооцох тул хялбар, энгийн байгаа нь давуу тал болж байна.


Анхаарах асуудал: Иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлэх төрийн чиг үүрэгтэй хот тохижилтын хөтөлбөрийн арга хэмжээ шууд холбогдож, тогтмол хэрэгжиж байгаа боловч Аймгийн ЖХТ-нд шууд хамаарах арга хэмжээ, үр дүн төлөвлөгөөгүй байгаа нь хот тохижилтийн үйлчилгээг сайжруулах, шинээр арга хэмжээ хэрэгжүүлэх боломжийг хязгаарлах магадлалтай тул үр дүн, үр нөлөөг илэрхийлж болохуйц шалгуур үзүүлэлт бүхий хөтөлбөрийг АЖХТ-д тусгах нь чухал.

Хил хамгаалах – 70602

Хилийн цэргийн 0129, 0168, 0108 дугаар ангиудад орон нутгаас жил бүр дэмжлэг үзүүлж ирсэн. Тус дэмжлэгийн хүрээнд хилийн цэргийн ангиуд хилчдийн ажиллах, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ажилчдын орон сууц болон ажлын байрны их засварын ажилыг хийж гүйцэтгэсэн. Мөн хилийн торон саадыг үе шаттайгаар засварлах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Нийт 4 төсөл арга хэмжээний гүйцэтгэлд 367,7 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

Аймгийн ЖХТ-д “Улсын хил хамгаалал хөтөлбөр”-ийн хүрээнд “Хил хамгаалах чадавхыг 20 хувиар нэмэгдүүлнэ.” Зорилтыг тодорхойлж, нийт 2 хүрэх үр дүн шалгуур үзүүлэлт, үр дүн тодорхойлсон. Үүнд:

1. “Хилийн ангиудад орчин үеийн техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, хилчдийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх” арга хэмжээг “үзүүлсэн “дэмжлэгийн тоо” шалгуур үзүүлэлтээр хэмжихээр төлөвлөсөн. Тус оны хагас жилийн байдлаар төлөвлөсөн 6 дэмжлэгээс 5 дэмжлэг хэрэгжүүлж, 90 хувийн гүйцэтгэлээр тайлагнасан байна. Хилийн цэргийн ангийн орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 15/08 дугаар тогтоолоор баталсан Дорноговь аймгийн 2024 оны төсөвт хилийн цэргийн 0108, 0129 дүгээр ангид тус тус 80,0 сая төгрөг, 0168 дугаар ангид 180.0 сая төгрөг нийт 340 сая төгрөгийг олгохоор баталсан. Үүнээс хилийн цэргийн 0129, 0108 дугаар ангийн нийт 160.0 сая төгрөгийг дэмжлэгийг үзүүлээд байна. Зэвсэгт хүчний болон Хилийн ангиудын үйл ажиллагааг дэмжих зорилгоор Орон нутгийн төсөвт 588.2 сая төгрөгийг батлуулж, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилтийг олгосон.



2. “Хилийн өргөст торон саадыг үе шаттай засварлахад дэмжлэг үзүүлэх” арга хэмжээг “дэмжлэгийн тоо” шалгуур үзүүлэлтээр хэмжихээр төлөвлөсөн. 2024 оны эхний хагас жилийн байдлаар 3 арга хэмжээ төлөвлөснөөс 1 арга хэмжээ хэрэгжүүлсэн байна. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 15/09 дүгээр тогтоолоор батлагдсан “Дорноговь аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-д хилийн өргөст торон саадыг үе шаттайгаар засварлах дэмжлэгийг үзүүлэхээр ажиллаж байна.



Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 47%

Хил хамгаалах үйл ажиллагаа хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 340.0 сая төгрөг төлөвлөгдсөн бөгөөд үүнээс 2024 оны эхний 6 сард 340.0 сая төгрөг хуваарилсан. Нийт төсвийн 47 хувьтай тэнцэх буюу 320.0 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 33%

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Хилийн халдашгүй дархан байдлыг хангахад дэмжлэг үзүүлнэ.” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 33% байна.

Хөтөлбөрийн гүйцэтгэл: 33%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлттэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 33 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: -13%

Хөтөлбөрийн үр ашиг нь -13 хувь буюу “үр ашигтай” гарсан.

ЗУРАГ № 55 ХИЛ ХАМГААЛАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ



Аргачлал: Тайлант хугацаанд хил хамгаалах ангиудыг дэмжихээр төлөвлөсөн ажил, арга хэмжээний хэрэгжилтийн хувь

Ахиц дэвшил: Улсын хил хамгаалах хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг АХЖТ болон бодлогын баримт бичигтэй уялдсан байдлаар төлөвлөсөн ба жилийн хөгжлийн төлөвлөгөөнд нарийвчилсан чиглэл бүрээр хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөсөн ба төсвийн хөтөлбөрт үүнээс тодорхой арга хэмжээний тоог сонгож тогтоосон нь бодлогын баримт бичгийн уялдааг хангаж, ижил төстэй байдлаар үнэлэх, үр дүнг харьцуулах боломжийг олгож байна.

Анхаарах асуудал: Хил хамгаалах хөтөлбөрт үйл ажиллагааны хэрэгжилтийн тоо хэмжээг шалгуур үзүүлэлтээр сонгосон нь цаашид тус салбар, хөтөлбөрийн нийгэм, эдийн засаг, орон нутагт үзүүлэх үр дүн, үр нөлөөг шууд илэрхийлэх боломжгүй байна. Иймд шалгуур үзүүлэлтийг үр дүнг хэмжих боломжтой, тогтвортой эх үүсвэрээр тооцох шалгуур үзүүлэлтээр өөрчлөх, бодлогын бусад баримт бичгүүдийн шалгуур үзүүлэлттэй уялдуулах талаар судалж шинэчлэх шаардлагатай.

Зэвсэгт хүчин– 70601

Монгол Улсын Зэвсэгт хүчин, БНХАУ-ын Ардын чөлөөлөх армийн Хуурай замын цэргийн хамтарсан “Талын түнш-2024” хээрийн сургуулийг тус аймгийн нутаг дэвсгэрт зохион байгуулсан ба хоёр орны найрамдал харилцааг хөгжүүлж, цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, харилцан туршлага солилцох, суралцах, бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг хангахад хоёр орны хүчин чармайлтыг нэмэгдүүлэх зорилготой тус сургуульд 2 улсын 500 гаруй алба хаагчид оролцож, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжиж 400 гаруй нарс модноос бүрдсэн “Найрамдлын төгөл”-ийг байгуулсан.

Зэвсэгт хүчний үйл ажиллагааг АЖХТ-нд “Зэвсэгт хүчин” хөтөлбөрийн хүрээнд “Иргэдийн эх оронч үзлийг төлөвшүүлнэ” гэх зорилтын хүрээнд 4 хөтөлбөрийн хүрээнд тодорхойлсон. Үүнд:

1. “Салбарын бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлан таниулж, эх оронч үзлийг төлөвшүүлэх арга хэмжээ зохион байгуулах” арга хэмжээг “Зохион байгуулсан арга хэмжээний тоо” шалгуур үзүүлэлтээр хэмжихээр төлөвлөж 2024 онд 10 арга хэмжээг төлөвлөсөн бол хагас жилийн байдлаар 8 арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.


2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр 2024 он 03 дугаар сарын 16-ны өдөр Дорноговь аймаг дахь Төрийн цэргийн болон Хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын дунд сагсан бөмбөгийн тэмцээн, 2024 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Зүүнбаян цэргийн хүрээний марш тактик тусгай



бэлтгэлийн аварга тасаг шалгаруулах тэмцээн, 03 дугаар сарын 17-ны өдөр орон нутгийн DSB телевизтэй хамтран "МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР" цэргийн баярын дугаар нэтрүүлэг, 03 дугаар сарын 18-ны өдөр Монгол цэргийн өдөр, Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 103 жилийн ойг тохиолдуулан аймаг цэргийн алдар цолтой 128 бөх, өсвөрийн 32 бөхийн барилдааныг тус тус зохион байгуулсан. Монгол цэргийн өдөр, Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 103 жилийн ойг Дорноговь аймгийн Төрийн цэргийн болон Хууль сахиулах байгууллагуудын хүрээнд хөдөлмөрийн болон хөдөлгөөний аюулгүй байдлыг мөрдлөг болгон

батлагдсан хөтөлбөр төлөвлөгөөний дагуу амжилттай зохион байгуулж ажилласан. Батлан хамгаалах сайдын 2024 оны А/63 дугаар тушаал, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаал, Хуурай замын цэргийн командлагчийн А/107 дугаар тушаалуудыг үндэслэн “ТАЛЫН ТҮНШ-2024” байлдааны буудлагатай тактик хээрийн сургууль 2024 оны 05 дугаар сарын 12-оос 19-ний өдрүүдэд Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян баг Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн сургалтын районд амжилттай зохион байгуулсан. Дорноговь аймгийн Боловсрол шинжлэх ухааны газар, Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуультай хамтран “Орон нутгийн онцлогтой хөтөлбөр”-ийн хүрээнд сурагчдын жагсаалын үзүүлэх тоглолт, гардан тулааны үзүүлэх тоглолт, үй олноор хөнөөх зэвсгээс хамгаалах хэрэгслийг өмсөх, АК бууны задаргаа зэрэг хичээлүүдийг ахлах ангийн 150 гаруй сурагчдад зааж сургасан. 2024.06.24 зохион байгуулагдсан дээр үйл ажиллагаанд 200 сурагч хамрагдаж, 300 сурагч, 200 гаруй эцэг эх, ард иргэд үзэж нийт хагас жилийн байдлаар зохион байгуулсан.

2. “Оюутан цэрэг сургалт зохион байгуулах” арга хэмжээг “Сургалтад хамрагдсан оюутан” шалгуур үзүүлэлтээр хэмжихээр төлөвлөж 2024 онд 14 оюутан төлөвлөсөн бол хагас жилийн байдлаар 20 оюутан хамруулсан байна.



Батлан хамгаалах тухай хуулийн 17.1.1 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь заалт, “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, Батлан хамгаалах сайдын 2024 оны “Оюутан-цэрэг” сургалт зохион байгуулж явуулах тухай А/35 дугаар тушаал, Батлан хамгаалахын сайдын Дорноговь аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээний 2.2.1, 3.6 дахь заалтууд, Дорноговь аймгийн Засаг даргын А/266 дугаар захирамжийн дагуу Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны салбар сургуулын


хичээлийн байранд долоо хоногийн амралтын өдрүүдэд зохион байгуулж байна. Сургалтын сонгон шалгаруулалтыг эрүүл мэндийг үзлэг, биеийн тамирын шалгуур үзүүлэлтээр зохион байгуулсан. Хүсэлт гаргаж сонгон шалгаруулалтад тэнцсэн Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны салбар сургуулын нэгдүгээр курсын 14, Политехникийн коллежийн 6 нийт 20 оюутныг “Цэргийн ерөнхий бэлтгэл” шатны сургалтад хамруулж сургалтыг амжилттай зохион байгуулсан. Сургалтад хамрагдаж төгсөлтийн шалгалтад амжилттай дүн үзүүлсэн 20 оюутныг Өмнөговь аймагт зохион байгуулагдах дараагийн шатны сургалтад хамруулсан.

3. “Хилийн цэргийн болон зэвсэгт хүчний анги салбаруудын орчин нөхцөлийг сайжруулах” арга хэмжээг “Ажлын гүйцэтгэлийн хувь хэмжээ” шалгуур үзүүлэлтээр хэмжихээр төлөвлөж “нийт жилийн гүйцэтгэлээр 100% байхаар төлөвлөснөөс 90%



биелэлтээр 2024 оны хагас жилээр дүгнэсэн байна. Хилийн цэргийн ангийн орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 15/08 дугаар тогтоолоор баталсан Дорноговь аймгийн 2024 оны төсөвт хилийн цэргийн 0108, 0129 дүгээр ангид тус тус 80,0 сая төгрөг, 0168 дугаар ангид 180,0 сая төгрөг нийт 340 сая төгрөгийг олгохоор баталсан. Үүнээс хилийн цэргийн 0129, 0108 дугаар ангийн нийт 160,0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлээд байна.

4. “Орон нутгийн хамгаалалт томилгоот нэгжийн сургалт зохион байгуулах” арга хэмжээг Сургалт зохион байгуулсан тоо” шалгуур үзүүлэлтээр хэмжихээр төлөвлөж нийт 3 арга хэмжээ төлөвлөснөөс 2024 оны эхний хагас жилд 1 арга хэмжээг төлөвлөсөн байна. Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалт, 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.6 дахь заалтууд, аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/836 дугаар захирамжын дагуу аймаг сумдын орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг 2024 оны 01 дүгээр сарын 10-аас 28-ны өдрүүдэд тодотгосон. 14 сумын орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүн, ангийн буу, авто техник, агт морь, атан тэмээ, ердийн хөсгийг тус тус томилгоожуулан төлөвлөгөөнүүдэд хавсаргасан. Томилгоо тодотгох үйл ажиллагаа 14 сумын байдлаар 100 хувь хангагдсан. Цэргийн штабын 2024 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн хээрийн сургуулийг 9 дүгээр сард зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.



Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 99%

Зэвсэгт хүчний үйл ажиллагаа хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 248.2 сая төгрөг төлөвлөгдсөн бөгөөд үүнээс 2024 оны эхний 6 сард 248.2 сая төгрөг хуваарилсан. Нийт төсвийн 99 хувьтай тэнцэх буюу 247.7 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 63%

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Харуул хоногийн манааны үүрэг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлнэ.” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 63% байна.

Хөтөлбөрийн гүйцэтгэл: 63%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлттэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 63 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: -37%

Хөтөлбөрийн үр ашиг нь -37 хувь буюу “үр ашигтай” гарсан.

Зураг № 56 Зэвсэгт хүчний хөтөлбөрийн биелэлт



Аргачлал: Тайлант хугацаанд зэвсэгт хүчний ангиудыг дэмжихээр төлөвлөсөн ажил, арга хэмжээний хэрэгжилтийн хувь

Ахиц дэвшил: Зэвсэгт хүчний хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг АХЖТ болон бодлогын баримт бичигтэй уялдсан байдлаар төлөвлөсөн ба жилийн хөгжлийн төлөвлөгөөнд нарийвчилсан чиглэл бүрээр хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөсөн ба төсвийн хөтөлбөрт үүнээс тодорхой арга хэмжээний тоог сонгож тогтоосон нь бодлогын баримт бичгийн уялдааг хангаж, ижил төстэй байдлаар үнэлэх, үр дүнг харьцуулах боломжийг олгож байна.


Анхаарах асуудал: Зэвсэгт хүчний хөтөлбөрт үйл ажиллагааны хэрэгжилтийн тоо хэмжээг шалгуур үзүүлэлтээр сонгосон нь цаашид тус салбар, хөтөлбөрийн нийгэм, эдийн засаг, орон нутагт үзүүлэх үр дүн, үр нөлөөг шууд илэрхийлэх боломжгүй байна. Иймд шалгуур үзүүлэлтийг үр дүнг хэмжих боломжтой, тогтвортой эх үүсвэрээр тооцох шалгуур үзүүлэлтээр өөрчлөх, бодлогын бусад баримт бичгүүдийн шалгуур үзүүлэлттэй уялдуулах талаар судалж шинэчлэх шаардлагатай.

Ойжуулалт – 71403

Дорноговь аймаг ойжуулалтын үйл ажиллагааг идэвхтэй хэрэгжүүлж байгаа бөгөөд тус хөтөлбөрийг улсын төсөвт “тэрбум мод хөтөлбөрийн хэрэгжилт”-ийн хувиар, АХЖТ-нд ойжуулалтыг илүү өргөн цар хүрээ болон зохион байгуулсан үйл ажиллагааны гарцад чиглүүлэн 4 хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтээр хэмжихээр төлөвлөсөн байна.


“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн нь 2030 он гэхэд тэрбумаар тоологдох мод тарьж, арчлан хамгаалж, ургуулснаар ойн санг 9.0%-д хүргэж, цөлжилт, газрын доройтлыг бууруулан, хүлэмжийн хийн шингээлт, усны нөөцийг нэмэгдүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулж, ногоон хөгжлийн сэргэлтийг эрчимжүүлэх, ашигт ургамлын тариалалт нэмэгдүүлж ажлын байр бий болгох, хүнсний хангамжийг сайжруулахад зохих хувь нэмэр оруулах зорилготой. Төсвийн хөтөлбөрийн хүрэх үр дүнг “Тэрбум мод” хөтөлбөрийн хэрэгжилтээр хэмжиж байгаа ба тус хөтөлбөрийн хүрээнд Дорноговь аймаг 72.9 сая мод тарих зорилттой.

Зураг № 57 Ойжуулалт, түүний хувь, жил бүрийн эцэст



Дээрх зурагт харуулсны дагуу Дорноговь аймаг нь сүүлийн жилүүдэд тарих модны тоо 2022 оны тогтол өсөж байсан боловч тарьсан модны тоо болон ургалтын хувь 2023 онд буурч, ургалтын хувь 69 хувьтай байсан байна²⁸. Дорноговь аймгийн АХЖТ-нд ойжуулалтын хөтөлбөрийн зорилтыг “Тарьсан модны ургалтыг 70 хувьд хүргэнэ” гэж тодорхойлж, 2024 оны хагас жилийн урьдчилсан тайлангаар ойжуулалтын хүрээнд дараах 4 чиглэлд арга хэмжээ хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байна. Үүнд:


1. “Ойн анги, мод үржүүлгийн газруудыг тогтвортой үйл ажиллагаа явуулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх” арга хэмжээг “Зөвлөх үйлчилгээнд хамрагдсан иргэн, ААН-ийн тоо” шалгуур үзүүлэлтээр хэмжихээр төлөвлөж нийт жилийн хэмжээнд 120 ААН, иргэнд зөвлөгөө өгөхөөр төлөвлөснөөс хагас жилийн хугацаанд 130 ААН, иргэнд зөвлөгөө өгч хэрэгжүүлсэн байна. Аймгийн хэмжээнд эхний хагас жилийн байдлаар хаврын мод тарих өдрүүдэд 39166 ширхэг мод, бут сөөгийг тарьж, нийт 109 аж ахуйн нэгж байгууллагын 1147 албан хаагчид, ажилчид, иргэд оролцсон. Мөн мод тарих өдрийн хүрээнд Аймгийн БОАЖГазар Сайхандулаан, Улаанбадрах, Эрдэнэ сумдын ЗДТГазартай хамтран мод тарих өдөрлөг зохион байгуулж, ААНБайгууллагууд, иргэдтэй хамтран мод тарьж, модны тайралт арчилгааны заавар зөвлөгөө өгсөн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн



²⁸ Эх сурвалж: Дорноговь аймгийн статистикийн хэлтэс. Дорноговь аймгийн 2023 оны статистикийн эмхэтгэл.


санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх аймгийн зорилтот хөтөлбөрийн биелэлтийг хангах, хаврын мод тарих аяны бэлтгэл ажлыг ханган, өмнөх онд тарьсан модны ургалтын хувийг нэмэгдүүлэх зорилгоор АЗДТГазраас аймгийн хэмжээнд “Усалъя, Ургуулъя, Арчилъя” аянг өрнүүлсэн. Уг аяны хүрээнд сумдууд тарьсан модны тогоог цэвэрлэж сэргээж, усалгаа арчилгаа, тайралт хэлбэржүүлэлтийг хийж, зарим сумд нь шинэ санаачилга болгон ЕБС болон сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүдэд экологийн боловсрол олгож сургалт зохион байгуулсан байна. Дорноговь, Говьсүмбэр аймгийн бүсчилсэн хээрийн дадлага сургалтыг МУИС-ын Ой хүрээлэнтэй хамтран 2024 оны 04 дүгээр сарын 20-ноос 24-ний хооронд Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газрын хурлын танхим, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дэргэдэх Мод үржүүлгийн газарт танхим болон практик хосолсон сургалтад нийт 42 мод тарьж ургуулах сонирхолтой иргэд, албан хаагчид амжилттай хамрагдлаа.

2. “Ойн анги, мод үржүүлгийн газарт ажиллах мэргэжилтэй ажилтан бэлтгэх, сургах” арга хэмжээг “Мэргэжилтэй ажилтны тоо” шалгуур үзүүлэлтээр хэмжихээр төлөвлөж нийт жилийн хэмжээнд 6 мэргэжилтэй ажилтантай үйл ажиллагаа явуулахаар төлөвлөснөөс хагас жилийн хугацаанд 7 мэргэжилтэнтэй ажилтантай болсон байна. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд ойжуулалт, мод тарих заавар зөвлөмж өгөх мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх зорилгоор улсын хэмжээнд “1000 сургагч багш бэлтгэх” сертификат олгох сургалтыг БОАЖЯ, БСШУЯ, ЗГХА, Ойн газар, МУИС-н Ойн хүрээлэнтэй хамтран 2022 оноос эхлүүлсэн ба энэ төрлийн сургалтад мэргэжилтнүүдээ хамруулж мэргэшүүлдэг байна.



3. “Сайншанд суманд сум дундын ойн анги байгуулах” арга хэмжээг “Ойн ангийн тоо” шалгуур үзүүлэлтээр хэмжихээр төлөвлөж нийт жилийн хэмжээнд 1 ойн анги байхаар төлөвлөж, хагас жилийн байдлаар 2 ойн ангитай байна. БОАЖГ-ын дэргэдэх мод үржүүлгийн талбайд 7 хүний бүрэлдэхүүнтэй 9498 м² талбайд хөрс боловсруулалт хийж, нийт 20кг үрээр, 7310 ширхэг мөчрөөр үржүүлэн, тарилт, талбайн цэвэрлэгээ, усалгаа арчилгааны ажлыг хийж байна.

4. “Мод үржүүлгийн газарт шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах” арга хэмжээг “Тоног төхөөрөмжийн тоо” шалгуур үзүүлэлтээр хэмжихээр төлөвлөж 2024 онд 2 тоног төхөөрөмж нийлүүлэхээс хагас жилийн байдлаар 4 тоног төхөөрөмжтэй болсон байна. БОАЖГ-ын дэргэдэх мод үржүүлгийн талбайд хүлэмж (40*8) барьж, 10 ширхэг хөрсний хучлага, 1 ширхэг манантуулагч (8*40), 2 га-д бороожуулагч усалгааны систем, 28 ширхэг туулайнаас хамгаалах (40 метр) тор авч суурилуулан, хүлэмжид агч, жигд, бүйлс моддыг үрээр тарьсан. Мөн гадаа талбайд агч (5кг), бүйлс (900гр), жигд (4кг), хайлаас (10кг) моддыг үрээр тарьж, бургас (1050 ш), сухай (1000 ш), улиас (5260 ш) моддыг мөчрөөр үржүүлэн суулгаж, усалгаа арчилгааг хийж байна.



Хэдийгээр ойжуулалтын чиглэлээр Дорноговь аймгийн хувьд олон чиглэлийн үйл ажиллагаа зохион байгуулсан боловч Аймгийн ИТХ-аар баталсан хөтөлбөрийн хүрэх үр дүн болох “Тэрбум мод” хөтөлбөрийн хэрэгжилтийг хагас жилийн байдлаар тооцоогүй байгаа нь тогтмол тооцох арга зүй байхгүй, бодлогын баримт бичгийн үр дүнтэй шууд уялдахгүй байгаатай холбоотой.

Тоон мэдээлэл:

Төсвийн гүйцэтгэл: 99%

Ойжуулалт хөтөлбөрт 2024 оны батлагдсан төсвөөр 705.3 сая төгрөг төлөвлөгдсөн бөгөөд үүнээс 2024 оны эхний 6 сард 362.9 сая төгрөг хуваарилсан. Нийт төсвийн 66 хувьтай тэнцэх буюу 239.1 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь: 0%

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Тэрбум мод хөтөлбөрийн хэрэгжилт.” гэж тодорхойлогдсон. Хүрсэн түвшин нь нэг шалгуур үзүүлэлтэй тул хүрсэн түвшний гүйцэтгэл 0% байна.

Хөтөлбөрийн гүйцэтгэл: 0%

Тус хөтөлбөр нь нэг хүрэх үр дүн, нэг шалгуур үзүүлэлттэй тул хөтөлбөрийн гүйцэтгэл болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ижил буюу 0 хувиар тайлагнагдсан.

Үр ашиг: -65.9%

Хөтөлбөрийн үр ашиг нь -65.9 хувь буюу “сайжруулах шаардлагатай” гарсан.

ЗУРАГ № 58 ОЙЖУУЛАЛТ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ



Аргачлал: Аймгийн хэмжээнд төлөвлөсөн хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь хэмжээгээр

Ахиц дэвшил: Хөтөлбөрийн хийсэн ажлаар бус улсын хэмжээнд харьцуулан дүгнэх боломжтой, томоохон зорилтын хүрээнд, эцсийн үр дүнд чиглэсэн байдлаар төлөвлөсөн нь дэвшилттэй.

Анхаарах асуудал: Хэдийгээр дүгнэх боломжтой шалгуур үзүүлэлт тогтоосон боловч аймгийн хөгжлийн бусад бодлогын баримт бичгийн шалгуур үзүүлэлттэй шууд давхцахгүй байгаа тул хагас жилээр үр дүнг үнэлэх боломжгүй байна. Иймд цаашид хөтөлбөрийн хэрэгжилтийг хагас жилийн байдлаар тооцдог байхаар тогтмол хэрэглэх арга зүйтэй болгох, бодлогын баримт бичгийн үр дүнтэй шууд уялдалж хэрэгжүүлэх шаардлагатай.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Тус судалгааны тайлан болон Монгол Улсын 2024 оны хагас жилийн бүх төсвийн ерөнхийлөн захирагчдын тайланд үндэслэн дараах санал дүгнэлтийг боловсруулсан тул дурдагдсан асуудал болон сайжруулах санал нь зөвхөн Дорноговь аймагт шууд хамаарахаас илүү бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчдын түвшинд ашиглагдахаар боловсруулагдсан.

| Дүгнэлт | Сайжруулах санал |
|---|--|
| <ul style="list-style-type: none"> Дорноговь аймаг нь 2024 оны төсвийн жилд аймгийн төсвийн хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг сайжруулсан нь хэмжих боломжтой, бодлогын баримт бичигтэй уялдсан байдал сайжирсан байна. | <p>Дорноговь аймгийн хөтөлбөр, үр дүнгийн төлөвлөлт, тайлагналыг сайжруулах зорилгоор НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд зорилтот аймгаар сонгон, бодлогын баримт бичигтэй уялдсан, хөтөлбөр, үр дүнгийн тайлагналын журам, тавигдах шаардлагад нийцүүлэн сайжруулах, зөвлөх үйлчилгээний ажлыг зохион байгуулсны үр дүнд аймгийн 2024 онд баталсан хөтөлбөрийн үр дүн сайжирсан байна.</p> <p>Бусад аймгуудтай харьцуулахад Дорноговь аймгийн хөтөлбөр бүр хэмжиж болохуйц, тогтвортой шалгуур үзүүлэлттэй болсон байна. Мөн нэг хөтөлбөрт тус бүр нэг хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт тодорхойлсон нь цаашид харьцуулах боломжтой, тайлагнах цаг хугацаа, ажлыг хөнгөвчилж байна.</p> <p>Цаашид хөтөлбөр бүрийн шалгуур үзүүлэлтийг оновчтой болгох, төлөвлөлтийн үе шатаас эхлэн хөтөлбөр, үр дүнг тасралтгүй шинэчлэн, сайжруулах шаардлагатай.</p> |
| <ul style="list-style-type: none"> Төсвийн тайлагналын бүх үе шатанд хөтөлбөр, үр дүнгийн тайланг хагас жилээр тайлагнах, нэгтгэх, хянах үйл ажиллагаа төлөвшөөгүйгээс шалтгаалан техник алдаа, зөрүү ихтэй байна. | <p>Хөтөлбөр, үр дүнгийн тайлан нь Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн нэг бүрэлдэхүүн хэсэг тул хуульд заасан хугацаанд бусад тайлангийн адил үнэн зөв, чанартай боловсруулж, тайлагнах, нэгтгэн дүгнэх ажлыг зүгшрүүлэх шаардлагатай байна. Тус тайлан нь 2023 оноос эхлэн тайлангийн журам, аргачлалтай болсон учраас хагас болон бүтэн жилээр боловсруулж, хянаж, нэгтгэх үйл ажиллагааг хариуцлагатай тайлагнах шаардлагатай.</p> |
| <ul style="list-style-type: none"> Орон нутгийн төсвийг төлөвлөх үе шатнаас эхлэх хөтөлбөр, үр дүнгийн тайлангийн боловсруулалт хангалтгүй байгаагаас төсвийн төсөлд сумдын үр дүн нэгтгээгүй, аймгийн ИТХ-аар төсөв батлах явцад сумдын төсөв болон үр дүнгийн мэдээлэл тусгагдаагүй нь аймгийн хэмжээнд төсвийн санхүүжилтээр хэрэгжсэн хөтөлбөрийн үр дүнг бүрэн илэрхийлэхгүй байна. | <p>Орон нутгийн төсвийн төлөвлөх, батлах, хуваарилах үе шатанд хөтөлбөр, үр дүнгийн тайланг аймгийн хэмжээнд тооцох арга зүй дутагдаж байна. Монгол Улсын 2024 оны төсвийн төсөл боловсруулах удирдамжид “2.4.2 Аймаг/нийслэлийн болон сум/дүүргийн ИТХ-ын тогтоолын 1 дүгээр хавсралтаар зөвхөн аймгийн эсвэл сумын төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг батлах /сумын төсвийн суурь зарлага, суманд олгож байгаа орлогын шилжүүлэг санхүүгийн дэмжлэгийг оруулахгүй байх/;” гэж тусгасны дагуу аймгууд төсөв батлах болон түүнийг тайлагнах явцад сумдын төсөв, үр дүн ороогүй байна.</p> |

| | |
|---|--|
| | <p>Төсвийн төсөл боловсруулах үе шатаас эхлэн хөтөлбөрийн хүрэх үр дүнг төсвийн нэгэн адил анхан шатнаас буюу сумдын нэгжээс хүлээн авч нэгтгэхгүй байгаагаас шалтгаалан Аймгийн ИТХ-аар баталж байгаа хөтөлбөр, хүрэх үр дүн, төсвийн хэмжээ зөвхөн аймгийн түвшинд сумдын нөлөөлөл тусгахад цаг хугацаа хангалтгүй, харилцан уялдаагүй байдал үүсдэг. Тус тайланд Дорноговь аймгийн хөтөлбөрийн төсвийг хөтөлбөрийн үр дүнгийн тайланд нэгтгэхдээ аймгийн нэгдсэн дүнгээр засварлаж тооцсон. Иймд тухайн орон нутгийн төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хэмжээнд гарсан үр дүнг бүрэн илэрхийлэх зорилгоор цаашид хөтөлбөр, үр дүнг төлөвлөж, хуваарилах, тайлагнах, хяналт шинжилгээ хийх үе шатанд төсвийн ерөнхийлөн захирагчид хамаарах бүх төсөв, хөтөлбөрийг багтаах нь зүйтэй.</p> |
| <ul style="list-style-type: none"> Хөтөлбөр, үр дүнгийн тайлангийн суурь болон зорилтот түвшний мэдээлэл, үндэслэх эх сурвалж, аргачлал тодорхойгүй байгаас үр дүн зөрүүтэй гарах магадлалтай. | <p>Хөтөлбөр, хүрэх үр дүн болон шалгуур үзүүлэлтийг боловсруулж, төлөвлөх үе шатанд хагас жилээр тооцох боломжгүй төлөвлөж байгаагаас шалтгаалан хагас жилийн биелэлтийг бодитой үнэлэхэд хүндрэлтэй байна. Иймд хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт бүрийг тооцох аргачлал, эх сурвалжийг тодорхой болгох шаардлагатай болгож, хагас жилээр суурь болон зорилтот түвшнийг тооцох боломж бүрдэнэ.</p> |
| <ul style="list-style-type: none"> Төсвийн хөтөлбөр болон бодлогын баримт бичгийн хөтөлбөр, үр дүнгийн уялдаа хангалтгүй байгаагаас тайлагналд хөтөлбөр дутуу тайлагнагдаж байна. | <p>Дорноговь аймгийн 2024 оны батлагдсан төсөвт нийт 35 хөтөлбөрийн хүрээнд төсөв зарцуулагдсан боловч Аймгийн ИТХ-аар 29 хөтөлбөр батлагдсан байна. Үүнд эрүүл мэнд, нийгмийн тодорхой бүлэгт чиглэсэн хөтөлбөр, хүрээлэн буй орчин хөтөлбөрүүдэд төсвийн хөтөлбөрийг нэгтгэн нэг шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр төлөвлөсөн. Хөтөлбөрийг нэгтгэн, нэг үр дүнгээр үнэлж болох боловч нэгтгэсэн хөтөлбөрт хамаарах салбарын үр дүн орхигдох хандлага үүсэж байна. Жишээлбэл: Нийгмийн тодорхой бүлэгт чиглэсэн хөтөлбөрт 6 төсвийн хөтөлбөр багтсан бөгөөд үүний 5 хөтөлбөр нь бодлогын баримт бичигт туссан, тодорхой үр дүнтэй, ялгаатай салбарт хэрэгжиж байна. Иймд нэгдсэн хөтөлбөрийг бүгдийг ганц шалгуур үзүүлэлтээр хэмжих боломжгүй тул “хэрэгжүүлэх арга хэмжээний тоо” гэх мэт ерөнхий хэрэгжилтээр үнэлж байна. Иймд цаашид хөтөлбөрийг нэгтгэхдээ оновчтой байдлыг харгалзан үзэх нь зүйтэй.</p> |
| <ul style="list-style-type: none"> Хөтөлбөр, үр дүнгийн тайлангийн төлөвлөх, төсөвлөх, тайлагнах, хяналт шинжилгээ хийх үе шатанд боловсруулсан арга зүй, зөвлөх үйлчилгээ, | <p>Үр дүнд суурилсан төсвийн онол, арга зүйг сайжруулах, улсын болон орон нутгийн төсөвт нэвтрүүлэх чиглэлээр хийгдсэн сургалт, нөлөөлөл, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа хангалтгүй байгаа болон төрийн албан хаагчдын тогтворгүй байгаагаас шалтгаалан хөтөлбөр,</p> |

| | |
|--|---|
| <p>журмын танилцуулга, зөвлөх үйлчилгээний үр дүнг төсвийн ерөнхийлөн захирагчидын ашиглалт хангалтгүй байна.</p> | <p>Үр дүнгийн төлөвлөлт, тайлагналын явц шаардлага хангахгүй байна. Иймд хөтөлбөр, үр дүнгийн бүх үе шатанд баримтлах зарчим, эрх зүйн баримт бичиг болон цаашид нэвтрүүлэх цахим системийг бүх төсвийн захирагчийн холбогдох төрийн албан хаагчдыг чадавхжуулах, тогтмолжуулах талаар анхаарах шаардлагатай.</p> |
| <ul style="list-style-type: none"> Тайланг хариуцаж нэгж, албан хаагч тодорхойгүй байгаагаас шалтгаалан тайлан удаашралтай, эх сурвалж тодорхойгүй, хариуцлагагүй байдал үүсэж байна. | <p>Орон нутагт хөтөлбөр, үр дүнгийн тайлангийн хэрэгжилтэд хамаарах зарим төрийн албан хаагчидын ажлын чиг үүрэгт уг тайлантай холбоотой чиг үүрэг тусгагдаагүй нь тухайн албан хаагч уг тайланд ач холбогдол өгөхгүй байх, тайлан чанаргүй боловсруулагдах зэрэг асуудлууд гарч байна. Иймд улсын болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчид хөтөлбөр, үр дүнгийн тайлангийн ач холбогдлыг бүх шатанд түгээх, хариуцлагажуулах шаардлагатай.</p> |

ХАВСРАЛТ

Хүснэгт № 3 Дорноговь аймгийн 2024 оны эхний хагас жилийн хөтөлбөр, үр дүнгийн тайлан, хөтөлбөрөөр, сая төгрөгөөр

| Хөтөлбөрийн код | Хөтөлбөрийн нэр | Хөтөлбөрийн хүрэх үр дүн | Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2023 оны зорилтот түвшин | Төсвийн гүйцэтгэлийн % | Хүрэн түвшин | Х/Г-ний Гүйцэтгэлийн хувь | Мэдээллийн албан ёсны эх сурвалж | Оролцооны хувь | Хөтөлбөрийн гүйцэтгэл | Үр ашиг |
|-----------------|--|---|--|-------------|----------|--------------|--------------------------|------------------------|--------------|---------------------------|---|----------------|-----------------------|---------|
| 70105 | Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа | Иргэдийн төлөөлөгчидийн хурлын шийдвэр нь орон нутгийн хөгжлийг дэмжихэд чиглэнэ | ИТХ-ын шийдвэрийн хэрэгжилт | хувь | 2022 | 94.5 | 97.0 | 74% | 80.00 | 82.5% | Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан | 100.0% | 82.5% | 8.2% |
| 70709 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх | Гэмт хэргийг бууруулна. | Гэмт хэрэг, зөрчил | тоо | 2023 | 670 | 663 | 44% | 446.00 | 148.7% | Статитик мэдээ | 100.0% | 148.7% | 104.5% |
| 70106 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага | Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. | Иргэдийн сэтгэл ханамж | хувь | 2022 | 85.6 | 88.0 | 27% | 94.70 | 107.6% | Иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа | 100.0% | 107.6% | 80.8% |
| 70426 | Төрийн өмчийг хэрэгжүүлэх | Орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалт, хяналтыг сайжруулна. | Орон нутгийн өмчийн байгууллагын өмч хөрөнгийн ашиглалтын гэрээний хэрэгжилт | хувь | 2022 | 80.0 | 85.0 | 55% | 80.90 | 95.2% | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан | 100.0% | 95.2% | 40.4% |
| 70418 | Худалдан авах ажиллагаа | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын арга хэмжээний худалдан авах ажиллагааг бүрэн зохион байгуулна. | Төлөвлөгөөний хэрэгжилт | хувь | 2023 | 100.0 | 100.0 | 70% | 86.80 | 86.8% | Худалдан авах төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан | 100.0% | 86.8% | 16.7% |
| 70429 | Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдлийн удирдлага | Төсөв санхүүгийн сахилга бат хөрөнгийн үр | Илрүүлсэн зөрчил | сая.төг | 2022 | 627.7 | 450.0 | 70% | 161.20 | 35.8% | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан | 100.0% | 35.8% | -34.2% |

| | | | | | | | | | | | | | | |
|-------|---|---|---|------|------|-------|-------|-----|-----------|--------|---|--------|--------|--------|
| | | ашгийг дээшлүүлнэ. | | | | | | | | | | | | |
| 71411 | Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага | Байгаль орчны салбарын хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах | Зохион байгуулсан арга хэмжээ | тоо | 2023 | 24 | 30 | 59% | 10.00 | 33.3% | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан | 100.0% | 33.3% | -25.7% |
| 71413 | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | Байгаль орчны салбарын хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах | Зохион байгуулсан арга хэмжээ | | | 24 | 30 | 26% | 12.00 | 40.0% | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан | 100.0% | 40.0% | 14.4% |
| 71405 | Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт | Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтыг сайжруулна. | Тусгай хамгаалтанд авсан газрын хэмжээ | га | 2023 | 32.7 | 35 | 92% | 32.70 | 93.4% | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан | 100.0% | 93.4% | 1.2% |
| 71902 | Нийгмийн халамж | Зорилтот бүлгийг халамжийн үйлчилгээнд бүрэн хамруулна. | Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэд | тоо | 2022 | 134 | 296 | 25% | 516.00 | 174.3% | Статистик мэдээ | 100.0% | 174.3% | 149.7% |
| 71600 | Эрүүл мэнд | Хүн амын дундаж наслалтын хувийг нэмэгдүүлнэ. | Дундаж наслалт | нас | 2022 | 72.9 | 73 | 47% | 73.00 | 100.0% | Статистик мэдээ | 100.0% | 100.0% | 53.1% |
| 71701 | Биенийн тамир, спорт | Спортын төрлөөр хичээллэгсэдийн тоог нэмэгдүүлнэ. | Спортоор хичээллэгсэд | хүн | 2022 | 15000 | 16000 | 41% | 32,241.00 | 201.5% | Статистик мэдээ | 100.0% | 201.5% | 160.4% |
| 71702 | Соёл урлаг | Соёл урлагийг түгээн дэлгэрүүлнэ. | Иргэдэд хүргэсэн соёл урлагийн арга хэмжээ | тоо | 2022 | 125 | 150 | 33% | 98.00 | 65.3% | Статистик мэдээ | 100.0% | 65.3% | 32.4% |
| 71801 | Сургуулийн өмнөх боловсрол | Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх | СӨБ-н хамран сургалтын цэвэр жин | хувь | 2022 | 87.8 | 88.0 | 60% | 93.30 | 106.0% | Статистик мэдээ | 100.0% | 106.0% | 45.9% |

| | | | | | | | | | | | | | | |
|-------|---|---|--|------|------|--------|--------|-----|-----------|--------|---|--------|--------|--------|
| 71802 | Ерөнхий боловсрол | Сургалтын чанарыг сайжруулах | гүйцэтгэлийн хувь | хувь | 2022 | 43.5 | 44.0 | 83% | 69.80 | 158.6% | Статистик мэдээ | 100.0% | 158.6% | 75.7% |
| 71804 | Мэргэжлийн боловсрол | Мэргэжлийн боловсрол эзэмшигчдийн тоог нэмэгдүүлнэ. | Политехникийн коллежид суралцагчид | тоо | 2022 | 652 | 717 | 80% | 667.00 | 93.0% | Статистик мэдээ | 100.0% | 93.0% | 13.4% |
| 70801 | Мал аж ахуйг хөгжүүлэх | Малын гоц халдварт өвчнийг бууруулна | Вакцинд хамрагдсан мал | тоо | 2022 | 514500 | 780300 | 81% | 42,015.00 | 5.4% | Статистик мэдээ | 100.0% | 5.4% | -75.5% |
| 70708 | Гамшгаас хамгаалах | Гамшиг ослын эрсдлийг хохирол багатай даван туулна. | Гамшиг ослын бууралт | хувь | 2023 | 4.1 | 4.5 | 99% | 3.00 | 66.7% | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан | 100.0% | 66.7% | -32.1% |
| 72208 | Ахмад настны хөгжил, хамгаалал | Ахмад настны талаарх төрийн тодорхой чиг үүргийг гүйцэтгэж, ахмад настанд чиглэсэн арга хэмжээний тоог нэмэгдүүлнэ. | Ахмад настанд чиглэн зохион байгуулсан арга хэмжээ | тоо | 2022 | 28 | 30 | 43% | 36.00 | 120.0% | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан | 100.0% | 120.0% | 77.3% |
| 71101 | Автозам | Орон нутгийн авто зам, замын байгууламжийг нэмэгдүүлэн иргэдийн аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлнэ. | Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ | тоо | 2022 | 20 | 22 | 26% | 11.00 | 50.0% | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан | 100.0% | 50.0% | 24.1% |
| 70204 | Санхүүгийн зах зээлийн зохицуулалт | Махны эрэлт нийлүүлэлтэд тохирсон бодлого зохицуулалтаар хангана. | Нөөцийн махны хэмжээ | тн | 203 | 50 | 100 | | | 0.0% | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан | 100.0% | 0.0% | 0.0% |
| 72200 | Нийгмийн тодорхой бүлэгт чиглэлсэн хөтөлбөр | Эмэгтэйчүүд, залуучууд, гэр бүлийн хөгжлийн чиглэлээр сургалт, нөлөөллийн ажлыг нэмэгдүүлнэ. | Зохион байгуулсан арга хэмжээ | тоо | 2022 | 15 | 30 | 21% | 9.00 | 30.0% | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан | 100.0% | 30.0% | 8.7% |

| | | | | | | | | | | | | | | |
|-------|---------------------------------|---|---|------|------|------|-------|------|--------|-------|---|--------|-------|--------|
| 71403 | Ойжуулалт | Төв суурин газрын ногоон байгууламж, ойжуулалтын талбайг нэмэгдүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг бууруулна. | Тэрбум мод хөтөлбөрийн хэрэгжилт | хувь | 2023 | 86.0 | 90.0 | 66% | | 0.0% | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан | 100.0% | 0.0% | -65.9% |
| 70106 | Нээлттэй Дорноговь | Дорноговь аймагт шилжин суурьшигчдийг нэмэгдүүлнэ. | Шилжин ирсэн иргэд | тоо | 2022 | 499 | 7000 | 79% | 789.00 | 11.3% | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан | 100.0% | 11.3% | -68.1% |
| 72101 | Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих | Орон нутгийн бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжин хөгжүүлэх зорилтот хөтөлбөр хэрэгжүүлнэ. | Зорилтот хөтөлбөрийн хэрэгжилт | хувь | 2023 | - | 30.0 | 10% | 10.00 | 33.3% | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан | 100.0% | 33.3% | 23.8% |
| 70203 | Засгийн газрын өрийн үйлчилгээ | Гадаад зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан дээлдүүлсэн зээлийн өрийг барагдуулна. | Өр барагдуулалт | хувь | 2022 | 53.0 | 100.0 | 0% | - | 0.0% | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан | 100.0% | 0.0% | 0.0% |
| 71502 | Хот байгуулалт, тохижилт | Ард иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | тоо | 2023 | 41 | 56 | 73% | 16.00 | 28.6% | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан | 100.0% | 28.6% | -44.9% |
| 70602 | Хил хамгаалах | Хилийн халдашгүй дархан байдлыг хангахад дэмжлэг үзүүлнэ. | Хилийн цэргийн ангиудыг дэмжсэн ажил, арга хэмжээ | тоо | 2023 | 5 | 6 | 47% | 2.00 | 33.3% | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан | 100.0% | 33.3% | -13.7% |
| 70601 | Зэвсэгт хүчний үйл ажиллагаа | Харуул хоногийн манааны үүрэг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлнэ. | Зэвсэгт хүчний ангиудыг дэмжсэн ажил, арга хэмжээ | тоо | 2023 | 6 | 8 | 100% | 5.00 | 62.5% | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан | 100.0% | 62.5% | -37.3% |